

**БУРХАНЫ
ИЛГЭЭЛТ**

Бурханы адислалт
А.Ч. Бхактиведанта Свами Прабхупадын
НОМУУД

Монгол хэл дээр хэвлэгдсэн:

Шри Ишопанишад
Харь газар хөнгөн аялахуй
Бурханы илгээлт

Англи хэл дээр:

Bhagavad-Gita As it is
Shrimad-Bhagavatam (12 vols)
Sri Caitanya-caritamrita (17 vols)
Krisna, the Supreme Personality of Godhead
Teachings of Lord Caitanya
The Nectar of Devotion
The Nectar of Instruction
Sri Isopanisad
Easy Journey to Other Planets
Teachings of Lord Kapila, the Son of Devahuti
Teachings of Queen Kunti
The Science of Self-Realization
Perfect Questions, Perfect Answers
Life Comes from Life
The Path of Perfection
Beyond Birth and Death
Krisna Consciousness: The Topmost Yoga System
Krisna Consciousness: The Matchless Gift
The Perfection of Yoga
Krisna, the Reservoir of Pleasure
On the Way to Krisna
Raja-vidya: The King of Knowledge
Elevation to Krisna Consciousness
A Second Chance
The Journey of Self-Discovery
Back to Godhead magazine (founder)

“Бхактиведанта Бук Траст” хэвлэлийн газрыг Шри Шримад А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада Ведийн гүн ухаан болон соёлын ном сургаалуудыг хэвлэн гаргахаар үндэслэн байгуулсан бөгөөд одоо эдгээр номууд дэлхийн 75 хэл дээр орчуулагдан гарчээ.

Бурханы өршөөлт
А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада
Кришнын ухамсарын Олон улсын нийгэмлэгийг үндэслэн байгуулагч-ачарья

БУРХАНЫ ИЛГЭЭЛТ

THE BHAKTIVEDANTA BOOK TRUST

Message of Godhead (Mongolian)

Гарчиг

Өмнөх үг

...

1. Бурханлаг мэдлэг.....

2. Карма-йога бол бурханлаг үр дагавар авчрах үйл ажиллагаа.....

Өмнөх үг.

Орчин үеийн хүн нь өөрөө өөрийгөө, мөн өөрийн амьдарч байгаа орон зай гэсэн зөвхөн хоёр зүйлийг л сонирхож байдаг. Өөрөөр хэлбэл хүний сонирхол нь хоёр л салбар, хүрээг хамардаг. Нэг дэхэд нь бидний бүдүүн буюу физик болон нарийн биетэй холбоотой бүхэн, харин хоёр дахьд нь биднийг хүрээлэн байгаа ертөнц хийгээд түүний олон янз байдлууд хамаардаг. Гэхдээ, эгэл жирийн хүмүүсийн зэрэгцээ трансценденталистууд гэж нэрлэгддэг өөр хүмүүс байдаг. Тэдний сонирхол нь зөвхөн өөрсдийн бие махбодь, ухаан болон хүрээлэн байгаа дэлхий ертөнцийг хамаараад зогсохгүй бие махбодь, ухаан болон энэ ертөнцийн хязгаарын чанадад орших трансценденталь хүрээлэл тийш тэмүүлж байдаг. Трансценденталистууд нь Үнэмлэхүй Үнэнийг харьцангуй үнэнээс илүү ихээр сонирхдог.

Трансценденталистууд (Тэднийг ерөнхийдөө ариун гэгээнтэн, гүн ухаантан, шинэчлэн өөрчлөгч, Бурханы элч гэх зэргээр нэрлэдэг.) янз бүрийн цаг үеүдэд янз бүрийн орнуудад илэрч тодордог. Бурханлаг ертөнцийн илгээлтийг номлосноороо тэд Үнэмлэхүй Үнэнд болон бүх хүн төрөлхтөнд үйлчлэн зүтгэж байдаг. Трансценденталистуудын санаа бодлоор бол, өөрсдийн бие махбодь болон хүрээлэн буй дэлхий ертөнцөө сонирхох явдал нь зөвхөн хүнд төдийгүй мөн муур нохой мэт доод амьтдад хүртэл илэрч байдаг. Гэхдээ, хүн илүү дээд эрхэм зорилгуудад хүрэхээр тэмүүлж байх ёстой. Хүнээс өөр юу ч бурханлаг үнэнийг ойлгож ухаарах чадваргүй байдаг. Ийм учраас бүх оршнолуудаас хүнийг хамгийн хөгжингүй нь гэж үздэг бөгөөд энэхүү өндөр байр суурь нь бидэнд ямар үүрэг оногдуулж байдгийг ойлгох ёстой.

Бүтээгдсэн бүх оршнолуудын дээд нь болох хүн өөрийн ухамсарыг бүрнээ хөгжүүлсэн цагт зөвхөн өөрийгөө болон өөрийн амьдрах дэлхий ертөнцийг сонирхоод зогсохгүй Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарахыг чармайж эхэлдэг. Үнэмлэхүй Үнэн нь хэн бүхний үйлийг захиран залж, бүхий л ертөнцийн хувь заяаг шийдвэрлэж байдаг тул трансценденталист нь Үнэмлэхүй Үнэнийг таньж мэдсэнээрээ үйл ажиллагаагаа зөв чиглэлд явуулж эхэлдэг. Энэхүү чиглэлийг тодорхойлж байдаг дүрэм журам хийгээд хорио цээрийн системийг ерөнхийдөө шашин буюу шашны итгэл бишрэл гэж нэрлэдэг. Соёл иргэншил бүхий ертөнцийн аль ч хэсэгт шашины ямар нэгэн хэлбэр байдаг гэдгийг олж харж болох билээ. Хэрвээ хүн ямар ч шашин шүтлэггүй байх аваас түүнд амьтадаас илүү дээр гараад байх юм байхгүй. Янз бүрийн орны, янз бүрийн цаг хугацааны болон янз бүрийн ард түмнүүдийн шашингууд нь өөр хоорондоо ялгаатай байдаг хэдий ч тэд бүгдээрээ л Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарахад ямар нэгэн хэмжээгээр чиглэгдсэн байдаг.

Үнэмлэхүй Үнэн бол ганц, зөвхөн цор ганц байдаг ч янз бүрийн шашины хүмүүс буюу трансценденталистууд түүнийг янз бүрийн байдлаар ойлгож хүлээж авч байдаг. Үнэмлэхүй Үнэн гэдгийн доор зарим нь бараг бүгдээр бодьгал бус Брахман гэж нэрлэдэг ямар нэгэн ойлгож ухаарахын аргагүй хүч байдаг гэж ойлгож байхад өөр бусад нь түүнийг амьд оршнол бүрийн зүрхэнд залрах, Бурханы хаа сайгүй бүхэнд нэвчих төлөв Дээд Сүнс буюу Параматма байдлаар харж байдаг. Эдгээрээс гадна трансценденталистуудын өөр нэгэн чухал бүлэг байдаг бөгөөд тэд нар Үнэмлэхүй Үнэн гэж бодьгал бус төлөвт болон мөн бүхэнд нэвчин хаа сайгүй залрах чадвартай байдаг хийгээд тэгэхдээ Тэр л Үнэмлэхүй Бодьгал хэвээрээ байдаг Бурханы Үнэмлэхүй Бодьгалыг ойлгодог.

Эдүгээ цагийн нийгэм нь шашиныг өөрийн материаллаг сонирхлын золиос болгож байна. Хүмүүс одоо, бүр доод амьтад лугаа идэх, унтах, биеэ хамгаалах болон мэдрэхүйн таашаал ханамж эдлэх талын асуудалдаа л ихээр санаа зовох болжээ. Үндсэндээ, тэд бурханлаг сэдвээр ярилцахаас эсвэл ядахдаа тодорхой нарийн ойлголттой болохоос ч аль болохоор зайлсхийж байдаг. Өнөө цаг үед улс төрийн нэртэй томоохон зүтгэлтэнгүүдийн

амнаас өлсгөлөн хүмүүст Бурхан хэрэггүй, шашин ч хэрэггүй гэсэн үг сонсдох болжээ. Иймэрхүү материалистуудаар толгойлуулсан эгэл жирийн хүмүүс нь зөвхөн өөрсдийн материаллаг бие махбодь болон хүрээлэн байгаа орчлонгоос өөр юуг ч үл мэдэх хийгээд бурханлаг ойлгоцгүй болсон амьтдын түвшин тийш аажим аажмаар доройтон доошилдог.

Хүний нийгэм нь хөрш айлынхаа нохойг харангуутаа шууд л бие бие рүүгээ хуцалдах нохдын түвшинд хүртлээ уруудан доройтсон. Өөр итгэл бишрэлтэй эсвэл өөртэй нь шууд зэрэгцэн хамт амьдардаггүй бусад хүмүүст атаархан хэрүүл шуугиан гаргаж байдаг хүн өөрийгөө хир зэрэг доройтон унасныг төсөөлөхөд ч хүнд бэрх байдаг. Тэрээр өөрийнхөө өмнө бар эсвэл чоно гараад ирсэн юм шиг л хашгирч эхэлдэг. Хүн төрөлхтөн бурханлаг мэдлэгээ орхиж гээснээрээ үнэн хэрэгтээ барс эсвэл чонын сүрэг болон хувирсан хэрэг.

Иймээс, хэрвээ бид хүмүүст эргээд эрүүл саруул ухаан бодолтой болоосой гэж хүсэж байх аваас Үнэмлэхүй Үнэний талаар ямар нэгэн зүйлийг ч гэсэн мэдэх шаардлагатай. Нийгмийн оюунлаг удирдагчид нь өөрсдийн хүчин чармайлтаа зөвхөн хоол хүнс, унтаж хэвтэх, биеэ хамгаалах болон материаллаг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх нөхцлийг сайжруулах тал руу чиглүүлэх ёсгүй. Өлсгөлөн хүнд Бурхан, шашинтай хамаарах хэрэг явдал байхгүй гэж боддог эрх баригчдад дэлхий дахинд хүмүүс бурханлаг өлсгөлөнгөөс болж зовж шаналж байна, Бурхан гэж Хэн бэ? шашин гэж юу вэ? гэдэг тухай ойлгох явдал хүмүүст урьд өмнөхөөсөө ч илүү ихээр шаардлагатай болжээ гэдгийг цөхрөлтгүй, шаргуу тайлбарлах хэрэгтэй.

Үүнтэй холбогдуудан, Парист ЮНЕСКО-ийн сүүлчийн хуралдаан дээр доктор Радхакришнанагийн (Энэтхэгийн ерөнхий сайд асан) хэлсэн үгийн үндсэн санааг товчхон өгүүлье. Тэрээр: “Бурханаас бардам сайрхуу байдлаар нүүр буруулан, материаллаг хөгжил цэцэглэлтэнд хүрэхээр хүчин чармайлтай төвлөрүүлэн зангидаж байгаа үндэстэн өөрсдийгөө мөхөл сүйрэлд хүргэдэг. Өнөөдөр сургууль, номын сан, дэлгүүр болон үйлдвэрүүдийг хөгжүүлэх нь тийм ч чухал биш, харин хүнийг сэргээн хөгжүүлэх л илүү чухал байна. Хэрвээ бид шинээр дэлхийн хамтын нийгэмлэг байгуулахаар хуран цуглаж байгаа бол хүмүүсийг дахин шинээр хүмүүжүүлэх хэрэгтэй.” гэж хэлсэн.

Урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр доройтон байгаа хүн төрөлхтнийг сэргээн хөгжүүлэхийн тулд бид Бурхантай холбогдсон өөрсдийн харьцааны чухлыг ухаарах явдал онцгой шаардлагатай.

Учир зүйг судлаачид болон эмпирик-философичид нь амьд оршнолуудын Бурхантай холбогдсон мөнхийн холбоог өөрсдийн материаллаг мэдлэг хийгээд шинжлэх ухааны судалгаанууд дээрээ үндэслэсэн онол болоод янз бүрийн аргуудын тусламжтайгаар ойлгохыг чармайн оролдож байдаг. Гэсэн ч, боловсролтой байдаг хэдий ч иймэрхүү философичид нь Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарч чадахгүй. Төгс төгөлдөр бус байдаг материаллаг мэдрэхүйн эрхтэнгүүдийн мэдрэмж дээр түшиглэж тулгуурласан танин мэдэхүйн нэгтгэн дүгнэж ургуулан бодох (индуктив) арга нь Үнэмлэхүй Үнэний талаар тодорхой ойлголт төсөөллийг өгч чадахгүй. Эзэмшсэн мэдлэгээрээ бардамнах учир зүйг судлагчид болон эмпирик-философичид нь өөрсдийн төгс төгөлдөр бус байдлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдаг учраас эцэстээ тэд бурхангүйн үзэлтэн болж юутай ч эгнэшгүй Бурханы Дээд Бодьгалын оршнолыг үгүйсгэж эхэлдэг. Иймэрхүү эргэлзээтэй, бурхангүй үзэлт үзэл бодолд автсанаар хүмүүс мунхагийн харанхуйд уусан хоцордог. Тэд Үнэмлэхүй Үнэний талаар хэн нэгний санаанаасаа зохиосон үзэл санаанд сэтгэл ханамжтай байх ба Бурхантай холбогдсон өөрсдийн жинхэнэ харьцаа холбоог ойлгодоггүй.

Трансценденталистууд нь танин мэдэхүйн нэгтгэн дүгнэж ургуулах аргыг хүлээн зөвшөөрдөггүй. Ямар нэгэн зүйлийг өөрсдийн мэдрэхүйн эрхтэнгүүдийн тусламжтайгаар ойлгох оролдлого хийхийг үл хэрэгсэн орхиж, оршин байгаа бүхнийг ойлгохын тулд тэд трансценденталь мэдлэгт тайлагдан нээгдсэн хүнд ханддаг. Энэ мэдлэг нь хүний зүрхний

гүнд нээгддэг болой. Бурханы Дээд Бодьгалын болон Бурхантай холбогдсон бидний харилцааны тухай жинхэнэ мэдлэгийг зөвхөн трансценденталь замаар л хүртэж болдог. Бурхан үнэмлэхүй учраас материаллаг ухаан бодолтой хүмүүст харагдаж үзэгдэхгүй байх эрхийг Өөртөө үлдээсэн хэрэг. Түүнийг ойлгож ухаарах, Түүнд хүрэхийг зөвшөөрдөг зөвхөн ганц, үнэмлэхүй арга байдаг бөгөөд мэдрэхүйн ойлгоц дээр үндэслэгдсэн танин мэдэхүйн харьцангуй арга бол энд ямар ч хэрэггүй, ач тусгүй юм. Бидний харьцангуй мэдрэхүйн ойлгоцоор Бурханд хүрч, Түүнийг ойлгож ухаарч болно гэж үзвэл үнэмлэхүй мөн чанарыг Бурхан биш харин бидний мэдрэхүй агуулдаг гэсэн үг болно. Гэвч үнэн хэрэгтээ, мэдрэхүйн ойлгоцын нэг ч хэлбэр бидэнд Бурханы талаархи мэдлэгийг өгч чадахгүй.

Бид өөрсдийн хомсхон мэдлэгийн тусламжтайгаар Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарч чадахгүй, гэхдээ Үнэмлэхүй Үнэн энэхүү ертөнцөд Өөрөө морилон бууж ирэн Бидэнд Өөрийгөө өршөөнгүйгээр нээдэг билээ. Орчин үеийн шинжлэх ухааны ямар ч амжилт ололт шөнийн тэнгэрт нарыг мандуулж чадахгүй. Харин өглөө болоход нар өөрөө бидний ямар ч чармайлт, оролцоогүйгээр мандан гийдэг. Нар мандмагц шөнийн харанхуй тэр дороо л сарнин алга болдог. Үүнтэй нэгэн адил, Бурханы Дээд Бодьгал болон Түүний ойр дотнын бараа бологчид, албатууд нь хэний ч туслалцаагүйгээр материаллаг ертөнцөд өөрсдөө морилон залардаг. Тэд өөрсдийн тайлахын аргагүй өршөөл нигүүлслийн улмаас наашаа зөвхөн, материаллаг мөн чанарын гурван *гуна* гэж нэршсэн Бурханы материаллаг эрчмийн нөлөөн доор хий хуурмагт автах дур сонирхолтой уналтанд өртсөн сүнснүүдэд өмөг болон хайр хишгээ хүртээхээр морилон ирдэг.

Нар мандах үед бид бүх цонх, хаалгаа хаан битүүлэх аваас нарны туяа бидний харанхуй өрөөнд нэвтрэн орж ирж чадахгүй. Иймээс, Бүхний Дээд Бурхан эсвэл Түүний ойр дотнын албатууд трансценденталь илгээлтийг номлохоор морилон ирэх үед бид өөрсдийн зүрхний хаалга, цонхуудыг хаах ёсгүй билээ. Эс тэгэх аваас Бурханы эсвэл Түүний албатаас цацран гийгүүлж байгаа гэрэл биднийг хэзээ ч гэрэлтүүлж гийгүүлэхгүй. Энэхүү онцгой, бурханлаг гэрлийг энгүүндээ сонсголоороо хүлээж авдаг. Бид Бурханыг болон Түүнтэй холбогдсон өөрсдийн харилцааг Түүний илгээлтийг хүлцэнгүйгээр анхаарсан тохиолдолд л үнэхээрийн таньж мэдэж чадах болно. Нийгэмд бүхэлд нь, түүний дотор ялангуяа үнэнийг жинхэнээр хайгчдад ач тусыг хүртээх "Бурханы илгээлт" гэсэн энэ ном чухамхүү ийм л трансценденталь санаа зорилгыг агуулсан болно. Бурханы илгээлтийг хүмүүст таниулах гэсэн энэхүү хир тааруу барагтайхан оролдлого минь хир зэрэг амжилттай болохыг би мэдэхгүй байна. Миний энэ ажил дахь төгс бус байдал, алдаа дутагдлыг уучлан хэлтрүүлэхийг уншигч та бүхнээсээ хүсье.

Зохиогч.

Нэг. БУРХАНЛАГ МЭДЛЭГ

Би, уналт доройтолд орсон сүнснүүдийг авчрагч, бүхнийг өршөөн нигүүлсэгч номын багш Шрила Бхактисиддханта Сарасвати Госвами Прабхупадад чин зүрхнээсээ, гүн хүлцэнгүйгээр бишрэл хүндэтгэлээ илэрхийлье. Тэрээр, хэн бүхэнд ач тус авчран хүртээх трансценденталь мэдлэгийн бамбараар мунхагийн харанхуйг үлдэн хөөж миний нүдийг нээсэн билээ.

Бид өөрсдийн жижигхэн хоёр нүдээрээ маш ихээр бахархан бардамнаж, тэдний тусламжтайгаар хүссэн бүхнээ харж чадна гэж бодоцгоодог. Гэхдээ бид харж байгаа бүхнээ мунхагийн харанхуйд бүрхэгдсэн байдаг гэдгийг ойлгож ухаардаггүй. Иймээс бид нэг бол бодит байдлын гажуудсан хэлбэрийг эсвэл түүний нэгээхэн хэсгийг л харж байдаг. Зүгээр л ширтсэнээрээ аливаа зүйлийг байгаа байдлаар нь харж болно гэж бодож байгаа хүн төөрөгдөл самууралд гүнээ орсон хэрэг. Нар бол тэнгэрийн маш том биет, эрхэс бөгөөд өглөө бүр дорно зүгээс мандан гийх үедээ бидэнд том биш гэрэлтэгч дугуй шиг л харагддаг. Гэхдээ нар бол дэлхийгээс маш олон дахин том гэдгийг хэн бүхэн мэдэх билээ. Иймд өөрсөддөө итгэлтэйгээр бардамнан бахархаж байдаг бидний нөгөө хараа маань биднийг өглөө бүр л ямар ч тус нэмэргүй, ийм нөхцөл байдалд оруулж байдаг байна. Бидний нүд мэдээллийг зөвхөн зохистой, таарч тохирсон нөхцөлд л хүлээн авах чадвартай байдаг. Бид өөрсдөөсөө хэтэрхий хол эсвэл хэт ойр орших зүйлийг харах чадваргүй. Жишээ нь, бид аньсага, зовхио харж чаддаггүй. Яг үүнтэй адилаар бид харанхуйд ямар нэгэн зүйлийг ялган харж чаддаггүй билээ. Иймээс бидэнд өөрсдийнхөө хараагаар, материаллаг мөн чанар бидэнд зориулан зохистой нөхцөл байдлыг бүрдүүлж өгсөн зөвхөн тэр үед л бахархан бардамнах үлдэж байх шиг байна. Тийм нөхцөл бүрдээгүй цагт хараа маань хичнээн хурц сайн байгаад ч бид бүхэн юмсыг жинхэнэ байгаагаар нь харж чадахгүй билээ. Нүдэнд хамааралтай энэ бүхнийг бид мэдлэг хүртэхдээ ашиглаж хэрэглэж байдаг мэдрэхүйн бусад эрхтэнгүүдэд ч мөн хамаатуулж болно.

Иймд хүрээлэн байгаа орчин, дэлхий ертөнцийн талаарх бидний ойлгоц нь гадаад нөхцөл байдлаас бүрнээ хамаарах учраас энэхүү ойлгоц нь алдаа дутагдалтай бөгөөд төгс төгөлдөр биш гэдэг нь илт байна. Алдаа дутагдалтай энэхүү байдлыг алдаа гаргагч тэр өөрөө ч, мөн иймэрхүү алдаа дутагдал гаргамтгай өөр хэн нэгэн ч засаж, залруулж чадахгүй.

Хэрвээ бид харанхуйд ямар нэгэн зүйлийг судалж шинжлэхийг хүсэн оролдох аваас бидний хараа бидэнд ямар ч тус нэмэр болохгүй, бид мэдээлэл хүлээн авах өөр аргуудыг ашиглах шаардлагатай болно. Энэ нь бид өөрсдийн сонирхон авч үзэж буй зүйлээ бүрнээ судалж шинжилж чаддаггүй гэдгийг харуулж байна. Тэр ч бүү хэл, бид тэмтэрч хүртэхүйн тусламжтайгаар тухайн зүйлийн талаар ямар нэгэн зүйл мэдсэн байлаа ч энэ нь нэг бол буруу эсвэл бүрэн бус байдаг. Энэ байдал нь заантай анх удаа тулгаран энэхүү оньсого таавар мэт амьтныг бие биедээ тодорхойлон хэлэхийг оролдож байгаа сохор хүмүүсийн түүхийг санагдуулам. Зааны сүүлнээс барьсан тэдний нэг нь: “Хүүе энэ чинь аврага том могой байна.” гэж хэлдэг. Харин, зааны хөлийг тэвэрч үзсэн нөгөө нэг нь: “Үгүй ээ, энэ чинь том багана л байна шүү дээ.” ... гэх мэтчилэнгээр хэлдэг.

Пад харанхуйд ямар нэгэн зүйлийг харах боломж олгодог зөвхөн ганц л арга байдаг. Хэн нэгэн нь гэрэл асаасан цагт л бид хүрээлэн байгаа орчин тойрноо байгаа төрх байдлаар нь харж чадах болно. Үүнтэй нэгэн адилаар, биднийг мэдлэгийн гэрлээр гэрэлтүүлэн гийгүүлэх манай номлогчдын өршөөл нигүүлслээр л бид үнэнийг харж чадах болно. Бид төрсөн цагаасаа л эхлэн эцэг, эх эсвэл багш зэрэг өөрсдийн номлогч сургагч болох хүмүүсээс мэдлэг хүртэхээр тэдэнд хандаж заншсан билээ. Тэднийг хүлцэнгүйгээр

сонссоноор л, зөвхөн тэдний тусламжтайгаар л туршлагатай болж мэдлэгийн замаар урагшилж чадах юм.

Манай багш нар биднийг бага сургуульд байхаас эхлэн дээд сургууль төгстөл эрдэм мэдлэгийн замаар хөтлөн байдаг билээ. Харин бид бүр цаашаа, бурханлаг мэдлэг хүртэхээр явахыг хүсвэл биднийг энэхүү харгуй замаар удирдан дагуулах чадвартай, нэр хүнд бүхий бурханлаг номын багшид хандах хэрэгтэй. Дунд болон дээд сургуулиудад олж авсан бидний мэдлэг нь одоогийн амьдралд л ямар нэгэн зүйлийг үзэж судлахад тус болж магадгүй ч энэхүү боловсрол нь бидний цагаас цагт, өдрөөс өдөрт, амьдралаас амьдралд тэмүүлэн байдаг бурханлаг мэдлэгийн мөнхийн шаардлагыг хангаж чадахгүй.

Хүн ямар нэгэн салбарт амжилтанд хүрэхийн тулд тухайн мэргэжлийн багштай танилцаж, түүний тусламж дэмжлэгийг авч, удирдлаган доор нь суралцах шаардлагатай байдаг. Хэрвээ хүн аль нэгэн дээд сургуульд эрдмийн зэрэг цол хамгаалахыг хүсэж байвал эхлээд энэ сургуультай тодорхой холбоо харилцаа тогтоох хэрэгтэй болдог. Дараа нь тэрээр багш нарын зааврыг даган баримталж, тэдний удирдлагын доор ажиллан сайшаалыг нь хүртэх ёстой байдаг. Энэ бүхэн нь хүссэн зорилгодоо хүрэхэд зайлшгүй шаардлагатай зүйлс. Яг үүнтэй адил, хэрвээ бид мөнхийн амьдралын зарчмуудын талаар мэдэхийг болон бүх зүйлсийг жинхэнэ байдлаар нь харахад суралцахыг хүсэх аваас бидний нүдийг нээх хийгээд биднийг мунхагийн эргүүлгээс мултлан гаргах үнэхээрийн чадвартай багштай холбоо харилцаа тогтоох ёстой. Номын багшид хандах арга нь зөрчиж, өөрчилшгүй хууль бөлгөө. Энэхүү мөнхий дүрэм журмыг хэн ч хүчингүй болгож, цуцалж чадахгүй.

Номын багштай трансценденталь холбоо харьцаа тогтоосноор бидний бурханлаг сахил эхэлдэг. Упанишадууд болон түүнтэй адил бусад шастируудад өгүүлсэнчлэн, бурханлаг шинжлэх ухааныг төгс төгөлдөр байдлаар хүртсэн хийгээд бүх судар шастируудыг нэвтэрхий сайн мэдэх номын багшийн өлмийд бишрэлтэйгээр хийгээд хүндэтгэлтэйгээр ойртон дотносох хэрэгтэй. Энэхүү шинжлэх ухааныг төгс төгөлдөр ойлгож ухаарахын тулд номын багшийн хэлхээ сүлжээнд нэгдэн нийлж, тэдний бурханлаг зам мөрийг даган баримталж, тэдний соёлыг эзэмшин, тэднээс суралцах шаардлагатай юм. Янз бүрийн бурханлаг байгууллагууд болон нийгэмлэгүүдийн мэргэшсэн удирдагчид нь ийм төгс төгөлдөр байдлаас хол төсөө хийгээд номын багшийн агуулж байх ёстой шинж чанаргүй байдаг нь нилээд харагддаг. Иймээс, иймэрхүү багш, номлогчдод зөвхөн ёс төдийг сахин биелүүлэх эсвэл заншил хэвшил болсон алба хүндлэлийг үзүүлэхийн төлөө хандах нь ямар ч утгагүй хэрэг. Бурханлаг сургалтыг туулаагүй хэн бүхний хувьд бурханлаг төгс төгөлдөр нь хүршгүй байдаг юм.

Бурханы Дээд Бодьгал хийгээд төгс төгөлдөр номын багш Шри Кришна нь Өөрийн шавь, дайчин баатар Аржунад Бхагавад Гитагийн гүн ухааныг айлдан номлосон. Кришна Аржуна хоёрын харьцаа нь номын багш болон шавь хоёрын харьцаа ямар байх ёстойн хамгийн шилдэг үлгэр жишээ болно. Аржуна нь Шри Кришнагийн хамгийн ойр дотнын анд нөхөр байсан учраас Шри Кришна түүнд Бхагавад Гитаг айлдан бүх шастируудын утга учрыг тайлан нээж өгсөн. Бид өөрсдийн материаллаг үүргээ биелүүлэх үйлэнд л автсан байдаг учраас ходоод хийгээд түүнтэй холбогдсон бүгдэд хамаарах материаллаг философиос өөр ямар ч философийг ерөнхийдөө үл сонирхцгоодог. Ходоодоо хэрхэн дүүргэх талаар олон тооны сургаал номлолыг бий болгосон болохоор одоо бидэнд, нэг бие махбодио нөгөөгөөр солингоо, өнө эртийн цагаас эрмэлзэн тэмүүлж байсан амьдрал-мөнхийн амьдралд хүргэх философид зориулах цаг хугацаа байдаггүй.

Кришна Аржунагийн байлдааны тэргийг Курукшетрын талбар дээр тулалдахын өмнө эгнэн жагссан байсан хоёр талын цэргийн хүчний дунд байрлуулсан байх үед Аржуна мунхаглал хийгээд сул дорой байдалд дийлдсэн эгэл жирийн хүн лугаа байдал гаргаж тулалдахаас татгалздаг. Гэсэн ч Кришна түүнд Бхагавад Гитаг айлдан, түүнийг гэгээрүүлдэг. Ийнхүү, Бурханы Дээд Бодьгал хийгээд Түүнийг хүрээлэх итгэлт чин

бишрэлтэнгүүд нь цаг үеэс цаг үед энэ ертөнцийн хүмүүст, тэднийг бүрхсэн мунхагийн харанхуйг сарниулан арилгаснаар өөрсдийн хэмжээлшгүй өршөөл ивээлийг хайрлан хүртээж байдаг. Энэхүү өршөөл ивээл байдаггүйсэн бол бид бурханлаг мэдлэгийг хэзээ ч хүртэхгүй байхсан билээ.

Зарим үед Бурханы Дээд Бодьгал Өөрөө газар дэлхий дээр морилон бууж ирэн хүмүүст бурханлаг мэдлэгийг хүртээдэг бол заримдаа Тэрээр энэхүү ач тустай үйл хэргийг Өөрийн итгэлт чин бишрэлтэнгүүддээ даалгадаг. Бурханлаг орноос трансценденталь илгээлтийг номлохоор өнгөрсөн үед морилон бууж ирсэн хийгээд мөн ирээдүйд морилон бууж ирэх ариун гэгээнтэнгүүд нь Бүхний Дээд Бурханы хамгийн эрхэм албатууд байдаг. Ийсус Христос Бурханы хүү байдлаар, Магомет- Түүний албат байдлаар, харин Бурхан Чайтанья Түүний чин бишрэлтэнгийн дүрээр морилон ирсэн билээ. Гэхдээ, эдгээр ариун гэгээнтэнгүүд нь хэний ч дүрээр ирсэн байсан, бүгдээрээ л энэхүү мөнх бусын ертөнцөд аз жаргал хийгээд хөгжил цэцэглэлтэнд хүрэх боломжгүй юм гэсэн адил байр суурьтай байдаг. Тэд бүгдээрээ аз жаргал болон хөгжил цэцэглэлт биднийг хүлээж байдаг өөр ертөнцийн тухай ярьцгаасан билээ. Мөнх бусын энэ ертөнцийн хүрээ хязгаарын чанадад орших Бурханы орон дахь мөнхийн аз жаргалдаа хүрэхээр бид тэмүүлэх ёстой. Тэр ч бүү хэл, Бурханы бодьгал мөн чанарыг үгүйсгэгч Бурхан Будда болон Шанкарачарья зэрэг гэгээнтэнгүүд хийгээд шинэчлэн өөрчлөгч нар нь материаллаг ертөнцөд мөнхийн аз жаргал болон хөгжил цэцэглэлтийг олж хүрч болно гэж хэзээ ч сургаж номлоогүй билээ.

Орчин үеийн нийгмийн үзэл сурталчид нь ихэнх эгэл жирийн хүмүүсийн адилаар өөрсдөө төөрөлдөж самууран, бидний оршин буй энэ ертөнцөөс өөр ямар ч бодит байдал гэж байдаггүй, энэ л ертөнцдөө оршсоноор бид аз жаргал хийгээд хөгжил цэцэглэлтийн хойноос тэмүүлэх өөрсдийн эрмэлзлээ дүүрэн хангаж болно гэж үздэг. Ийм хүмүүсийн үгээр бол, материаллаг бие махбодь нь бидний жинхэнэ “Би”, бие махбодьтой холбоотой бүхнийг судлах нь өөрийгөө ухаарахуй юм, мөн бидний үндсэн үүрэг бол мэдрэхүүдээ таашаал ханамж эдлүүлэх болон өөрийн бие махбодио бүхий л боломжит арга хэрэгслээр тогтоон барьж, тэжээн тэтгэхэд оршдог ажээ. Нийгмийн удирдагчид нь Бурханыг философийн замаар ойлгож ухаархыг зугаацал эсвэл ухааны чадваруудаа хөгжүүлэх дасгалуудаас илүү өөр зүйл биш юм гэж үздэг. Гэхдээ, иймэрхүү үзэл бодол, ятгалга сэнхрүүлэг нь нь нийгэмд ямар ч мэдрэгдэхүйц ач тус авчирдаггүй.

Тэгэхлээр Аржуна нь төөрөгдөл самууралд орсон эгэл жирийн хүн адил дүр үзүүлэн оюун санаа, эр зоригийн сул дорой байдал гаргаж байна. Аржунагийн энэхүү үйлдлийн ач тусаар л Бхагавад Гита нь Бурханы Дээд Бодьгалын амнаас айлдагдан гарсан бөлгөө. Бурханыг энэхүү ертөнцөд морилоход итгэлтэй бараа бологчид нь Түүнийг үргэлж дагалддаг. Аржуна бол Бурханы Дээд Бодьгал Шри Кришнагийн мөнхийн итгэмжит албатуудын тоонд ордог бөгөөд Бурхан бүхий л хүмүүст ач тус хүртээх л гэж Бхагавад Гитаг Аржунад айлдсан билээ.

Аржуна Бурханы Дээд Бодьгалын цэвэр чин бишрэлтэн байсан учраас Бхагавад Гитагийн трансценденталь гүн ухааныг тулалдааны талбар дээр хүртэл хэлэлцэж чадаж байна. Тэгэхэд, үүнээс ч бүр энгийн, өдөр тутмын үйл эрхлэн байгаа өнөөгийн цаг үеийн хүмүүс бидэнд энэ талаар ярих цаг зав ч гардаггүй. Гэсэн ч Аржуна бид бүхэнд үлгэр жишээ үзүүлэн сургамж болохыг хүсэн, тунгааж бодоход ямар ч цаг хугацаа байхгүй тийм нөхцөл байдалд Бхагавад Гитаг ойлгохыг чармайсан билээ. Тэрээр үүнийг бидний ач тусын төлөө л хийсэн. Бхагавад Гитагийн гүн ухааныг ойлгосноор Аржуна тулаанд шийдвэр төгс орсон.

Өнөө цаг үеийн эгэл жирийн хүн адил төрөл төрөгсөдөө татагдан байгаа Аржунагийн байдал нь бурханлаг мэдлэгээр хомс байгаагийн шинж тэмдэг. Гэхдээ, бурханлаг мэдлэгийг хүртсэнээрээ материаллаг үүргээ биелүүлэхээс татгалзах ёстой гэж үргэлж ойлгож болохгүй. Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Аржунад Бхагавад Гитагийн номлолыг тайлбарлахдаа түүнд өөрт оноогдсон үүргүүдээсээ татгалзах ёстой

гэж огтхон ч зөвлөөгүй билээ. Харин ч эсрэгээр, Шри Кришнагийн өршөөл нигүүлслээр бурханлаг мэдлэгийг хүртсэнээрээ Аржуна бүр ч илүү эрс шийдэмгийгээр тулалдаж эхэлсэн билээ. Жинхэнэ бурханлаг мэдлэгийг хүртсэн цагт бидний дотор Бурханы Дээд Бодьгалыг хэлбэрэлт гуйвалтгүй чин бишрэх байдал болон Түүний трансценденталь албанд зүтгэх халуун эрмэлзэл сэргэдэг. Бхагавад Гитагийн учир утга зөвхөн үүнд л оршдог.

Ойртон байгаа тулаантай холбогдсон асуудлуудыг өөрөө бие даан шийдвэрлэх чадваргүйгээ ойлгомогц Аржуна Шри Кришнагийн ачлал ивээлд өөрийгөө машинд хүлцэнгүйгээр даатган Түүний шавь нь болсон. Энэ хүртлээ Аржуна Кришнатай өөрийн найз нөхөр мэтээр харьцаж байсан. Гэхдээ найз нөхрийн яриа нь ямар ч ач тусыг үл авчрах маргалдаанд олонтоо хүргэдэг. Иймээс Аржуна Шри Кришнагийн шавь нь болохоор шийдсэн. Шавь нь өөрийн номын багшийнхаа үгнээс зөрж болдоггүй билээ. Үүнд л багш шавийн харилцааны учир утга оршдог.

Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Аржунад Бхагавад Гитагийн эрхэм нандин номлолыг, тэр Түүнд хэлбэрэлт гуйвалтгүйгээр чин биширч байгааг болон өөрийн мэдлэгээрээ бардамнахгүй гэдгийг харсаны дараа л нээн хүртээсэн. Бид, Кришнад өөрийгөө хараахан даатгаагүй байгаа Аржуна шиг л асуудлуудаа төгс төгөлдөр бус амьдралынхаа туршлага дээр үндэслэж тулгуурлан өөрсдийнхөө хүчээр шийдвэрлэх гэж оролдож чармайж байдаг. Гэсэн ч эдгээр чармайлт, оролдлогууд нь биднийг байнгад нөмрөн бүрхэх ухаан бодлын болон бие махбодийн тайван бус байдлаас үл ангижруулдаг бөгөөд энэ нь хүчээ хий дэмий үрсэн хэрэг болон үлддэг. Хүн өөрийн асуудлуудаа мөнхийн амьдралын байр сууринаас харан шийдвэрлэхийг хүсээгүй цагт энэ амьдралдаа ч тэр, дараагийн амьдралдаа ч тэр аз жаргалд хүрэхгүй. Бхагавад Гитагийн эрхэм дээд номлол сургаалын учир утга ийм байдаг бөлгөө.

Материаллаг бие махбодь болон ухааны хүслээс дээш тэдгээрийн чанадад орших бурханлаг мэдлэг бидэнд туйлын чухал шаардлагатай. Өөрийн үйл ажиллагааг энэхүү трансценденталь түвшинд явуулаагүй цагт жинхэнэ тайван амгаланд хүрнэ гэдэг боломжгүй хэрэг. Бурханлаг буюу трансценденталь түвшин- энэ бол мөнхийн амьдралын түвшин бөгөөд энэхүү мөнхийн амьдралгүйгээр материаллаг бие махбодь болон ухаан оршин байж чадахгүй. Хэдийгээр тийм байдаг ч, бид мөнхийн амьдрал гэж юу болох талаар ойлголтгүй байдаг хирнээ өөрсдийн материаллаг мэдлэгээр маш ихээр бахархан бардамнаж байдаг. Өнөө цаг үеийн бид өөрсдийгөө мөнхийн сүнсийг бүрхэн хучиж байдаг гадаад бүрхүүлд хамааралтай материаллаг ойлголттой их бага ямар нэгэн хэмжээгээр адилтган үзэж байдаг. Энэхүү гадаад ойлголт ухагдахуунтай өөрсдийгөө буруу, хуурмаг байдлаар адилтган үзсэнээсээ болж бид хэрүүл маргаантай болон мөргөлдөөн сөргөлдөөнтэй янз бүрийн хэрэг явдалтай холбогдон орооцолддог. Өөрийгөө адилтган үзэхүйн энэ бүх хэлбэрүүдээс салан ангижирч өөрийн жинхэнэ мөн чанарт хүрсэн цагт л жинхэнэ аз жаргал болон амар амгалангийн талаархи бидний мөрөөдөл биелэгдэх болно. Бурханлаг буюу трансценденталь түвшингөөс хол төсөө *махатма* гэж нэрлэгдэх хүмүүс, төрийн сод гарамгай зүтгэлтэнгүүд болон нэр хүндтэй эрдэмтэдээс тус дэм эрэн материаллаг амьдралаа хөнгөрүүлэх гэсэн зүтгэл чармайлт л биднийг бие махбодь болон ухааны өөрийгөө буруу, хуурмагаар адилтган үзэхүйн эрээн мяраан гоёмсог “хувцас”-аар ороон хучдаг. Бхагавад Гитад, Кришна иймэрхүү зүтгэл чармайлт, оролдлогууд нь үргэлж амжилтгүй болж байдаг гэж анхааруулан сануулсан байдаг.

Өөрт тулгарсан хүндрэл бэрхшээлтэй байдлыг даван гарах хүч, чадваргүй байсан Аржунаг Кришнагийн шавь болон Түүнийг өөрийн номын багшаа болгох үед Тэрээр: “Аржуна минь ээ, чи хэдийгээр гүн гүнзгий утга санаа бүхий үгүүдийг хэлж ярьж байгаа ч гэсэн жинхэнэ мэргэдэд харамсал үл төрүүлэх зүйлд харамсаад байгаа учир мэдлэг чинь тийм ч өндөр бус байна гэдэг нь илт.” гэж айлдан түүнийг зэмлэдэг.

Цэцэд мэргэд нь нэгэн удаа илрэн тодорсоноо цаг хугацааны явцад үгүй болдог зүйлсийн талаар хэзээ ч эмгэнэн гашууддаггүй. Эхийн хэвлийгээс төрдөг бидний бие махбодь нь эрт орой хэзээ нэгэн цагт шарил, чандар, шороо эсвэл ялгадас болон хувирдаг. Үүнтэй нэгэн адил хуурамч эго, оюун ухаан болон ухаанаас бүрдэх нарийн материаллаг бие махбодь нь сүнсний ангижралд хүрэх үед мөн л эвдрэн сүйрдэг. Энэ л учраас, жинхэнэ мэдлэгийг хүртсэн хэн бүхэн материаллаг бие махбодь болон ухаан, мөн тэдэнтэй холбогдсон жаргал зовлонд их ач холбогдол өгдөггүй.

Нөгөө талаас, ийм цэцэд мэргэд нь бие махбодь болон ухааны түвшингөөс ойлгож хүрэхийн аргагүй бөгөөд бурханлаг мөн чанартай байдаг өөрийн сүнсний эдэлж байгаа жаргал болоод зовлонд онцгой анхаарал хандуулдаг. Сүнсний талаархи ийм мэдлэгийг агуулж байх хүнийг бурханлаг буюу трансценденталь мэдлэгийг хүртжээ гэж ярьдаг. Аржуна зөвхөн үгширмэл ужиг тэнэг мунхаг-материалист биднийг гэгээрүүлэх гэж л ямар ч бурханлаг мэдлэггүй, ухвар мөчид материалист байдалд өөрийгөө оруулсан хэрэг. Бурхан энэ дүрд Аржунаг өөр хэн бүхнээс илүү зохицоно гэж үзсэн учраас Өөрийн зүгээс түүнд Бхагавад Гитаг айлдсан.

Бенгалийн засгийн газрын ерөнхий сайд Набаба Хусейна-Шаха-Сакар Маллик (Хожим нь тэрээр Бурхан Чайтаньягийн гол шавь нарын нэг болон Санатана Госвами гэж алдаршсан.) Бенаресад Чайтанья Махапрабхутай учран золгохдоо өөрийгөө, Аржунатай адилаар мөн л тэнэг мунхаг-материалист гэж нэрлэсэн. Бурхан Чайтаньяд хандан тэрээр айлтгахдаа: “Бурханлаг мэдлэггүй эгэл жирийн хүмүүс намайг улс төрийн сод гарамгай зүтгэлтэн, аугаа эрдэмтэн, *махатма*, эсвэл *парамахамса* гэж нэрлэдэг. Гэхдээ иймэрхүү нэр алдар надад нийцэж зохицож байгаа гэдэгт би итгэлтэй бус байна. Үнэн хэрэгтээ, эдгээр хүмүүс намайг, надад тохирч нийцэхгүй байдлаар нэрлэж байгаа нь шууд бус байдлаар басамжлан байгаа хэрэг гэж би бодож байна. Би өөрийнхөө тухай ч, өөрийн жинхэнэ мөн чанарын талаар ч юу ч үл мэдэх билээ. Гэвч эдгээр ухвар мөчид материалистууд намайг эрдэм мэдлэгтэй л гэж магтаж алдаршуулж байна. Тэд зүгээр л намайг шоолж инээж, мөн басамжилж байгаа нь эргэлзээгүй хэрэг.”

Шрила Санатана Госвами өөрийн байр суурийг ингэж тодорхойлсон байдаг. Үнэн хэрэгтээ тэр бурханлаг мэдлэгт гүн нэвтэрхий боловч өөрийгөө зөвхөн бидэн шиг ухвар мөчид материалист гэж үзэж байна. Шрила Санатана Госвами, трансценденталь мэдлэггүй байж бусдаар улс төрийн сод гарамгай зүтгэлтэн болон аугаа эрдэмтэн гэж нэрлүүлэхийг зөвшөөрсөн гэж өөрийгөө зэмлэж байна. Тэрээр, өөрийн жинхэнэ “Би” буюу сүнснийхээ тухай юу ч үл мэдэх бөгөөд тэр талаар санаа үл тавьж, харин мөнх бус материаллаг бие махбодь болон ухааны амсаж эдэлж байдаг жаргал зовлонг тэсвэрлэн өөрийн цагаа хий хоосон үрэн өнгөрөөж байдаг ч аугаа эрдэмтэн, улс төрийн сод гарамгай зүтгэлтэн, хамгийн шилдэг гүн ухаанч, *махатма* эсвэл *парамахамсын* нэр алдартай болж, тиймэрхүү тэнэг мунхагуудын дунд хялбархан алдаршихын төлөө тэмцэгчээс илүү тэнэг мунхаг хүн материалистуудын дунд байдаггүй гэдгийг шууд бус утгаар ойлгуулж байна. Санатана гэж “мөнхийн” гэсэн утгатай үг. Санатана Госвами, амьд оршнолууд нь мөнх бус бие махбодь болон ухаанд л тохирч нийцсэн байдаг зуурдын аз жаргалыг биш, харин мөнхийн аз жаргалыг хүртээсэй гэж ихэд хүсэж байсан. Хэрвээ хүн мөнхийн сүнсний мөнхийн аз жаргалд хүрэхээр эрмэлзэн тэмүүлж эхлэх аваас түүнийг Санатана Госвамийн зам мөрийг даган баримтлагч буюу жинхэнэ трансценденталь гэж үзэх хэрэгтэй.

Манай энэ цаг үед нийгмийн болоод улс төрийн зүтгэлтэнгүүд, эрдэмтэд болон *махатмууд* нь бараг бүгдээрээ ямар нэгэн хэмжээгээр материалистууд болсон байдаг бөгөөд бурханлаг мэдлэгийг өчүүхэн төдий ч сонирхдоггүй. Иймээс эрдэмтэд гэж нэрлэгдэгчид болон тэнэг мунхаг материалистуудын удирдагчдад сургамж өгөх гэж Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Аржунаг *пандит* буюу цэцэн мэргэн хүн гэж үзэхийн аргагүй гэж айлдан түүнийг юуны өмнө зэмлэсэн болой.

Орчин үеийн нийгмийн удирдагчид нь зөвхөн материаллаг бие махбодь болон ухаантай холбогдсон шашины байж болох бүхий л хэлбэрүүдийг дэлгэрүүлж байна. Гэхдээ тэдний маш цөөн нь бие махбодь болон ухаан нь сүнсний зөвхөн “хувцас”, түүний “пальто” болон цамц гэдгийг мэддэг. Хувцсандаа санаа тавих явдал нь түүний эзэнд жинхэнэ ач тусыг авчирч чадахгүй билээ. Бидний санаа тавих хамгийн гол зүйл бол сүнс. Эрүүл саруул ухаан бодолтой ямар ч хүн хуучирч муудсан хоёр дугаар зэргийн зүйлүүдэд санаа тавиад байдаггүй. Хамгийн гол нь өөрийн сүнсэндээ санаа тавих явдал байдаг. Хамгийн гол зүйлдээ, өөрөөр хэлбэл сүнсэндээ санаа тавьснаараа хүн хоёр дугаар зэрэглэлийн зүйлс болох бие махбодь болон ухаандаа давхар анхаарал халамж тавьсан хэрэг болдог. Хоёр дугаар зэрэглэлд тавигдсан зорилгодоо хүрэх гэж зүтгэснээрээ хамгийн гол зорилгодоо хүрдэггүй билээ. Өөрөөр хэлбэл өөрийн гадуур хувцасны тал дээр хичээнгүйлэн санаа тавьснаар бурханлаг цангааг тайлж чадахгүй юм.

Иймээс, амьд оршнолуудын талаар ярихдаа бид бие махбодь болон ухаан нь амьдралын хүч сүнс- бодьгалыг нөмрөн хучсан гадна талын бүрхүүл юм гэж үзэх ёстой. Энэхүү гадаад бүрхүүл нь мөнх бус байдаг бөгөөд энэ нь түүнтэй холбогдсон бүхэн мөн л цаг зуурын байдаг гэсэн үг юм. Мөнх бус бие махбодь болон ухааны амсаж эдэлж байдаг жаргал болоод зовлон нь зуурдын болой. Үүнээс үүдэн Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна: “Ай Кунтийн хүү минь ээ, жаргал зовлонгийн бүхий л хэлбэрүүд нь зуны аагим халуун болоод өвлийн тэсгим хүйтэн шиг л материаллаг мэдрэхүйн ойлгоцоор л төрж байдаг. Тэд байгаль мөн чанарын хуулинд захирагдан ирж явж байдаг учраас амгалан тайван байдлаа алдалгүйгээр тэвчин тэсвэрлэх хэрэгтэй. Түр зуурын зовлон жаргалд тэнцвэртэй тайван байдлаа алдахгүй байгаа хүн л мөнхийн амьдралд хүрч чадах билээ.” гэж Бхагавад Гитад айлдсан байдаг.

Гэвч өнөөгийн байр сууринд байгаа бидний хувьд бие махбодь болон ухааныхаа амсаж эдэлж байгаа цаг зуурын жаргал болоод зовлонг хайхрахгүй байна гэдэг бол маш хүнд. Бид өөрсдийгөө бие махбодь болон ухаантайгаа үл адилтган үзэхээс хол төсөө байдаг. Иймээс л материаллаг жаргал болоод зовлонг ажрахгүй байж чаддаггүй билээ. Гэхдээ бурханлаг мэдлэгийг хүртэж агуулах гэдэг нь бидэнтэй болж явагдаж байгааг үл тоон эс ойшооно гэсэн үг огт биш, харин жаргал болоод зовлон байнгад солигдон байдгаас болж сүнсний тэнцвэртэй байдлаа алдахгүй байх гэсэн утгатай юм.

Бид цаг зуурын байдаг материаллаг жаргал болоод зовлонгийн мөн чанарыг ойлгох ёстой. Тэдгээрийг үл хайхарч эс ойшоох нь материаллаг бие махбодь болон ухааны оршнолыг тэтгэж, тогтоон барьж байдаг сүнсэнд хайхрамжгүй хандсантай адил хэрэг болох бөгөөд ингэх нь туйлын тэнэг мунхаг явдал болох билээ. Үнэн хэрэгтээ, хүн бурханлаг мэдлэгийг сонирхон сүнсээ ойлгож ухаарах аваас өөрийн бие махбодь болон ухаанаас шалтгаалан гарсан материаллаг жаргал болоод зовлонгийн дунд ч трансценденталь тайван амгаланг амтлангаа тэдгээрийг үл ажирсан байдлаа хадгалж чадах болно. Оршнолын зөвхөн ийм трансценденталь нөхцөл байдалд л жинхэнэ тайван амгаланд хүрч болдог. Ийм трансценденталь нөхцөл байдал л жинхэнэ ханамжтай байдлыг авчирдаг болой. Хүн гэр орноосоо удаан хугацааны туршид алс хол байж байгаад эцэст нь гэрийн зүг буцан харьж байхдаа амсаж эдэлж байдаг таашаал ханамжтай байдал нь аяллын явц, замын дунд тохиолдох тав тухгүй байдлыг хөнгөрүүлж зөөллөж байдаг. Гэртээ харьж байгаа түүний баяр хөөрийг нь ямар ч хүндрэл бэрхшээл гутаан дарж чаддаггүй. Мөн тэрчлэн, трансценденталь мэдлэг хүртсэний ач тусаар Бурханы зүгт, буцаад гэр лүүгээ харьж байгаа хүн өөрийн бие махбодь болон ухааны зүгээс үзүүлж учруулж байгаа зовлон шаналалд анхаарал үл хандуулдаг.

Бид мэдрэхүйн ойлгоцоороо л жаргал болоод зовлонгийн байж болох бүхий л хэлбэрүүдийг амсаж эдэлж байдаг. Хэлбэр, амт, үнэр, дуу болон хүртэхүй- энэ бүх, янз бүрийн мэдрэмжүүд нь ухааны оролцоотойгоор бидэнд тав тухтай байдал эсвэл зовлон шаналалыг амсуулж эдлүүлж байдаг. Өвөл хүйтэн усанд угаал үйлдэх нь хэцүү,

бэрхшээлтэй байдаг ч зун ийм ус нь таатай сайхан байдаг. Өвөл галын илч дулаан тааламжтай байдаг бол зун энэ л гал нь зовлон бэрхшээл учруулж байдаг. Ингэхлээр гал ч тэр, ус ч тэр аль аль нь дан ганцаараа бие даан бидэнд таатай сайхан байдал үзүүлэх эсвэл зовлон бэрхшээлийг учруулах шалтгаан болох чадваргүй байдаг. Бидний мэдрэхүй тэднийг ямар нөхцөл байдалд хүлээн авч байгаагаас хамааран тэд нэг бол аятай таатай байдлын эсвэл зовлон шаналалын эх үүсвэр болж байдаг байх нь. Иймээс, дэлхий ертөнцөд юу ч тэр зөвхөн аз жаргал эсвэл зөвхөн зовлон шаналалын шалтгаан болдоггүй. Аз жаргал болон зовлон шаналалын ойлголт нь зөвхөн тухайн хүний хувийн бодол санаатай холбоотой байдаг бөгөөд тэдгээр нь бидний сэрэл мэдрэмж нь бидний ойлгоц, сэтгэхүй болон хүсэл эрмэлзэлтэй хэрхэн харгалзан нийцэж байдгаас хамаардаг.

Гэхдээ сэтгэхүйн, сэрэл мэдрэхүйн ойлгоц болон хуурамч эго-ны нөлөөллийн доорхи бодол санааны үйл явцтай холбогдсон зуурдын аз жаргал болон зовлон шаналал нь мөнхийн сүнстэй огтхон ч холбоогүй байдаг учраас тэдгээрийг “үл оршин буй бодит байдал” гэж нэрлэдэг. Хэрвээ эрдэмтэдийн нээсэн мэдлэг нь мөнхийн сүнстэй ямар ч холбогдолгүй л байх юм бол тэд хүмүүнлэгийн болон тухайн шинжлэх ухааны салбарт ямар ч өндөрт хүрсэн бай ялгаагүй түүнийг, биднийг хий хуурмагт автуулж живүүлсэн бие махбодь болон ухааныг төөрөлдүүлэн мэхэлж эрхэндээ оруулан боолчилдог материаллаг мөн чанарын *гунуудын* илрэл л гэж үзэх хэрэгтэй.

Мөн чанарын *гунуудын* нөлөөллөөр гажуудсан хийгээд бидний өмнө дэлгэгдэн нээгдэж байгаа иймэрхүү материаллаг мэдлэг нь “үл оршин байгаа бодит байдлын” зураг төдий л зүйл бөгөөд жинхэнэ аз жаргал болоод амар амгаланг олоход бидэнд хэзээ ч тус нэмэр болохгүй. Бхагавад Гитад Шри Кришнагийн айлдсанчлан, мөнхийн сүнсний тухай трансценденталь мэдлэгээ гүнзгийрүүлэн хөгжүүлж байгаа хүн л цаг зуурын жаргал болоод зовлонг үл ажран, төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөлийн зовлон зүдгүүрээс салан ангижрах бөгөөд мөнхийн бурханлаг амьдралын жинхэнэ аз жаргалд хүрдэг.

Иймээс бид, хүмүүсийн төлөө ач тустай, хэрэгтэй юм хийхийг чин үнэнээсээ чармайн хичээж байгаа боловч бүтэмжгүй байдалтай учраад байгаа хэн бүхнийг тусламж дэмжлэг хүртэхээр Шри Кришнад эсвэл Аржунагийн үлгэр жишээг даган Түүний итгэмжлэлт албатуудад хандах хэрэгтэй гэдгийг зөвлөж байна. Мэдээж хэрэг, бид бусдад сайн сайхан зүйл хийхийг хичээн чармайх ёстой боловч, эхлээд үүнийгээ хэрхэн яаж хийхийг төгс төгөлдөр байдлаар мэдэх хэрэгтэй. Хүн өөрийн хүрээлэгчдийн ашиг сонирхолд хуурмаг бодь сэтгэлтэний бодол санаагаар хандах аваас тэр алдар цуу, өргөмжлөл хүндлэл болон олз ашгийн ямар нэгэн хэлбэр бүхий цаг зуурын ач тусыг л хүртдэг.

Гитлер эсвэл Муссолинтай адил төстэй хэн нэгэн материалист удирдагч нь, өөрийн нь боловсруулсан хүчээр албадах эсвэл тайван замаар хэрэгжүүлэх өөрчлөлт шинэчлэлт нь хүмүүст ач тус хүргэхийн зэрэгцээ нийгмийн талаар санаа тавих гэж нэрлэгдэх энэхүү байдал нь нийгмийн зүгээс өөрийн нь талыг баримтлагчдыг хүлээн зөвшөөрч, тэдэнд хүндлэл сайшаалыг үзүүлэхэд нь түүнд туслах болно гэж өөрийн талынхнаа ятган итгүүлж байдаг. Түүний ач тустай гэгдэх үйлийн үр дүн нь цаг зуурын байдаг учраас иймэрхүү жолоодогчоос хайр хишиг хүртэхээр чармайж байгаа хэн бүхэнд тэрээр бодьтой ач тусыг үзүүлж чаддаггүй болой.

Нийгмийн “ач тусын” төлөө чиглэсэн энэ бүх үйл ажиллагаа нь ямар ч ач тусгүй байдаг. Түүнээс гадна жолоодогч гэж нэрлэгдэгчийнхээ заасан замыг дагаснаар түүний дагалдагчид нь зовлон бэрхшээлийг улам бүр ихээр амсаж эдэлж байдаг. Хэрвээ нэг сохор нөгөө сохортоо замаар явахад нь туслахыг оролдох аваас тэд хоюулаа л замын хажуугийн сувагт унацгаах болно. Бурханлаг мэдлэггүй хүн хараагүй сохор хүнтэй адил төстэй байдаг бөгөөд иймээс ч бусдыг гэрэл рүү хөтлөхийн өмнө тэр өөрөө хараа орох ёстой.

Энэтхэгт бурханлаг мэдлэгийн баялаг өв уламжлал хэзээнээсээ л хадгалагдан уламжлагдаж ирсэн учраас чухамдаа Энэтхэгт төрсөн хэн бүхэн бусад хүмүүст ачлал

ивээлийг хайрлан хүртээх далд битүү чадвартай байдаг. Бхаратаваршагийн (Эрт дээр цагт Энэтхэгийг ингэж нэрлэдэг байв.) гэгээнтэн, мэргэд нь зөвхөн бие махбодийн болон ухааны шаардлагыг хангах үйлээр өөрсдийгөө хязгаарлаж байгаагүй. Тэд бие махбодь болон ухаанд трансценденталь байдаг сүнсний тухай шинжлэх ухааныг байнгад хөгжүүлж байсан. Маш их хүндрэл бэрхшээлтэй учирч байдаг хэдий ч одоо ч гэсэн Энэтхэгийн гэгээнтэн, мэргэд энэхүү шинжлэх ухааныг үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна. Гэхдээ тэд өөрсдөө эхлээд бурханлаг мэдлэгийг хүртээгүй байж бусдад ач тусыг хүртээхийг оролдох аваас энэ нь энэтхэгчүүдийн зүгээс хийж байгаа хамгийн айхавтар тэнэглэл мунхаглал болох билээ.

Бурханлаг мэдлэгийг хүртэхийг эрмэлзэж байгаа хүн хамгийн эхний ээлжинд сүнс бол үнэмлэхүй, мөнхийн үнэнийг төлөөлдөг гэдгийг ойлгох ёстой. Сүнсний гадаад бүрхүүл болох бие махбодь болон ухаан нь бүрэн дүүрэн бус буюу харьцангуй үнэн юм. Бүхний Дээд Бурхан энэ талаар Бхагавад Гитагийн хоёр дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан байдаг:

“Бүхий л бие махбодид нэвчин тархах тэр зүйл бол устаж сүйрдэггүй гэдгийг мэдэж ав. Үхэшгүй мөнхийн сүнсийг хэн ч устгаж чадахгүй. Үл устаж сөнөх, хэмжихийн аргагүй хийгээд мөнхийн сүнсний бие махбодь нь үхэх тавилантай билээ. Иймээс, ай Бхаратын үр удам минь ээ, энэхүү мөнхийн үнэнийг таньж мэдээд байлдан тулалдагтун.”

“Амьд оршнолыг устгаж болно эсвэл амьд оршнол нь устдаг гэж бодож байгаа хүн нь огтын мэдлэггүй харанхуй юм. Учир нь сүнсийг устгаж болохгүй бөгөөд тэрээр огт устдаггүй юм. Сүнсний хувьд төрөлт үхэл гэж хэзээ ч байдаггүй. Тэр хэзээ ч үүсэж бий болоогүй, хэзээ ч үүсэж бий болдоггүй, хэзээ ч үүсэн бий болохгүй. Тэр төрдөггүй, мөнхөд байнга оршиж байдаг, анхдагч, тэгсэн хэдий ч мөнхөд залуугаараа. Бие махбодь үхэж үрэгдэхэд ч тэр үхэж үрэгддэггүй. Сүнс бол устаж үгүй болдоггүй, төрж бий болдоггүй, өөрчлөгдөж хувирдаггүй гэдгийг мэдэх хүн хэрхэн, хэн нэгнийг хөнөөх эсвэл хөнөөлгөх гэх билээ дээ? Бие махбодь болон ухаанаас бүрдэх гадаад бүрхүүл л үхэж үрэгддэг.”

“Бие махбодь болон ухаан нь хувцастай адил юм. Хүн хуучирч муудсан хувцсаа тайлж хаяад шинийг өмсдөгтэй адил сүнс нь хэрэггүй болсон хуучин бие махбодио орхин шинэ бие махбодийг авдаг.”

“Сүнсийг ямар ч зэвсэг хэрэглэсэн бай огтолж хэрчиж чадахгүй, тэр галд ч шатахгүй, усанд ч норж уусахгүй, мөн салхинд ч гандаж өгөршихгүй. Тэр байнгад хаа сайгүй, өөрчлөлт хувиралтгүй, хөдөлшгүй оршдог бөгөөд мөнхөд ийм байна. Сүнсийг үгээр тодорхойлон хэлэх буюу ухааны хүчээр түүнд төгс хүрэх аргагүй байдаг. Иймээс сүнс бие махбодийг орхих үед гашуудан гуниглах хэрэггүй юм.”

Бхагавад Гитад бие махбодь болон ухааныг *киетра* буюу үйлийн талбар, харин сүнснийг *киетра-гья* буюу үйлийн талбарыг мэдэгч гэж тодорхойлсон байдаг. Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Бхагавад Гитагийн 13 дугаар бүлэгт *киетра* болон *киетра-гья* гэж юу болохыг тайлбарлан, мөн *пракрити* (мөн чанар буюу таашаал ханамж эдлүүлэгч материаллаг ертөнц) болон *пуруша* (материаллаг ертөнцийг таашаагч бодьгал)-ын талаар айлдсан. Бурхан Кришнагийн тайлбарласанчлан, энэ ертөнцөд үйлдэгдэж байгаа бүхий л үйлүүд болон тэдгээрийн бүхий л үр дагаврууд нь байгаль буюу мөн чанар (*киетра*) болон түүгээр таашаал ханамж эдлэгч (*киетра-гья*)-ийн хослон нийлсэний үр дүн байдаг. Жишээлбэл, тариа будаа нь талбай болон тариачин хоёрын харилцан үйлдлийн үр дүнд л ургадаг. Энэ тохиолдолд тариалангийн талбай нь *киетра*, харин тариачин нь *киетра-гья* болно. Мөн, хүүхэд нь *пракрити* буюу таашаал ханамжийн объект болон *пуруша* буюу таашаал ханамж эдлэгч хоёрын хослон нийлсэний үрээр хорвоод төрдөг билээ. Үүнтэй адил төстэйгөөр, бидний энэ материаллаг ертөнцөд харж байгаа бүхэн үйлийн талбар (*киетра*) болон үйлийн талбарыг мэдэгч (*киетра-гья*)-ийн нэгдлийн үр дүнд бий болдог.

Кшетра-гья нь амьд сүнс байдаг бол *кшетра* нь амьд оршнолын эзэмшин захирч байдаг матери юм. Физик, хими, одон орон, эм зүй, эдийн засаг, секс судлал болон материаллаг шинжлэх ухааны бусад салбарууд нь зөвхөн үйлийн талбар *кшетраг* судалдаг байхад бурханлаг буюу трансценденталь мэдлэг нь *кшетра-гья* байдлаар тодорхойлогддог мөнхийн сүнс тэй холбоотой байдаг. Шинжлэх ухааны жинхэнэ хөгжил гэж амьд сүнс (*кшетра-гья*)-ийг судлахыг хэлэхээс биш үхмэл матери (*кшетра*)-г биш. Энэ талаар бид цаашид илүү дэлгэрэнгүй ярих болно. Харин одоо, *кшетра-гья* (*пуруша* буюу таашаагч) нь материаллаг бие махбодь, ухаан болон бусад элементүүдтэй нэгдсэнээр хорвоо ертөнц дэх бүх оршнолууд бий болдог учраас чухамдаа *кшетра-гья* нь танин мэдэхүйн үндсэн объект байдаг гэдгээр л тайлбараа хязгаарлая.

Кшетра-гья нь мөнхийн сүнс байдаг бол *кшетра* нь цаг зуурын матери юм. Энэхүү хөдөлбөргүй үнэн нь ведийн цэцэн мэргэн үгэнд тусгалаа олсон байдаг: *брахма сатйам жаган митхиа* буюу “Сүнс бодитой оршин байдаг, харин хүрээлэн байгаа дэлхий ертөнц бол бодит байдлын сүүдэр төдий зүйл юм.” Материаллаг ертөнц мөнх бус байдаг учраас “бодит байдлын сүүдэр” гэж нэрлэгдэж байна. Тэрээр цаг хугацааны хязгаарлагдмал завсарт л оршдог. Гэсэн хэдий ч энэхүү ертөнц нь ерөөсөө оршин байдаггүй гэж алдаатай буруугаар бодох явдал байдаг. Бидний хэн бүхэнд мөнх бус буюу цаг зуурын материаллаг бие махбодь болон ухаан байдаг. Иймээс өөрийн бие махбодь болон ухааны оршнолыг үгүйсгэн өөрийгөө инээдэмтэй байдалд оруулан элэг доог болохын хэрэггүй юм. Мөн, бидний бие махбодь болон ухаан нь мөнх бус гэдгийг мартаж болохгүй. Бие махбодь болон ухааны бүрхүүл доор далдлагдсан сүнс л мөнх болой. Иймээс тэр бол хөдөлбөргүй үнэний төлөөлөл юм. Мөнхийн сүнсийг хэн ч устгаж хөнөөж чадахгүй гэдгийг бид эн тэргүүнд ойлгох шаардлагатай. Мөнхийн сүнс нь сайн сайхан хийгээд хорон муу, энэрэн нигүүлсэхүй хийгээд үл энэрэн нигүүлсэхүйн талаархи материаллаг ойлголт төсөөллийн чанадад, тэдгээрээс дээш оршдог.

Өнөөгийн цаг үед дэлхий дахин бүхлээрээ бүдүүлэг физик бие махбодь болон ухаанаа цаг зуурын тав тухтай байдлаар л хүрээлүүлэх мэдлэгийн гүнд шигдэн орсон байна. Ийм байдалд байгаа хэдий ч бие махбодь болон ухаанаас нэн чухал сүнсний тухай мэдлэгт хэн ч зохих анхаарал тавихгүй байна. Үүний үр уршгаар дэлхий дахин, хэн бүхэнд барагдашгүй их зовлон шаналал, зовиур түгшүүр авчрагч мунхаглалын харанхуйд орчихоод байна. Хүн материаллаг аз жаргалыг удаан хугацааны туршид амсаж эдэлдэг үү? Огтхон ч үгүй. Иймэрхүү таашаал ханамжид автана гэдэг нь ходоодныхоо хэрэгцээ шаардлагаа умартаад гадуур хувцсаа л угааж суухтай адил юм. Бидний үндсэн хэрэгцээ бол бие махбодь бүрт оршин байдаг амьд оршнол буюу үл устаж сөнөх сүнсний мөнхийн үнэний тухай мэдлэг хүртэх явдалд оршиж байдаг.

Амьд оршнол нь маш өчүүхэн жижиг, бүр атомаас хүртэл жижиг. Сүнсний тухай шинжлэх ухаанд нэвтэрхий хүмүүс сүнсний овор хэмжээний талаархи ойлголт төсөөллийг бидэнд өгөхийг чармайн хичээсэн байдаг. Тэдний өгүүлснээр бол, сүнс нь овор хэмжээний хувьд үсний үзүүрийг арван мянга хуваасны нэгээс томгүй. Хүчтэй үйлчилгээтэй эмийн өчүүхэн бага тун ч бүхий л организмд нөлөөгөө үзүүлдэгтэй адил сүнсний оршин байгаа нь бүхий л бие махбодид мэдрэгддэг. Бие махбодийн аль ч хэсэгт хамгийн хөнгөнөөр хүрэхийг ч мэдэрдэг бидний чадвар нь бурханлаг жижиг хэсгийн бие махбодид оршин байгаагаар тайлбарлагддаг. Харин энэхүү бурханлаг очийг гаран явмагц бие махбодь нь ямар ч хөдөлгөөнгүй үхмэл болох бөгөөд түүнийг сүхээр цавчиж байсан ч ямар ч өвдөлтийг мэдрэхгүй.

Ямар ч материалист эрдэмтэн сүнсийг материаллаг бодисуудаас бүтээж чадахгүй гэсэн баримт нь өчүүхэн жижиг бурханлаг оч буюу сүнс нь материаллаг бус гэдгийг хэлж байна. Нэр алдартай эрдэмтэд нь бурханлаг сүнсийг материаллаг шинжлэх ухааны тусламжтайгаар ахин сэргээн оруулж чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон билээ. Материас бүтээгдсэн бүхэн түр зуурын байдаг бөгөөд устаж сүйрэх

тавилантай байдаг. Харин үүний эсрэгээр, бурханлаг оч нь юуны өмнө, материаллаг элементүүдийн ямар нэгэн нэгдлээс үл тогтох учраас устаж сүйршгүй байдаг билээ. Хүмүүс атомын бөмбөгийг бүтээж хийхэд суралцсан ч амьд бурханлаг очийг бол чадахгүй.

Орчин үеийн шинжлэх ухаан нь бүхий л улс орнуудад их амжилттай хөгжсөн хэдий ч алдар цуутай эрдэмтдийн нэг нь ч танин мэдэхүйн хамгийн чухал объект үргэлж хэвээр байдаг бурханлаг оч- сүнсийг судлах оролдлого хийгээгүй нь ямар харамсалтай хэрэг вэ? Үүнд л бидний бүрэн арчаагүй байдал, гүн гүнзгий мунхаглал оршдог.

Амьдралын эх булаг өчүүхэн жижиг оч нь Альберт Эйнштейн эсвэл Исаак Ньютон нарын бие махбодийг орхимогц тэдний аугаа тархины үйл ажиллагаа шууд л зогссон. Хэрвээ амьдралын энэхүү эх үүсвэрийг химийн эсвэл физикийн урвалын тусламжтайгаар дахин сэргээж болдог байсан бол эдгээр аугаа эрдэмтэдийн залгамжлагчдын хэн нэгэн нь, тэд өөрсдийн хувь нэмрээ шинжлэх ухааны хөгжилд цаашид үргэлжлүүлэн оруулаасай гэсэн үүднээс тэднийг амьдралд нь шууд эргүүлэн оруулах л байсан. Бурханлаг очийг бүтээж бий болгоход ямар ч арга, заль мэх байгаад материалист эрдэмтэдэд тус нэмэр болохгүй. Иймээс үүнийг ирээдүйд л хийх болно гэж зарлаж байгаа тэдний хэн бүхэн нь хамгийн тэнэг мунхаг бөгөөд бялангач болой. Сүнс бол мөнх. Тэр төрдөггүй, мөн үхдэггүй иймээс түүнийг бүтээж бий болгоно гэдэг боломжгүй хэрэг. Эцсийн эцэст, бид бүхэн өөрсдийн туршлагаараа, бүтээгдсэн бүхэн эрт орой хэзээ нэгэн цагт устаж сүйрдэг гэдгийг мэддэг. Сүнсний мөнх байдал нь түүнийг ямар ч материаллаг арга хэрэгслээр бүтээж болдоггүйгээр батлагдана.

Бурханлаг очийг хөнөөж болно гэж бодож байгаа хүн түүний мөн чанарын талаар мөн л мэдэхгүй байгаа хэрэг. Иймээс Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна мөн чанараараа бурханлаг болох амьд оршнол нь хэзээ ч төрдөггүй, мөн хэзээ ч үхдэггүй гэж онцлон айлдсан. Тэр бол мөнхөд оршдог, түүний хувьд өнгөрсөн, одоо, ирээдүй гэж байдаггүй. Сүнс усташгүй, тэрээр материаллаг бие махбодь үхсэний дараа ч үргэлжлэн оршсоор байдаг. Үхэл төрөлтийн төгсгөлгүй замаар замнан байгаа сүнс нэмэгддэгч үгүй, мөн хорогддог ч үгүй. Амьд оршнол нь маш өндөр настай, маш эртнийх гэгддэгч тэрээр мөнхийн залуугаараа байдаг. Сүнс бол үхэл сүйрэлд өртөх хувь тавилантай бие махбодь болон ухаанаас ялгаатай.

Иймээс, бурханлаг мэдлэгт нэвтэрхий хүмүүс хэн нэгнийг балмадаар хөнөөх эсвэл бусдыг аллага хядлаганд өдөөдөггүй. Тэгвэл яагаад Аржуна Курукшетрын талбарт болсон тулалдаанд оролцсон юм бэ? Энэ асуултын хариулт нь дараахь зүйлд оршино. Эр цэргийн үүргээ биелүүлэх явдал нь зөвхөн бие махбодид хамааралтай хэрэг. Нүнжигтэй, шим сайтай хоол нь ухаанд биш харин ходоодонд л таашаал ханамж эдлүүлдэгтэй адилаар дайн тулааны эсвэл түүхийн бусад үйл явцын үед болж тохиолддог бүхэн нь бие махбодид л хамааралтай байдаг болохоос сүнсийг бол хөндөж шүргэх ч үгүй. Бурханлаг жижиг хэсэг нь устаж сүйршгүй байдаг бөгөөд тэр галд ч, усанд ч үхдэггүй эсвэл мөн агаар салхинд ч өгөршиж ганддаггүй учраас матери нь мөнхийн амьд оршнолд нөлөөлж чадахгүй юм. Зөвхөн материаллаг зүйлсийг л зэр зэвсгээр тасчиж, галд шатааж, усанд уусгаж эсвэл салхинд гандаж өгөршүүлж болдог. Материалаг шинж чанарын иймэрхүү үгүйсгэлийг Бхагавад Гитад, сүнсний буюу амьд оршнолын метафизикийн мөн чанарын талаархи тодорхой ойлголт төсөөллийг бидэнд буй болгодог дагалдах, хажуугийн учир баримт байдлаар өгүүлсэн байдаг.

Энэтхэгт *санатана-дхарма* буюу “мөнхийн шашин” гэж нэрлэгддэг тэр зүйл бол чухамдаа эдгээр мөнхийн, хаа сайгүй орших үл өөрчлөгдөж хувирах, үл устаж сөнөх бурханлаг хэсгүүдэд л зориулагдсан. Өөрөөр хэлбэл, жинхэнэ бурханлаг байдал нь нэг бол бүдүүлэг физик бие махбодь эсвэл нарийн материас бүрдэх ухаанд холбогдол, хамааралтай байх бүхий л итгэл бишрэлүүдэд трансценденталь байдаг. *Санатана-дхарма* буюу мөнхийн шашин нь үндэстэн, улс орон эсвэл цаг хугацаагаар хязгаарлагддаггүй. Тэр

бол бүх нийтийг хамаардаг. *Санатана-дхарма-гаас* ангид гадуур байх бүх шашиныуд нь зөвхөн бие махбодь болон ухаанд л ач тус хүртээх чадвартай байдаг.

Үндэс угсаа, төрсөн газар орон, амьдарч байгаа цаг үеэсээ хамаараад бид өөрсдийгөө индиуст, мусульман, Христэд итгэгч, буддист, социалист, большевик гэх зэргээр нэрлэж байдаг. Улс орон, үндэстэн эсвэл цаг үе зэрэг цаг зуурын ойлголтууд дээр үндэслэгдсэн итгэл бишрэлийн олон янз хэлбэрүүдийг бодож олсноороо бид шашины салбарт нэн хол явсан хэрэг. Чухамхүү энэ учраас л бид “шашиныг сольж” болно гэж алдаатай, буруугаар бодож байдаг. Өнөөдөр өөрийгөө, би бол индиус гэж нэрлэж байгаа хүн маргааш мусульман болж болно, мусульман нь Христэд итгэгч болох гэх мэт... Гэхдээ хүмүүс жинхэнэ бурханлаг мэдлэгийг хүртэн, сүнс буюу амьд оршнолын салшгүй, мөнхийн шашин- *санатана-дхарма-д* бат итгэлтэй болсон цагт л дэлхий даяараа жинхэнэ амар амгалан, хөгжил цэцэглэл болон аз жаргалд хүрнэ. *Санатана-дхарма-гүйгээр* эдгээр зорилгод хүршгүй юм.

Сүнс бол өчүүхэн жижиг бөгөөд материаллаг хараанд өртөшгүй. Ийм учраас түүнийг жигтэй хачин, битүүлэг болон ойлгож ухаарч хүрэхийн аргагүй гэж нэрлэдэг. Үүний зэрэгцээ үхэл, төрөлт, хөгшрөлт, өвчлөл болон материаллаг амьдралын өөр бусад ямар ч шалгалт сорилтонд эс эрсдэх учраас тэр мөнх. Тэгвэл эдгээр хүнд хэцүү шалгалт сорилтоос салж ангижран жинхэнэ амар амгаланд хүрэхийн тулд сүнсний мөнхийн шашиныг газар сайгүй зориг шийдэмгийгээр түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ, энэхүү мөнхийн шашин нь үндэс угсаа, улс гүрэн эсвэл цаг хугацааны хүрээгээр хязгаарлагддаггүй гэдгийг бид байнга санаж байх ёстой.

Карма-йога—бурханлаг үр дагавар авчрах үйл

Ведийн мэдлэгт нэвтэрхий мэргэдийн үгээр бол амьд оршнол нь 8 400 000 биологийн хэлбэрүүдийг бүгдийг нь дамжин аажим аажмаар хөгжсөний үр дүнд сая л Бхаратаваршагийн ариун гэгээн газар орон Энэтхэгт төрдөг ажээ. Энэхүү 8 400 000 биологийн хэлбэрт 900 000 усанд оршигч, 200 000 ургамал зэрэг үл хөдлөх оршнолууд, 1 100 000 хэвлээр явагч болон хорхой шавьж, 1 000 000 шувууд, 3 000 000 адгуусан амьтадын болон 400 000 хүний хэлбэрүүд багтдаг. Сүнс нь эдгээр биологийн янз бүрийн хэлбэрүүдийг ээлжлэн аван олон сая жилийн туршид хэмжээ хязгааргүй орчлонгоор ийнхүү хэрэн бэдэрч байдаг. Чухамхүү ийм учраас л сүнсийг хаа сайгүй оршигч гэж нэрлэдэг.

Урд өмнө дурьдсанчлан, удаан хугацаагаар хэрэн бэдэрч тэнүүчилсэний эцэст Бхаратаваршагийн ариун дагшин газар орон (Энэтхэг)-т төрсөн хэн бүхэн өөрийн бурханлаг мөн чанарыг ухааран, өөрөө гэгээрсэний дараагаар бусдадаа дээдийн дээд ач тусыг хүргэх ёстой гэж Шри Чайтанья Чаритамрита-д батлан өгүүлсэн байдаг. Сүнсээ ойлгож ухаарахын төлөө Энэтхэгээс өөр ямар ч орны аугаа мэргэд төдийлөн их хүчин чармайлт гаргаагүй. Барууны орнуудын оршин суугчдын хувьд гэвэл, тэд бие махбодь болон ухааныг судлахад төвлөрөн чиглэдэг материаллаг шинжлэх ухааны хөгжлийн өндөр амжилтанд хүрсэн гэдэг нь тодорхой. Энэхүү өндөр хөгжил дэвшилд хүрсэн хэдий ч барууны ихэнх хүмүүс нь сүнсний тухай шинжлэх ухаанд зохих анхаарал хандуулдаггүй учраас материализмын аймшигт үр дагавраас болж зөвж шаналж байдаг нь мөн л тодорхой. Иймээс хүмүүст Бурханы бурханлаг илгээлтийг үнэхээр дуулгаж сонсгохын тулд барууны аугаа сэтгэгчид Энэтхэгийн өв уламжлалд хандах ёстой.

Дэлхий даяар дүрэлзэн байгаа материализмын түймрийг унтраах хийгээд хүмүүсийн хувь тавиланг хөнгөрүүлэхийн тулд Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Бхагавад Гитад, *карма-йогын* гол учир утга бол бурханлаг үр дагавар дагуулагч үйл мөн гэж тодорхой тайлбарлан айлдсан. Материаллаг олз ашгийн төлөөх үйл болон бурханлаг

үр дагавар дагуулах үйл хоёрын хооронд маш их ялгаа байдаг. Бурхан Бхагавад Гитад *буддхи-йога-г* буюу “оюун ухаан дээр үндэслэгдсэн хийгээд бурханлаг үр дагавар дагуулах үйл”-г хэдэнтээ дурьдсан байдаг. Өөрийн чин бишрэлтэнгүүддээ үргэлж өршөөнгүй байдаг Бурханы Дээд Бодьгал Шри Кришна тэдэнд чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэх болон амьдралынхаа төгсгөлд Түүн рүү буцан ирэхэд нь туслах оюун ухааныг хайрлан хүртээдэг гэж айлдсан учраас *буддхи-йога* нь “трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах алба” гэсэн утгыг мөн илэрхийлдэг. Бурханы зүгт зөвхөн чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэсний ачаар л буцан очиж болох талаар өөр баталгаанууд ч байдаг.

Ийнхүү, зөвхөн *буддхи-йога-д* буюу бурханлаг үр дагавар дагуулах, ухаарсан үйл болох *карма-йога-д* өөрийгөө зориулсан цагт л үйлийнхээ (кармын) үр дагавраас салан ангижирдаг.

Бхагавад Гитагийн хоёр дугаар бүлэгт, Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна: “Ийнхүү Би чамд бурханлаг мэдлэгийг нээн хүртээлээ. Одоо Би чамд бурханлаг үр дагавар дагуулах үйлийн талаар айлдъя. Түүнийг үйлдэх болсноороо чи эгэл жирийн үйлүүдийн араасаа дагуулж байдаг боолчлолоос салан ангижрах болно. Энэ зам мөрөөр замнаж байгаа хэн бүхэн ямар ч гарз хохирлыг амсдаггүй. Энэ зам мөр дээр гаргасан өчүүхэн бага хөгжил дэвшил ч гэсэн асар том аюул заналаас хамгаалдаг.” гэж айлдсан.

Бурханд чин бишрэлээр зүтгэх явдал нь бурханлаг үр дагавар авчрах үйлийн цорын ганц хэлбэр. Энэхүү үйлийг бид өөрсдийн өдөр тутмын, ердийн үйлүүдтэйгээ хэрхэн яаж нийцүүлэн зохицуулах талаар Бхагавад Гитад тайлбарласан байдаг.

Өдөр тутмын ердийн үйлүүдээ гүйцэтгэхтэй нийцүүлэн зохицуулагдсан чин бишрэлийн зүтгэлийг тусгай нэр томъёоны хэлээр *карма-йога* гэж нэрлэдэг. Хэрвээ чин бишрэлийн алба нь философийн гүн гүнзгий мэдлэгтэй хавсарсан байх аваас түүнийг *гьяна-йога* гэж нэрлэдэг. Харин чин бишрэлийн алба зүтгэл нь ердийн үйл ажиллагаа болон гүн гүнзгий мэдлэгийн хүрээнээс халин тэдгээрийн чанадад гарсан байх аваас түүнийг цэвэр трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах алба буюу *бхакти-йога* гэж нэрлэдэг.

Бидний энэ ертөнцөд үйлдэж байгаа аливаа үйл бүр нь тодорхой үр дагавар дагуулж авчирч байдаг. Өөрсдийн ажил үйлийн үр шимээр таашаал ханамж эдлэх явцдаа бид өөр шинэ үйлүүд хийж үйлдэж байдаг, харин тэд өөрийн ээлжиндээ араасаа шинэ үр дагавар дагуулж байдаг. Бидний үйл ажиллагаа болон түүний үр дагаврын аврага том мод ингэж л ургаж өсөж бидэнд янз бүрийн үр жимсээ өгч байдаг. Бид энэ модныхоо үр жимсийг таашаангаа түүний салаа мөчрүүдэд улам ихээр орооцолдон төөрөлдөж байдаг. Амьдралаас амьдралд өөрийн үйлийн үр дагаврыг бий болгонгоо, мөн амсаж хүртэнгээ сүнс материаллаг оршнолын гинжинд өөрийгөө оруулж хадуулж байдаг. Тэрээр амьдралын 8 400 000 хэлбэрийн аль нэгэнд хамаарагдах ямар нэгэн бие махбодийг аван төрөх бөгөөд өөрийн өнгөрсөн үеийн үйлүүдийн үр дагавруудаас шалтгаалан гарах олон тооны зовлон зүдгүүрийг амсаж туулж байдаг.

Материаллаг үйл ажиллагаа болон түүний үр дагаврын торноос мултран ангижрах нь үнэндээ боломжгүй юм. Бүхий л үйлээсээ огоорон амьдралын *санньяси*-хэвшилд амьдарч байгаа хүн ч гэсэн ядаж өөрийгөө хооллож ундлахын тулд тэртэй тэргүй ямар нэгэн зүйл хийх л хэрэгтэй болдог. Нэг үгээр хэлэхэд үйлээсээ огоорохын хэрэггүй, хамгийн наад зах нь л гэхэд өөртөө хоол унд олохын тулд хүн бүр ямар нэгэн зүйл хийх л хэрэгтэй болно.

Ийм учраас, Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Аржунад хандан: “Ай Аржуна минь ээ, өөрт оноогдсон үүргээ үргэлж биелүүлж бай. Ямар нэгэн үйл үйлдэнэ гэдэг нь үйл огт үл үйлдэхээс хавьгүй дээр. Өөрт оноогдсон үүргээ биелүүлэхээс татгалзсанаараа чи амин зуулгагүй л болно шүү дээ.” гэж зөвлөсөн.

Хүнд оноогдсон үүрэг гэдгийн доор ариун гэгээн шастирууд болон шашин номын хуулийн эмхэтгэлүүдэд зааж зөвлөсөн байдаг үйл ажиллагаануудыг ойлгодог. *Санньяси* эсвэл ид шидэт-иогчийн хуурмаг дүр эсгэн үйл үл үйлдэгч байснаас ямар нэгэн үйл эрхэлж байх нь хавьгүй дээр. Зөвхөн өөртөө хоол хүнс олохын тулд л шафран-өнгийн өмсгөл өмсөж явснаас гудамж цэвэрлэн чин шудрагаар мөнгө олон амьдралаа залгуулж байх нь илүү дээр. Энэ сургаалыг шашины өөрчлөн шинэчлэгч, аугаа гүн ухаанч-монист Шанкарачарья бид бүхэнд үлдээсэн билээ. Хэрүүл тэмцэл болон бялангач зангийн цаг үе болсон өнөө үед оноогдсон үүргээ биелүүлэхийг ертөнцөөс огоорохоос илүү дээр гэж үзэх хэрэгтэй. Ертөнцөөс үнэхээрийн огоорсон хэн бүхэн нийгэм дэх өөрт оноогдсон үүргээ эс биелүүлэх явдал нь араасаа аймшигт үр дагавар дагуулдаг гэдгийг сайн ойлгосон байдаг учраас түүнийг биелүүлэх явдлыг хэзээ ч эс тоон хайхрамжгүй ханддаггүй. Үйл бүхнээ зогсоон орхих аваас бид өөрсдийн амин чухал хэрэгцээгээ ч хангаж үл чадах тул оноогдсон үүргээ биелүүлэхээс хэрхэн татгалзаж болох билээ? Түүний зэрэгцээ, хортой буруу арга замаар үйлдсэн үйл болон түүний үр дагавар нь сүнсийг материаллаг ертөнцийн олзонд барьж байдаг гэдгийг мартаж болохгүй.

Энэ хоёрын нэгийг сонгон шийдэхэд туслах гэж Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна бидэнд: “Үнэмлэхүй Үнэн, Дээдийн Дээд Оршнол- Вишну буюу *Ягья-г* цэнгүүлэхийн төлөө өөрт оноогдсон үүргүүдээ биелүүлэх нь хамгийн сайн болой. Бусад аливаа үйл бүр нь өөрийн үр дагавраар сүнсийг боолчилдог. Өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнг *Ягья-д* зориулж байгаа хэн бүхэн материаллаг амьдралын олзноос чөлөөлөгдөн ангижирдаг.” гэж айлдсан.

Араасаа материаллаг боолчлолын үр үл дагуулах үйл ажиллагааг бурханлаг үр дагавар авчрах үйл ажиллагаа буюу *карма-йога* гэж нэрлэдэг. *Карма-йога* нь хүнийг зөвхөн материаллаг үйл ажиллагааны гав гинжнээс салган ангижруулдаг төдийгүй, мөн Бурханы Дээд Бодьгалыг бишрэх трансценденталь бишрэлийг түүнд хөгжүүлдэг. Хүн ажил хөдөлмөрийнхөө үр шимээр өөрөө таашаал ханамж эдлэхийн оронд түүнийгээ Бүхний Дээд Бурханы трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэхэд зориулан ашиглах ёстой. Энэ бол чин бишрэл дүүрэн бялхах албаны эхний үе шат. Шри Чайтанья Махапрабху Праяга-д, Дашашвамедха-гхата-гийн дэргэд Шрила Рупа Госвамитай ярилцаж байхдаа чин бишрэл дүүрэн бялхах албаны энэ аргыг тайлбарласан. Бурхан Чайтаньягийн айлдсанчлан, онцгой зол завшаан тохиож байгаа хүн л Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнагийн болон номын багшийн өршөөл нигүүлслээр трансценденталь чин бишрэл дүүрэн албаны бялхам хайрын үр хөврөлийг хүртэж чадах болмой. *Карма-йога* нь цэвэр чин бишрэл дүүрэн бялхах албаны эхлэлийн үе шат юм. Бурхан Кришна хүмүүст энэ шинжлэх ухааныг Өөрөө эсвэл Өөрийн итгэмжлэлт албатуудаараа дамжуулан нээн хүртээдэг. Өөр бусад эх булгуудаас мэдлэг олж авч байгаа хүн *карма-йогын* утга учрыг зөвөөр ойлгож чадахгүй бөгөөд *карма-йогчийн* дүр эсгэгч хүмүүст ийм явдал тохиолддог.

Бид өөрсдийн амьдралыг залгуулахын тулд мөнгө олох хэрэгтэй байдаг билээ. Мөнгөөр бид өөрсдийн амьдралд шаардлагатай зүйлс, голчлон хоол ундны бүтээгдэхүүнийг авдаг. Хэрвээ бид хэвийн хэмжээнд хооллож ундлахгүй бол бие махбодь маань сульдан доройтох болно. Бие махбодь маань сульдан доройтох аваас бид амьдралаа залгуулахын төлөө ажиллаж чадахгүйд хүрнэ. Материаллаг үйл ажиллагааны мухар эргүүлэг ингэж л бий болдог бөгөөд бид түүнд унасанаар орчлон даяар хэрэн тэнүүчилж эхэлдэг. Бид өнө эртийн цагаас л орчлонгоор нэг хэрэн тэнэж байгаа бөгөөд зэрэглээ мэт сүүтгэнэсэн аз жаргалын хойноос хөөцөлдөх явцдаа байнгад зовж зүдэрч байдаг. Бүхнээс хүчирхэг Бурханы тааллыг эс ойшоож, таашаагчийн байр суурийг зохиомлоор эдлэн байгаа сүнс нь амьдралаас амьдралдаа мөнхийн аз жаргалын хойноос тэмүүлж байдаг боловч түүнийг хаана эрж хайхаа үл мэддэг. Энэ учир шалтгаанаар Прахлада Махаража:

“Зөвхөн бүхнээс хүчирхэг Бурхан Вишнуд хүрсэнээр л дээдийн дээд ач тусыг олно гэдгийг хэн ч мэддэггүй.” гэж хэлсэн билээ.

Бид өөрсдийн жинхэнэ сайн сайхан ач тустай байдлын талаар эрэгцүүлэн бодолгүйгээр материаллаг оршнолын далай дундуур амьдралаас амьдралд ямар ч зорилгогүйгээр хэсэн тэнүүчилж байдаг. Өөрсдийн үйл болон түүний үр дагаврын давалгаанд туугдан зөөгдөж яваа бид энэхүү аюултай аялал нь ямар зовлон бэрхшээл авчрахыг ойлгож ухаардаггүй. Бидний аяллын эцсийн зорилго бол хаа сайгүй залран байдаг Бурхан Вишну, Үнэмлэхүй Үнэн гэдгийг ойлгох ёстой. Үүнийг батлан Шри Кришна айлдсанчлан, ямар ч үйл нь Вишну буюу *Ягья-г* цэнгүүлэхэд л чиглэсэн байх ёстой. Риг-Вед энэ л үнэнийг: “Вишну бол Дээд Бурхан Шүтээн, иймээс хагас бурхад нь Бурханд Өөрт нь болон Түүний бадамлянхуа өлмийд өөрсдийн хараагаа үргэлж хандуулж, ширтэж байдаг.” гэж тунхаглан зарладаг. Ведүүдийг Бурханы Дээд Бодьгал Өөрөө бүтээсэн билээ. Ингэхлээр, Бурханы айлдсан Бхагавад Гитад Ведийн бүх номлол сургаалын учир утга тусгагдсан байдаг бөгөөд үүнд эргэлзэхийн хэрэг байхгүй. Иймд, хэрвээ бид материаллаг үйл ажиллагааны мухардмал эргүүлгээс мултран гарахыг хүсэж байгаа л бол өөрсдийн аливаа үйл бүрийг зөвхөн Вишнуг цэнгүүлэхийн төлөө л үйлдэх ёстой.

Энэтхэгийн эрт дээр үеийн оршин суугчид (хэдийгээр буруу алдаатай ч тэднийг өнөө үед индусууд гэж нэрлэдэг) нь хүний нийгмийн дөрвөн анги бүлэг болон бурханлаг амьдралын дөрвөн хэвшилд хуваагддаг нийгмийн байгууллын систем *санатана-дхарма* буюу *варнашрама-дхармаг* баримталдаг байсан. Дээд ангиудын төлөөлөгчид болох *брахманууд* (оюунлаг хүмүүс), *кишатрия-гууд* (эрх баригчид, удирдагчид) болон *вайшья-гууд* (худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид) нь өөрсдийн амьдралдаа вайшнализмын зарчмыг удирдлага болгодог байв. Өөрөөр хэлбэл, тэд бүхий л үйлээ Бурханы Дээд Бодьгал, Вишнуд зориулдаг байлаа. Өөрсдийн бурханлаг хөгжлийн дөрвөн үе шатын буюу шавийн ёсны, гэр бүлийн амьдралын, үйл хэргээсээ холдон хөндийрөхүйн эсвэл ертөнцөөс огоорохуйн амьдралын хэвшлийн алинд нь ч тэр *варнашрама-дхармаг* баримтлагчид, тухайлбал гэр бүлийн амьдралаар амьдрагч хүмүүс нь Вишнуд бишрэл хүндэтгэлээ үргэлж илэрхийлж байсан. Үүнийг *брахмануудын* гэр бүлд бүр онцгойлон чухалчилдаг байлаа. Өнөөдөр ч гэсэн ийм гэр бүлүүдийн үр удам нь Вишнуг өөрсдийн гэр бүлийн Шүтээн гэж өдөр бүр бишрэл хүндэтгэлээ үргэлжлүүлэн илэрхийлж, мөргөж залбирч байдаг.

Бурханлаг хөгжил дэвшил бүхий эдгээр хүмүүс нь өөрсдийн бүхий л үйл ажиллагаагаа Вишнуд зориулдаг. Тэд өөрсдийн чадварын хирээр мөнгө олоод дараа нь түүнийгээ Түүнд үйлчлэн зүтгэхдээ хэрэглэдэг. Тэд хүнсний янз бүрийн бүтээгдэхүүн худалдаж аваад түүгээрээ Вишнуд зориулан өргөл бэлтгэдэг. Вишнуд өргөсөн зоог нь *прасада*- “Бурханы хишиг” буюу Түүний зоогийн илүү гарч үлдсэн хэсэг нь болох бөгөөд түүнийг хэн бүхэн амтархан хүртэж болох ажгуу. Өнгөрсөн үед байсан нэгэн ёс заншил өнөө үед энд тэнд уламжлагдан ирсэн байх аваас энэ нь түүнийг бүхий л хүн төрөлхтөний хэмжээнд дахин бүрэн сэргээж болно гэсэн үг. Зөвхөн цаг үе, үндэстэн ястан болон улс гүрний онцлог байдалд бага зэрэг зохицуулан тааруулаад л хэрэглэж болно. Тэгсэн цагт хүн бүр материаллаг үйл ажиллагааны торноос мултран гарах боломжтой болно.

Вишнугийн бадамлянхуа өлмийд хүрнэ гэдэг нь ангижралыг олно гэсэн үг гэж аугаа мэргэд батлан өгүүлдэг. Вишнугийн, мөн чанарын хувьд бурханлаг байдаг мэдрэхүйнүүдэд таашаал цэнгэл эдлүүлснээр буюу өөрөөр хэлбэл *карма-йогын* эрхэм дээд зорилгод тэмүүлэн хүрснээр бид өөрсдийн хэрэгцээг бүрнээ хангаж чадна. Харин бид оноогдсон үүргээ биелүүлж байхдаа Вишнуг цэнгүүлэхийг үл хичээн чармайх аваас бидний үйлдэх үйл бүр үхлийн хор бүхий материаллаг үр дагаврыг л авчрах болно. Эцсийн дүндээ эдгээр хорт үр дагавраас л болж дэлхий ертөнц бүхэлдээ эмх замбараагүй

байдалд ордог. Ажид үйлээ Вишнуг цэнгүүлэхийн төлөө явуулснаар болон Түүнд өргөсөн зоогийн илүү гарч үлдсэнийг хүртсэнээрээ бид оноогдсон үүргүүдээ биелүүлэх явцдаа үйлдсэн бүхий л нүглийнхээ үр дагавраас ангижрах болно.

Бид өөрсдийгөө нүгэл болон түүний үр дагавруудаас хамгаалан зайлуулах гэж яаж ч оролдсон бай нүгэл үйлдэхээс зайлсхийн тойрох аргагүй юм. Тэр ч бүү хэл өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулж байсан ч мөн адил. Хуульчдыг хир их худлаа ярьдаг тухай өгүүлэхийг больёо гэхэд байнгад л худлаа ярьж байдаг худалдаачдыг жишээ болгон авч болно. Өөрийн үйлчлүүлэгчлээ “хууль ёсоор” зөвтгөн цагаатгах шалтаг олох гэж зөвхөн хуульчид л арга заль гаргаж байдаг юм биш. Иймэрхүү байдлыг өөр бусад мэргэжлүүдэд ч хамаатуулан хэлж болно гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой. Хүн хүссэн ч бай, эс хүссэн ч бай ялгаагүй, араасаа байж болох бүхий л таагүй байдал болоод гай гамшигийг дагуулдаг гэдэг нь эргэлзээгүй нүгэлт үйлүүдийг үйлдэж байдаг.

Тэр ч бүү хэл ямар нэгэн нүгэл үйлдэхгүй байхыг эрмэлзэн боломжтой бүхнийг хийж байдаг ч (харин вайшнавууд, Вишнугийн чин бишрэлтэнгүүд нь үүнтэй холбогдуулан маш хянамгай болгоомжтой байдаг) бид өөрсдөө ажиглаж мэдэлгүйгээр, тухайлбал гудамжаар зүгээр явж байхдаа ч олон тооны маш жижигхэн оршнолуудыг хөнөөж байдаг. Ус ууж байхдаа бид маш олон тооны бичил биетэнгүүдийн үхлийн шалтгаан болдог. Биднийг идэж байхад, унтаж байхад эсвэл өрөө тасалгаа, гэр орноо цэвэрлэж янзалж байхад ийм зүйл мөн л болж байдаг. Иймээс бид өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж байх явцдаа санаандгүйгээр үйлдэх нүглүүдээс зайлсхийх аргагүй юм.

Нийгэмд үйлчилж байгаа хуулиар бол хүн алсан алуурчинд цаазын тавцан дээр очих аюул занал тулгарч байдаг ч амьтан хөнөөсний төлөө цаазаар авах ял шийтгэл оноодоггүй. Гэсэн хэдий ч Бурханы хуулиар амьтан хөнөөх нь хүн алсан шиг тийм нүгэлтэйд тооцогддог. Иймээс хүн алсан ч бай, мөн амьтан хөнөөсөн ч бай ялгаагүй л Бурханы өмнө хариуцлага хүлээдэг. Хүмүүс Бурханыг болон Түүний хуулиудыг оршдог гэдэгт итгэдэггүй байж болох, тэд хийсэн үйлүүдийн нь төлөө тэдэн рүү дайран довтлох тоо томшгүй олон зовлон бэрхшээлээс сургамж авалгүйгээр тийм нүглүүдийг цаашид үргэлжлүүлэн хийсээр байж болох ч, үүнээс болж Бурхан ч тэр, Түүний мөнхийн хуулиуд ч тэр, оршин байхаа зогсоож болихгүй нь лавтай.

Смрити гэж нэрлэгддэг хуулиудын эмхтгэлд, бидний хэн бүхний мэдэлгүйгээр, санаандгүйгээр үйлддэг нүглийн таван хэлбэрийг дурьдсан байдаг. Эдгээр нүглүүдэд биеэ маажих, нухах, барих эсвэл илэх, гал асаах, савнаас ус асгах болон гэр орон буюу өрөө тасалгаагаа цэвэрлэж, эмхэлж янзлах үедээ амьд оршнолуудыг хөнөөсөн нүглүүд хамаарагддаг. Бид нүгэлт үйл үйлдэхээс зайлсхийж байсан ч эдгээр таван хэлбэрийн нүгэлд тэртэй тэргүй буруутай болох бөгөөд үүнд эргэлзэх өнгө аяс ч гаргаж болохгүй. Иймээс зайлсхийх аргагүй, зориудын бус санамсаргүй нүглээсээ болж зовж шаналахгүйн тулд Вишнуд өргөсөн зоогийн илүү гарч үлдсэнээр хооллох хэрэгтэй. Энэ л учраас *санатана-дхармаг* баримтлагчдын гэр бүлд, ялангуяа *брахманы* гэр бүлийн хүмүүс Бурхан Вишнуд өдөр бүр мөргөж залбирч байдаг. Бурхан Вишнуд өргөхийн тулд биш, харин өөрийнхөө таашаал ханамжийн төлөө л хоол унд хийж бэлтгэж байгаа хүн харамсалтай нь өдөр тутмынхаа үүргийг биелүүлж байх явцдаа санаатайгаар болон санамсаргүйгээр үйлдсэн бүх нүглийнхээ төлөө шийтгэгдэх болно гэдэг нь зайлшгүй хэрэг.

Ийм учраас төр засгийн удирдлагууд болон нийгмийн зүтгэлтэнгүүд нь өөрсөддөө хийгээд өөрсдийн нь араас даган байгаа бусдадаа ач тус болох үүднээс Вишнуг цэнгүүлэхийг заавал чармайн хичээх ёстой. Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Аржунад: “Аугаа хүн ямар л үйл үйлдэж байна эгэл жирийн хүмүүс түүнийг л дагаж байдаг. Тэр юуг үнэн гэж тодорхойлном бусад нь түүнийг татгалзалгүйгээр хүлээн авдаг.” гэж айлдсан. Иймээс нийгмийн удирдлагууд нь Вишнугийн трансценденталь мэдрэхүйд

таашаал цэнгэл эдлүүлж байхаар өөрсдийн үүргээ биелүүлэн ард иргэддээ зохистой үлгэр дууриал үзүүлж байх ёстой.

Гэхдээ, харамсалтай нь бид, араас нь эгэл жирийн хүмүүс дагалдан байгаа удирдагчид нь сэтгэл зүрхнийхээ гүнд бурхангүйн үзлийг агуулдаг хийгээд Бурханы хуулиудын үл хүлээн зөвшөөрдөг тийм л цаг үед амьдарцгааж байна. Ийм хүмүүс Вишнуг цэнгүүлж чадна гэж үү? Хэрвээ тэд Бурханы трансценденталь мэдрэхүйд таашаал цэнгэл үл эдлүүлэх аваас тэд өөрсдөө болон тэдний дагалдагчид нь өөрсдийн оноогдсон үүргээ биелүүлэх явцдаа бузартсан нүглээсээ хэрхэн яаж салан ангижрах болж байна вэ? Нийгмийн удирдагчид нь хаа сайгүй орших бодьгал бус төлөв хийгээд Бүхний дээд трансценденталь бодьгал дүрдээ нэгэн зэрэг залран байх бүхнээс хүчирхэг Вишнугийн оршин байгааг эс хүлээн зөвшөөрөх аваас эгэл жирийн хүмүүс Түүний тухай юу мэдэж чадах билээ дээ? Вишну бол оршин буй бүхний цорын ганц Эзэн, иймээс бидний хэн нь ч хичнээн ч аугаа байсан бүх материаллаг мөн чанарыг таашаан ханамж эдэлж чадахгүй. Иймд бид бүгдээрээ бүхний дээд эзэн Бурхан Вишнугаас бүрнээ хамааралтай байдаг. Бид зөвхөн Түүний бидэнд Өөрийн ивээл, эзэнэгтэйн тэмдэг болгон хүртээж байгаа тэр л зүйлийг ашиглаж болохоос биш, Түүнд эсвэл өөр хэн нэгэнд харьяалагдах зүйлийг авна гэж оролдох ёсгүй билээ. Вайшнавизмын үзэл санаа ийм байдаг.

Энэ тухай Ишопанишад-д: “Орчлонгийн бүхий л зүйлс Бүхний Дээд Таашаан Цэнгэгчид харьяалагддаг билээ. Чухам ийм учраас бид Түүний өршөөн соёрхож хувь болгон ноогдуулсан тэр л зүйлийг ашиглаж болохоос биш өөр бусдад хамаарах зүйл рүү ямар ч тохиолдолд санаархан өнгөлзөж үл болно.” гэж өгүүлсэн байдаг.

Улс төрийн болон бусад удирдагчид нь өөрсдийн үйл ажиллагаагаа Вишнуд хандуулах ёстой. Түүнийг биширч шүтсэнээрээ тэд өөрсөддөө төдийгүй мөн өөрсдийн талынхандаа ач тусыг хүргэх болно. Төр засгийн удирдлагууд хийгээд шашины номлогчдыг оролцуулаад нийгмийг удирдан жолоодогчид нь вайшнавизмын үзэл санааг баримтлан дагахын оронд өөрсдөө таашаан цэнгэгчийн байр суурь буюу Вишнугийн эрхэм дээд байр суурийг эзлэхийг оролдох аваас тэд алдар цуу, нэр хүнд болон эд баялаг зэрэг зөвхөн цаг зуурын ач тусыг л хүртдэг, харин тэдний урагш муутай дагалдагчид нь тэдний хуурмаг, ёс төдий бие хайргүй зүтгэлд нь хууртагдан төөрөлддөг. Иймэрхүү бурхангүй- удирдагчид нь өөрсдийнхөө араас дагалдан буй, нядалгааны газар луу явж буй хонин сүрэг мэт харанхуй мунхаг сүнснүүдэд ач тус хүргэж чаддаггүй. Тэдгээр удирдагчид нь засгийн эрхэнд байх хугацаандаа ямар нэгэн тус шимийг хүртэж байдаг ч, тэдний дагалдагчид нь нэн дорой буурай байдалтай байдаг нь ердийн үзэгдэл. Нийгмийн удирдагчид нь өөрсдийн талынхнаа цаг зуурын зорилгодоо хүрэхэд уриалж байхдаа тэднийг нүгэлт үйлийн бүхий л хэлбэрүүд рүү татан оруулж байдаг. Тэд өөрсдийгөө ямар нэгэн ач тустай зүйлээр хангахаар эрмэлзэн зорьж байхдаа өөрсдийн харьяат ард иргэдийн амин чухал сонирхолыг нь золиосонд гаргаж байдаг ба ингэснээр тэдэнд маш их хохирол хөнөөл учруулдаг.

Иймэрхүү удирдагчид нь өөрсдийн мөнх бус бие махбодийн үхэлтэй хамтаар хуримтлуулж хураасан цаг зуурын эд зүйлс бүхэнд нь мөн л төгсгөл ирдэг гэдгийг ойлгодоггүй. Гэхдээ тэдний бүхий л амьдралынхаа туршид үйлдсэн үйлүүд нь ухаан, оюун ухаан болон хуурамч эгоны нарийн бүрхүүлд үл үзэгдэх байдлаар хадагдан үлддэг бөгөөд энэ бүрхүүл нь сүнсний хамтаар дараагийн бие махбодид шилжин орох үед тэд нар материаллаг үйл ажиллагааны мухар эргүүлэгт дахин эрсдэн унадаг ба тоо томшгүй олон жилийн туршид нэг бие махбодиос нөгөө бие махбодид шилжин явахаар тулгагдсан, гарцаагүй байдалд ордог. Эгэл жирийн хүмүүсийн хувьд гэвэл тэд өөрсдийн мунхаг удирдагчдын уриалан, шаардсан бүхнийг цаашид үргэлжлүүлэн хийсээр байдаг.

Иймээс нийгмийн удирдагчид нь мөн чанарын нарийн хуулиудын, тухайлбал кармын хуулийн талаар мэдэж байх ёстой бөгөөд тэд өөрсдөөс нь хамаар ч байдаг бүхэнд яаж ач тус хүргэж болох талаар нарийн тодорхой ойлголттой байх шаардлагатай. Энэ нь,

юуны өмнө төр засгийн удирдлагууд нь бурханлаг үр дагавар дагуулах үйл ажиллагаа буюу *карма-йогын* аргыг судлах, түүнийг бодит амьдралд хэрэгжүүлэх ёстой гэсэн үг юм. Тэгсэн цагт тэд хүмүүст ач тусыг үнэхээрийн хүргэх болно. Эмч өөрөө өвчтэй байх аваас бусдыг хэрхэн эмчилж анагаах билээ дээ? Эхлээд өөрөө өвчнөөсөө эдгэрч илаарших ёстой. Тэгээд дараа нь бусдыг эмчлэх хэрэгтэй. Мөн, эмч хүн өвчтөнийхөө хүсэл зоргоор байх ёсгүй. Жинхэнэ туршлагатай эмч нь өвчтөний янгууч занг гүйцэлдүүлэхийн оронд, шаардлагатай эмийг нь түүнд таалагдах, эс таалагдахаас үл хамааран бичиж өгдөг.

Ихэнх хүмүүсийн гол өвчин бол бүхнээс хүчирхэг Бурхан Вишнуд үйлчлэн зүтгэхийг хүсдэггүйд оршдог гэдгийг нийгмийн удирдагчид ойлгож байх ёстой. Харин эдгээр удирдагчид нь өвчний шалтгаан болох бурхангүйн үзлийг үндсээр нь таслан хаяхын оронд түүний илрэх шинж тэмдэгүүдэд цаашдаа хөнгөн хуумгай, өнгөцхөн амирлангуй байдалтайгаар хандсаар байх аваас зовж шаналж байгаа хүн төрөлхтөн ямар ч тайвшрал хөнгөрлийг олохгүй. Бурханд өргөсөн зоогийн илүү гарч үлдсэн нь иймэрхүү өвчнүүдийг анагаах туйлын сайн хоол болох учраас зөвхөн түүнийг хүртсэнээр л энэ өвчнийг эдгээн илааршуулж болно. Харин эм нь бол Бурханы тухай яриа хүүрнэлүүдийг сонсох болон Түүнийг магтан дуулж алдаршуулах, мөн Түүний тухай санаж бодох, Түүний шүтээн-дүрд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх, Түүнд трансценденталь алба өргөх, Түүнийг өөрийн дээдийн дээд найз нөхөр байдлаар хүлээн авах болон төгсгөлд нь Бурханд үг дуугүй, ямар ч хэлэлцээнгүйгээр өөрийгөө даатгах явдал байдаг. Хэрвээ удирдагчид нь хүмүүсийг зовлон зүдгүүрээс ангижруулахыг үнэхээрийн хүсэж байгаа л юм бол дурьдсан цагаан хоолны дэглэмийг баримтлан, эдгээр эмүүдийг хүлээн авж, хэрэглэх боломжийг тэдэнд олгох ёстой.

Дэлхий дахины байдлыг төгөлдөржүүлэх арга замыг олохыг болон огоорохуй, тэвчээр, ёс суртахууны зарчмуудыг баримтлахыг хийгээд мөн өөр бусад зүйлсийг номлохыг үнэхээрийн чармайж байдаг Махатма Ганди шиг ухаан суусан хашир туршлагатай удирдагчдыг зохих ёсоор үнэлэх хэрэгтэй. Гэхдээ хүмүүс бидний бодож олсон бүхий л аргууд нь хязгаарлагдмал байдгийн зэрэгцээ мөн төгс төгөлдөр бус учраас өөрсдийн бодож олсон иймэрхүү аргуудын тусламжтайгаа цаглашгүй Үнэнд хүрэхийн аргагүй. Ийм учраас, Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Бхагавад Гитад, жинхэнэ цэцэн мэргэн хүн олон амьдралын дараагаар Түүнд өөрийгөө даатгадаг бөгөөд оршин байгаа бүхнийг Васудеватай (Вишнугийн бүрэн хувилгаан) холбоотойгоор харах чадвартай ийм *махатма* маш ховор гэж айлдсан байдаг. Ийнхүү батлан айлдсаны учир нь ердийн *махатма-ууд* хаа сайгүй олон байдаг ч, илэрч тодорсон дэлхий ертөнц нь Бурхантай ямар холбоотойг байдгийг үнэхээрийн ойлгож ухаарсан жинхэнэ *махатма* нэн ховор байдаг гэдэгт оршино.

Ийм *махатма-ууд* нь танин мэдэхүйн нэгтгэн дүгнэж ургуулан бодох (индуктив) арга дээр үндэслэн бодож олсон аргуудын тусламжтайгаар Бурханд ойртохыг хэзээ ч оролддоггүй. Харин түүний оронд дедуктив буюу жинхэнэ эх сурвалжаас хүртэх аргыг сонгон нэг бол Бүхний Дээд Бурханаас Өөрөөс нь, эсвэл Түүний жинхэнэ элч төлөөлөгчөөс эх авсан мэдлэгийг хүртдэг. Хүн нэгтгэн дүгнэж ургуулан бодох аргын тусламжтайгаар Бурханыг ойлгох гэж хичнээн ч цаг хугацаа зарцуулсан бай, түүний хүчин чармайлтууд нь хүссэн үр дүнд нь хүргэхгүй. Ийм байдлаар хүртэж болох цорын ганц зүйл бол Үнэмлэхүй Үнэний бодьгал бус төлвийн тухай төгс төгөлдөр бус хийгээд бүрэн бус мэдлэг юм. Энэ мэдлэгийг эцсийн эцэст, чухамдаа Түүнээс л хүртдэг.

Гандигийн номлол нь иймэрхүү төгс төгөлдөр бус байдалд нэрвэгдсэн байдаг. Хэдийгээр Рама Бурханы нэр алдрыг давтан хэлдэг ч тэрээр ариун гэгээн нэр алдрын тухай бурханлаг шинжлэх ухаанд боловсроогүй нэгэн билээ. Тэр бодьгал бус Бурханыг шүтдэг. Өөрөөр хэлбэл, тэр Бурхан бол бишрэл хүндэтгэлээ бодитойгоор илэрхийлэхүйц бурханлаг бодьгалын шинж чанаргүй байдаг учраас Тэр зоогийг болгоон таалах, харах эсвэл сонсох чадваргүй гэж үздэг. Имперсоналист-философичид нь Үнэмлэхүй Үнэнийг

ухаарах гэсэн өөрсдийн оролдлого чармайлтаараа Бурханы зөвхөн бодьгал бус төлөвт л хүрч чаддаг, иймд тэд Түүний бурханлаг зугаа наадмуудын тухай юу ч үл мэднэ. Үнэмдэхүй Үнэнийг трансценденталь мэдрэхүйгүй гэж боддог хүмүүс нь Түүнийг хүч тамиргүй, арга ядсан байдалтай байдаг гэж үздэг. Харин хүч чадал тамир тэнхээгүй тэдний Бурхан шүтэн бишрэгчдийнхээ залбирлыг мэдээжийн хэрэг хэзээ ч сонсохгүй бөгөөд дэлхий ертөнцийн зовлон шаналалыг нимгэлж хөнгөрүүлж чадахгүй.

Эмпирик-философийн задлан шинжлэх арга нь хамгийн сайндаа л судлагчдад метафизик объектыг фикик объектоос ялгаж салгах боломжийг олгодог, гэхдээ хүн Үнэмлэхүй Үнэний бодьгал мөн чанарыг ойлгож ухаараагүй байгаа цагт Тэр түүнд Өөрийгөө бодьгал бус төлөвөөрөө л илрүүлж таниулдаг. Харин Түүний талаархи ийм хуурай ойлголт төсөөлөл нь бодитой бурханлаг ач тус авчирдаггүй. Ийм учраас Гандитай адил төстэй удирдагчид нь өөрсдөө Үнэмлэхүй Үнэний буюу хаа сайгүй залрах Бурхан Вишнугийн бодьгалын мөн чанарын ойлголтод баттай итгэлтэй болж байж бусдыг Түүний трансценденталь албанд *карма-йогын* үзлээр татан оруулах ёстой. Тэгсэн цагт л тэд бүх нийтэд ач тус үзүүлж, хүргэж чадна.

Ихэнх хүмүүс нь материаллаг бие махбодь болон ухаантай холбогдсон үйл хэрэгт автсан байдаг. Материаллаг үйл ажиллагааны нэн доод түвшингүүдэд орших хүмүүс бурханлаг үйлийн учир утга, ач холбогдлыг ойлгох нь хүнд байдаг. Ийм хүмүүсийн аливаа нүгэлт муу болоод буянт сайн үйл ажиллагаа нь өөрсдийн мөнх бус бие махбодь болон ухаанаа зовлон бэрхшээлээс хэрхэн яаж холдуулан зайлуулах болон хоол унд, нойр, өөрийгөө хамгаалах хийгээд мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхээс аль болох их ханамж авахад л чиглэгдсэн байдаг учраас тэд ерөнхийдөө аливаа эхлэл санаачлага бүртээ ялагдал хүлээж байдаг.

Материаллаг эрдэмтэд буюу материаллаг үйл ажиллагааг хөхүйлэн урамшуулагч шинжлэх ухааны орчин үеийн шүтэн бишрэгчид нь харах, үнэрлэх, сонсох, хүртэх, амтлах болон мөн ухаан зэрэг материаллаг мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэхийн тулд байж болох бүхий л зүйлийг сэдэж зохиож байдаг. Энэ нь материаллаг аз жаргалын төлөөх учир утгагүй тэмцэлд хүргэж хүмүүсийн дунд дайсагналын галыг асааж байдаг. Хоол хүнс, үнээ болон хувцас хунар зэрэг хамгийн хэрэгцээтэй зүйлс ч хаа сайгүй дутагдан хэцүү бэрх болж байгаа бөгөөд үүнээс улбаалан эцэс төгсгөлгүй хэрүүл тэмцэл дэгдэн гарч, зарим хүмүүс нь бусдынхаа хамаарал харьяалалд орж байна. Бурханы бидэнд номлон сургасан уламжлалт, энгийн амьдралд болоод илүү эрхэм дээдээр сэтгэх түвшинд хүрэх замд олон янзын саад бэрхшээл ингэж л үүсэн бий болж байна.

Үгширмэл материалистуудаас арай илүү дээд түвшинд орших хүн үхлийн дараа амьдрал байдаг гэдэгт хатуу итгэдэг бөгөөд өөрийн өнөөгийн амьдралдаа бүдүүлэг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх түвшингөөс өндийн босож дээшлэхийг хичээн чармайж байдаг. Хүн хожим хойно өөрийн хүслээр зарж үрэх гэж мөнгөө банкинд хадгалуулж байдагтай адилаар ийм хүмүүс нь дараагийн амьдралдаа таашаал цэнгэл эдлэх боломжтой болох гэж буянтай сайн үйлүүдийг аль болох ихээр үйлдэхийг хичээж байдаг. Тэгсэн хэдий ч тэд, буянтай сайн үйлдлүүд ч тэднийг кармын үйлийн гав гинжнээс чөлөөлөн салахад тус нэмэр болдоггүй гэдгийг ойлгодоггүй. Урьд өмнө тайлбарласанчлан, буянтай сайн болон нүгэлтэй муу үйлүүд нь хүнийг үйл болоод түүний үр дагаврын эргэх хүрдэнд бөх батаар барьж байдаг.

Хүн нүгэлтэй ч бай, эсвэл буянтай ч бай ялгаагүй, материаллаг л бол *карма-йога* нь сүнсийг түүний хувьд мөнхөд элэг буруу, харийн байдаг материаллаг үйлийн боолчлолоос чөлөөлөн ангижруулах арга зам мөн гэдгийг ойлгодоггүй. Иймээс хашир туршлагатай *карма-йогч* нь гадна өнгөн талдаа материаллаг зүйлст бүрнээ автан татагдсан юм шиг байдалтай өөрийгөө авч явдаг хэдий ч энэ үедээ өдөр тутмын үйл хэргээ эрхлэн явуулангаа нарийн төвөгтэй үйл ажиллагаа болон түүний үр дагавраас хэрхэн яаж мултран ангижрахыг эгэл жирийн энгийн хүмүүст харуулахын тулд өөрийн ажил

хөдөлмөрийн үр шимийг Вишнуд зориулж байдаг. Энэ байдал нь *карма-йогч*-д өөрт нь болон өөр бусад бүгдэд ач тусыг үзүүлдэг. Бурханы Дээд Бодьгал Бхагавад Гитагийн (3.25)-д: “Ай Бхаратын үр удам минь ээ, өөрт оноогдсон үүргээ, трансценденталь мэдлэгийг үл мэдэх хийгээд үйлийнхээ үр дүндээ бүрнээ дурлан татагдсан энгийн материалист лугаа биелүүл. Хүмүүсийг *карма-йогын* зам мөрт ингэж байж л татан оруулж болно.” гэж айлдсан.

Бурханлаг мэдлэгийг үнэхээрийн хүртсэн хүмүүс бие махбодь болон ухаанаа тэтгэхэд хэрэгтэй бүхнийг зөвхөн, Бүхний Дээд Бурхан Вишнугийн трансценденталь мэдрэхүйг цэнгүүлэхийн тулд л хийж байдаг Үнэн хэрэгтээ, эдгээр трансценденталистууд нь материаллаг олз ашгийн л төлөө ажиллаж байдаг хүмүүсээс ялгаатай байдаг ч хүмүүс ийм эрдэм мэдлэгтэй трансценденталистуудыг эгэл жирийн энгийн хөдөлмөрчид гэж бодоцгоодог. Тэд бол *карма-йогчид*, тэд бол бурханлаг зорилгын төлөө ажиллаж байдаг. Ийм бурханлаг үйл ажиллагаа эрхлэн байгаа хүн ямар ч нэмэлт хүчин чармайлт үл гаргангаа материаллаг ач тусыг хүртэж байдаг нь жам ёсны хэрэг бөлгөө.

Өнөөгийн энэ цаг үед материаллаг үйл ажиллагааны хэлбэр, хүрээ үзэгдэж харагдахгүйгээр, гайхмаар хурдан өргөжин тэлж байгааг бид ажиглаж байна. Энэ дэлхийд тоо томшгүй олон үйлдвэр, эмнэлэг болон өөр бусад, байж болох бүхий л байгууллагууд бий болж байна. Өнгөрсөн цаг үед материаллаг үйл ажиллагаа ийм их хөгжсөн байгаагүй. Өнө эртийн цагт хүмүүсийн амьдрал энгийн даруу, харин сэтгэхүй нь эрхэм дээд түвшинд байсан. Тийм болохоор, одоо *карма-йогчдын* өмнө үйл ажиллагааны өргөн талбар нээгдэж байна. Тэд орчин үеийн соёл шинжлэх ухааны ололт амжилтыг Вишнугийн трансценденталь албанд ашиглах болсон бөгөөд ингэснээрээ тэд Түүнийг цэнгүүлж байдаг.

Карма-йогын санаа байдалтайгаар Үнэмлэхүй Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх тэр л зорилгоор, эртний мэргэдийн энэ талаар зөвлөсөнчлөн, үйлдвэр бүр дээр, байгууллага бүр дээр, мөн тэрчлэн айл гэр бүрт Вишнугийн сүм заавалгүй байх ёстой. Хаа сайгүй залрах Бурханы Бодьгал нь Өөрийгөө олон янзын бүрэн болоод хэсэгчилсэн трансценденталь дүрүүдэд илрүүлэн тодруулж байдаг ч мөнхийн бурханлаг Хосууд болох Шри Шри Лакшми-Нараяна, Шри Шри Сита-Рама, Шри Шри Радха-Кришна дүрээр илрэн залрах Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байхыг мэргэд зөвлөдөг. Иймээс бид, энэ Хосуудын аль нэгэнд нь бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх сүм байгуулахыг бүхий л үйлдвэр, эмнэлэг, их дээд сургууль болон зочид буудлын удирдагчдад болон эздэд нь гүнээ сайшаан зөвлөж байна. Тэгсэн цагт эзэд өөрсдөө болон тэнд ажилладаг бүх хүмүүс *карма-йогчид* болцгооно.

Томоохон үйлдвэрүүдийн ажилчид нь хор уршиг бүхий буруу дадал зуршлуудтай байдаг нь ердийн үзэгдэл бөгөөд үүнээсээ болж тэд хүний амьдралын хамгийн доод түвшин, ёроол руу аажим аажмаар гулсан унаж байдаг. Гэхдээ тэдэнд Вишнуд өргөсөн зоогийн илүү гарч үлдсэнээс хүртэх боломж олгох аваас цаг хугацааны явцад тэдний амьдрал төгөлдөржин, эрхэм дээд трансценденталистуудын түвшинд хүртэл дээшлэнэ. Нөгөө талаас, эдгээр хүмүүст энэхүү нэр хаягийг зүгээр л зүүгээд байсан байлаа ч тэд *харижан* буюу “Бурханы хүмүүс”-ийн өндөр дээд байр сууринд хэзээ ч хүрэхгүй. Хэрвээ тэд Вишнугийн трансценденталь албаас гадуур ангид өөр зүйлийг хүсэх аваас тэднийг дээшлүүлэх гэсэн бидний оролдлого маань зөвхөн таагүй байдлыг л авчрах бөгөөд тайван амгалан байдал болон нийгмийн эмх журмыг алдагдуулах болно. Цаг зуурын ямар нэгэн зорилгод хүрэхийг эрмэлзэн, өөрсдийн ажилчдын хор хөнөөлтэй дадал зуршлуудыг өөгшүүлэн дэмжиж байгаа удирдагчид нь тэдэнд ямар ч ач тусыг хүргэж, үзүүлж чаддаггүй. Тиймээ, тэдгээр удирдагчид нь иймэрхүү бодлогогүй үйлээсээ өөрсдөө ч ямар ч ач тусыг олохгүй. Харин ч эсрэгээр, ажилчдын болон эзэд хөрөнгөтнүүдийн иймэрхүү зан байдал нь тэдний хооронд буюу нийгэмд ихээхэн таагүй байдал авчрах тойрч зайлж

гарахын аргагүй зохисгүй сөргөлдөөнд хүргэж болно. Энэ асуудлыг зөвхөн ганцхан буюу бүх эргэлзээ тээнгэлзээгээ таягдан хаяад *карма-йогын* аргуудыг самбаачлан ашиглах замаар л шийдвэрлэж болно. Хүмүүс бурханлаг үр дагавар дагуулах үйл ажиллагаа буюу *карма-йогын* зарчмуудыг системтэйгээр мөрдөн баримтлах аваас үр дүн нь хүлээж байснаас ч илүү гарч, социалистууд, большевикууд эсвэл лейбористуудын бүх нийтийн эрх тэгш байдал, бүх дэлхийн хамтын ажиллагаа эсвэл ажилчид нь хөрөнгөтнүүдээс баян чинээлэг байх, газар дэлхий дээрх диваажинг байгуулах гэсэн салангид, ижил буруу оролдлогуудын хүрэх амжилт ололтоос илүү ихэд хүрнэ.

Хүмүүсийн хоорондын ах дүүгийн харьцаа нь аажим аажмаар гүнзгийрэн хөгждөг бөгөөд өөрийгөө хайрлах хайр нь гэр бүлээ хайрлах хайранд, гэр бүлээ хайрлах хайр нь нийгэмлэг хүрээгээ хайрлах хайранд, нийгэмлэгээ хайрлах хайр нь үндэстэнээ хайрлах хайранд шилжин хувирдаг. Харин үндэстэнээ хайрлах хайрнаас бүхий л хүн төрөлхтөнийг хайрлах хайр хөгжин бий болдог. Энэхүү шат дараалсан үйл явцын цаана ямар нэгэн нэгдсэн зүйл далдлагдаж байдаг бөгөөд түүний ач тусаар л бидний хайр нэг түвшингөөс нөгөөд гэх мэтчилэн хөгжиж байдаг. Гэвч, бүх нийтийн ах дүүгийн барилдлагаа, нөхөрлөлд хүрэх гэсэн эцэс төгсгөлгүй хүчин чармайлтад бидний бүхий л ойртон татагдахуйн төв нь гэр бүл биш, нийгэмлэг хүрээлэл ч биш, үндэстэн ч биш, тэр ч бүү хэл хүн төрөлхтөн ч биш, харин хаа сайгүй залрах Бурхан Вишну байдаг гэдгийг бид ойлгож ухаардаггүй. Үүнийг мэдэхгүй байхын учир шалтгаан нь бид Үнэмлэхүй Үнэний хий хуурмагийн, материаллаг эрчмийн харанхуйд бүрхэгдэн хучигдсан байдаг оршдог. Аугаа чин бишрэлтэн Махаража Прахлада энэ тухай батлан өгүүлсэнчлэн, эгэл жирийн энгийн хүмүүс нь амьдралын эцсийн зорилго бол Бурханы Дээд Бодьгал Вишну байдаг гэдгийг мэддэггүй. Бурханы бүхий л дүрүүдээс сэтгэл зүрхийг хамгийн ихээр татдаг нь Шри Кришна.

Кришна гэдэг үгийн үндэс *кри* нь “өөртөө татагч” гэсэн утгыг илэрхийлдэг. Тэгэхлээр, Дээдийн Дээд Үнэмлэхүй Үнэн Бурханд “Бүхнийг татагч” буюу Кришнагаас өөр ямар алдар байж болох билээ. Мэргэд гүн гүнзгий судалгаа явуулан, Кришна бол Бүхний Дээд Бурхан гэж тогтоосон. Наймишараньягийн ойд (Ситапур, Уттар-Прадеш тойрогт орших одоогийн Нимсар) Сута Госвамигаар ахлуулан цугларсан мэргэдүүд Үнэмлэхүй Үнэний хувилгаан дүрүүдтэй холбогдсон бүгдийг тодорхой хэлэлцсэн. Тэд, Кришна бол Бурханы Дээд Бодьгал, харин бусад хувилгаан дүрүүд нь нэг бол Түүний бүрэн хувилгаан дүр, эсвэл бүрэн хувилгаан дүрийн хэсэгчилсэн хувилгаан дүрүүд байдаг гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Шри Кришна бол Бүхний Дээд Бурхан. *Бхагавата-ын* номлол сургуулийн трансценденталистуудын санаа бодол ийм байдаг. Мөн үүнийг батлан манай орчлонгийн бүтээгч Брахма-ын өөрийн нь залбирал болгон хэлсэн “Брахма самхита”-д: “Шри Кришна бол Бурханы Дээд Бодьгал, Түүний бурханлаг дүр нь мөнх бөгөөд мэдлэг хийгээд цэнгэл баяраар дүүрэн бялхаж байдаг. Тэр бол анхдагч бодьгал бөгөөд Говинда гэж нэрлэгддэг. Түүнд эхлэл гэж байдаггүй. Гэхдээ тэр бүх эхлэлийн эхлэл бөлгөө.” гэж өгүүлсэн байдаг. Иймээс ойр тойрныхонтойгоо харьцаж байгаа бидний харьцаа дурлан татагдахуйн үндсэн объект болох Шри Кришнаг хайрлах хайр дээр үндэслэгдсэн зөвхөн тэр цагт л бүх нийтийн адил тэгш байдал болон ах дүүгийн барилдлагааны үзэл санаа нь бат бэх энх тайван, амар амгаланд хүрэхэд бидэнд бодитойгоор туслана.

Энэ байдлыг төрөл төрөгсөдийн харьцаан дээр жишээ болгон тайлбарлаж болно. Миний эгчийн нөхөр, жишээлбэл эгчтэй минь гэрлэх хүртэл миний хувьд тэр гаднын хүн байсан. Харин одоо миний эгч түүний эхнэр болж, бидний харьцааны төвд орсоноор би түүнийг хүргэн ахаа гэж үздэг. Энэ шинэ харьцааны тусаар түүний охид хөвгүүд нь мөн л миний төрөл садан болсон. Одоо бол тэд миний үеэлүүд билээ. Миний эгч бидний хувьд адилхан, хайрын объект болсон учраас бидний төрөл садангийн халуун дотно харьцаа үүссэн хэрэг. Яг үүнтэй адилаар, бид өөрсдийн ашиг сонирхлын төвөөр өөрийн улс орноо болгох аваас бид өөрсдийгөө үүгээрээ хязгаарлан бусдаас тусгаарлан, бид бол

“бенгалчууд”, бид бол “пенжабууд” эсвэл бид бол “англичууд” гэж нэр шошгыг өөрсөд дээрээ нааж зүүцгээж байдаг. Хэрвээ бид, ямар нэгэн итгэл бишрэл буюу шашиныг шүтэн түүнд өөрсдийн ашиг сонирхолоо төвлөрүүлэх аваас өөрсөдөө ”индиуст”, “мусульман” эсвэл “Христэд итгэгч” гэсэн аль нэгэн шашины бүлэглэлийн хаяг шошгыг зүүцгээх болдог. Ингэж л бид бусад олны хувьд ямар ч хүсэл сонирхолгүй байх зүйлд дурлан татагдаж байдаг учраас тэд бидэнтэй бидний ийнхүү татагдан байгааг хуваалцаж чаддаггүй.

Бид өөрсдийн хүсэл сонирхолоо бүхнийг татагч Бурханы Дээд Бодьгал Кришнад төвлөрүүлсэн цагт л хүмүүстэй харьцах бидний харьцаа төгс төгөлдөр болно. Кришна бол анхдагч амьд оршнол, энэ нь Тэрээр хэн бүхний хувьд хайрын нь төвлөрөл байдаг гэсэн үг мөн учраас бид мөн чанарын хувьд Кришнаатай мөнхөд холбогдсон байдаг. Ийм учраас Кришнагаас биднийг салган тусгаарлаж байгаа хийгээд бидний мэдлэгийг бүрхэгдүүлэн харанхуйлах хий хуурмагийн эрчим *майа-гийн* нөлөөнөөс болж түр зууртаа мартагдсан байх энэхүү харьцаагаа дахин сэргээх хэрэгтэй. Кришнаатай холбогдсон мөнхийн харьцаа холбоогоо дахин сэргээхийн тулд бид *карма-йогын* аргыг ашиглах хэрэгтэй бөгөөд ингэснээрээ бид бурханлаг танин мэдэхүйн зам мөр дээр эхний алхамаа хийж байгаа хэрэг болно.

Карма-йогын зам мөрөөр замнаж байгаа хүн Кришнаатай холбогдсон трансценденталь харьцаагаа сэргээхэд нь хэн бүхэнд туслах чадвартай байдаг. Ийм трансценденталь харьцааны гол учир утга нь Кришнагийн мөнхийн чин бишрэл дүүрэн бялхах албанд зүтгэхэд оршдог. *Карма-йога* нь энэхүү аугаа их ач тусыг материаллаг үйлд автсан байх эгэл жирийн энгийн амьд оршнолуудад, тэднийг заншиж дадсан үйлээс нь салгаж хөндийрүүлэлгүйгээр хүртээдэг. Урьд өмнө дурьдсанчлан, Кришна Бхагавад Гитад, материаллаг ухаан бодолтой хүмүүсийг дадаж сурсан сонирхолтой ажил үйлээс нь хориглон болиулахыг зөвлөдөггүй. Харин ч эсрэгээр, ийм үйлийг *карма-йогын* гольдрол руу чиглүүлэнгээ, түүнийг дэмжиж болно.

Ер нь материаллаг ухаан бодолтой хүмүүс нь хий хуурмагийн эрчмийн нөлөөнөөс болж өөрсдийгөө Кришна гэж үздэг учраас тэдний хувьд Кришнаатай холбогдсон мөнхийн холбоогоо ойлгоход хүнд байдаг. Өөрсдийн нь хувьд жам ёсны бус болох Бүхний Дээд Таашаагчийн байр суурийг эзэлснээр ийм хүмүүс байгалийн хүчийг өөрсдийн эрхшээлдээ оруулахыг оролдож байдаг. Ингэх нь тэдэнд улам их зовлон зүдгүүрийг учруулж байдаг ч хүрээлэн байгаа дэлхий ертөнцийг ноёлон захирах гэсэн хүсэл эрмэлзлээсээ салдаггүй. Харин урам хугаран итгэл алдарсан цагтаа тэд улам илүү урам зоригтойгоор таашаал ханамж эдлэхийн тулд бүхий л таашаал ханамжаас татгалзсан дүр эсгэн, ертөнцөөс хуурмагаар огоордог. Өөрсдийн ажил хөдөлмөрийн үр шимээр таашаал ханамж эдлэхийг хичээн чармайж байгаа материаллаг хүмүүс нь тээрмийн чулуу эргүүлж байгаа хувь тавилан муутай шар лугаа тэсвэрлэхийн аргагүй зовлон шаналалыг амсаж эдэлж байдаг. Гэвч *майа-гийн* үлээж сэвшээлгэн байгаа хий хуурмагийн нөлөөн доор тэд өөрсдийгөө үнэхээрийн таашаал ханамж эдэлж байна гэж бодож байдаг. Ийм учраас, цэцэн мэргэн *карма-йогч* нь мунхаг материалистуудыг өдөөн төвөг учруулалгүйгээр тэдний дуртай ажил үйлийг тактикийн зорилгоор эрхлэн явуулж байдаг ч энэ үйлээ Кришнаатай холбоотойгоор үйлдэж байдаг. Энэ учраас, Кришнын мөнхийн албат болох цэцэн мэргэн ангижирсан сүнснүүд нь оюунлаг бус материалистуудад *карма-йогын* арга замыг сургангаа заримдаа өдөр тутмын ердийн үйл ажиллагааны хамгийн гүнд нэвтрэн орж байдаг.

Шри Кришна болон Аржуна шиг Түүний мөнхийн бараа бологч дагуулууд нь *карма-йогын* аргыг хэрхэн яаж хэрэглэхийг өөрийн үлгэр жишээгээр үзүүлэхээр өөрсөд дээрээ дааж авахгүй л бол оюунлаг бус материалистууд нь учир утгагүй үйлтэй зууралдсаар мунхагийн харанхуйд үлдэх байсан билээ. Оюун ухаанаа орхин гэсэн эгэл хүмүүс нь материаллаг зорилгуудад хүрэх зам нь даван гэтлэхийн аргагүй саад тотгороор

хаагдсан байдаг гэдгийг ойлгодоггүй. Гаргаж буй хүчин чармайлтынх нь үр дүн өөрсдөөс нь бүрэн хамаардаг гэж хичнээн итгэлтэй байсан ч тэд тэртээ тэргүй мөн чанарын *гунуудын* нөлөөн доор хийж үйлдэх л хэрэгтэй болдог. Шри Кришна Бхагавад Гитад ийм л дүгнэлт хийсэн байдаг. Тэрээр, ухвар мөчид материалистууд нь мөн чанарын *гунууд* тэднийг нэг бол энэ эсвэл тэр үйлийг үйлдэхийг албадаж байдаг гэдгийг мэдэлгүйгээр хуурамч эгоны нөлөөн доор өөрсдийгөө өөрсдийн үйлийн учир шалтгаан гэж үзэж байдаг хэмээн айлдсан байдаг. Иймэрхүү тэнэг мунхаг хүн хүссэн бүхнээ үйлдүүлэхээр түүнийг албадаж байдаг, Бурхан Кришнагийн хий хуурмагийн эрчим *Майа-деви-гийн* эрхшээл доор өөрийгөө байдаг гэдгээ ойлгох тийм байдалд байдаггүй. Мөн чанарын *гунуудаас* боолын ёсны хамааралтай байхаар шийтгэгдсэн ийм хүн өөрийн үйлийн цаг зуурын үр шим болох түргэн зуурт урсан өнгөрөх аз жаргал болон зовлон шаналалыг л хүртдэг.

Бхагавад Гитад Бурхан Кришна айлдсанчлан, бүхий л амьд оршнолууд нь Түүний салшгүй жижиг хэсгүүд буюу Түүний мөнхийн трансценденталь албагууд байдаг. Аливаа бүрэлдхүүн хэсгийн жам ёсны зориулалт нь бүхэл бүтэндээ үйлчлэхэд л оршдог. Хитопадешагийн бүрэлдэхүүнд ордог эртний ведийн ёгт үлгэрүүдийн нэг Удеша индриянам-д энэхүү үнэнийг бие махбодь болон түүний эд эрхтэнгүүдийн жишээн дээр тайлбарласан байдаг. Хөл, гар, хамар болон бусад эрхтэнгүүд нь бүхэл бүтний буюу биеийн хэсгүүд байдаг. Харин гар, хөл болон бусад эрхтэнгүүд нь өөрсдийн олсон хоол хүнсээ ходоодондоо өгөхийн оронд өөрсдөө түүгээр таашаал ханамж эдлэхийг оролдох аваас бие махбодь бүхэлдээ хохирон зовох болно гэдэг нь илт хэрэг. Тэгснээрээ, биеийн хэсгүүд нь бүхий л бие организмын ашиг сонирхлын эсрэг үйл үйлдэж байгаа хэрэг болно. Иймэрхүү учир утгагүй үйлдэл нь гарт ч, хөлд ч мөн бусад эрхтэнгүүдэд ч ач тус болохгүй. Харин ч эсрэгээр, ходоодонд орох ёстой хоол тэжээл дутагдсанаас бие махбодийн үйл ажиллагаа алдагдаж эцэстээ сульдан доройтож бүр өвчин эмгэгтэй болно. Үүний нэгэн адил, Шри Кришнагийн салшгүй өчүүхэн жижиг хэсгүүд болох амьд оршнолууд нь Бүрэн Бүтэнээ цэнгүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулахаас татгалзах аваас үүнээсээ болж тэд өөрсдөө л зовлон зүдгүүр амсаж эдлэх болно.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришна бол бүх учир шалтгаануудын учир шалтгаан, амьдралын эх булаг, орчлон ертөнцийн модны үндэс үндэс билээ. Энэ бол Бхагавад Гитад айлдсан байх айлдвар, дүгнэлт болой. Мөн тэнд өгүүлсэнчлэн, Кришнагаас ямар нэгэн байдлаар, зүйлээр илүү гарах хэн ч байдаггүй. Бүхий л өргөл тахилгуудын болоод аливаа ажил үйл бүрийн үр дүнг ганцхан Тэр л таалан болгоодог. Харин, Кришна бол Бурханы Дээд Бодьгал гэдгийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй учраас нүгэлтэй хутгалдаж бузартсан байдаг хүн л Түүнд өөрийгөө даатгахаас татгалздаг хэдий ч бүхий л амьд оршнолууд нь Түүний мөнхийн трансценденталь албагууд байдаг билээ.

Амьд оршнол нь Бурханы Бодьгалтай холбогдсон өөрийн мөнхийн харьцааг мартсанаас болж төөрөгдөл самууралд бүрнээ орон өөрийгөө айхтар сүрхий, бяцхан Кришна гэж үздэг бөгөөд бүх оршнолуудын анхдагч шалтгаан хийгээд эрхэм зорилго нь байдаг Бурханы Бодьгал, Үнэмлэхүй Үнэний трансценденталь чин бишрэлийн албыг үл ойшоож, эс хайхран хүрээлэн байгаа дэлхий ертөнцийг таашаан ханамж эдлэхээр бүхий л хүч чадлаараа чармайж зүтгэж байдаг. Төөрөгдөлд орсон амьд оршнолуудын үйл ажиллагааг мөн *майа* буюу хий хуурмагийн эрчим гэж нэрлэгддэг материаллаг мөн чанарын гунууд удирдан залж байдаг. Үнэн хэрэгтээ амьд оршнол нь мөн чанарын буюу байгалийн хүчийг өөрийн эрхшээлдээ оруулан захирч чадахгүй юм. Амьд оршнолыг Дээдийн Дээд Таашаан Цэнгэгч Кришнагийн байр суурийг эзлэхээр оролдмогц л мөн чанарын гунууд түүнийг шууд олзлон авдаг. Өөрийн “Би”-гийн тухай буруу ойлголт төсөөлөлдөө хөтлөгдөн байгаа амьд оршнол нь Дээдийн Дээд Таашаан Цэнгэгчийг дуурайхыг оролддог боловч өөрийн мөн чанарын хувьд тэрээр, гар, хөл, нүд эсвэл бусад эрхтэнгүүд нь бүхий л биеийн үүргийг гүйцэтгэх чадваргүй байдагтай адил Түүн лугаа байж чадахгүй юм. Таашаал ханамж эдлэх гэж ийнхүү чармайн зүтгэж байхдаа тэр байж

болох бүхий л зовлон бэрхшээлийг тэсэн туулах болдог. Хий хуурмагийн эрхшээлд орсон бид өөрсдийн материаллаг үйл ажиллагааны явцад учрах хүндрэл бэрхшээлүүдийг даван туулахын тулд *карма-йогын* зам мөрд орох хэрэгтэй.

Трансценденталистууд нь жинхэнэ мэдлэгийг хүртсэн байдгаараа эгэл хүмүүсээс ялгаатай учраас тэдний үйл нь эгэл хүмүүсийн үйлээс илүү, онцлог шинж төлөвтэй байдаг. Материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөллөөр тулгагдах материаллаг үйл ажиллагаа нь Бурхан Кришнагийн чин бишрэлийн албаны үйлийн бурханлаг утга учир, ач холбогдлоос үндсээрээ ялгаатай гэдгийг трансценденталистууд ойлгож байдаг. Өөрт нь материаллаг бие махбодь болон ухаантай адил ижил зүйл огтхон ч байдаггүй гэдгийг мэдэж байгаа трансценденталист нь үйл хэргээ бурханлаг түвшинд явуулахыг үргэлжид чармайдаг. Материаллаг ертөнцөд түр зуур оршин байгаа хэдий ч өөрөө бол бурханлаг сүнс, Дээд Сүнсний салшгүй хэсэг гэдгээ тэр мэднэ. Иймээс гар, хөл, нүд болон мэдрэхүйн бусад эрхтэнгүүд нь янз бүрийн үйл ажиллагаанд оролцож байдаг ч түүнийг материаллаг ухаан бодолтой хүмүүстэй адилтган үзэж болохгүй. Шри Кришнагийн трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах алба зүтгэл нь ийм хүнийг материаллаг үйлийн гинж тушаанаас ангижруулдаг. Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Аржунад: “Ай Аржуна минь ээ, материаллаг үйлээр таашаал ханамж эдлэх оролдлогоо орхин трансценденталист бол. Дайчин эрийн үүргээ биелүүл, гэхдээ үүнийгээ Надад зүтгэж байгаа байдлаар л хий. Миний сургаал зааврыг дагах хийгээд Надад үл дайсагнах хэн бүхэн үйл хэргээ ийм бурханлаг ухаан санаатайгаар явуулснаар материаллаг үйлийн чөдөр тушаанаас заавал ангижирдаг.” гэж айлдсан билээ.

Бид өөрсдийгөө бие махбодьтойгоо адилтган үзэх буюу өөрөөр хэлбэл бие махбодь болон ухаанаа өөрсдийн “Би” гэж алдаатай буруугаар бодон, материаллаг ертөнцийг таашаал ханамж эдлэх зүйл гэж ойлгон өөрсдийгөө түүний нэг хэсэг нь гэж үзэж байгаа цагт жинхэнэ мэдлэгийг хүртэх боломжгүй. Иймээс Бурханы Дээд Бодьгал Шри Кришна трансценденталист болох хүсэл эрмэлзлийг өөрсөддөө хөгжүүлэхийг бидэнд зөвлөж байна. Зөвхөн тэгсэн цагт л бид, бид бол материаллаг ертөнцийн хэсэг биш, харин мөнхийн бурханлаг оршнолууд гэдгээ ойлгох болно. Энэ үнэнийг таньж мэдсэнээрээ бид өөрсдийн ухамсараа материас жинхэнэ ёсоор холдуулж эхлэх ба бурханлаг зам мөрөөр цааш хэдийчинээн урагшлана, материаллаг зүйлсүүдтэй мэдрэхүйн холбогдож шүргэлцсэний уршгаар үүсэн гарах аз жаргал болон зовлон шаналал нь бидэнд төдийчинээн бага нөлөөлөх болно. Сүнс материтай шүргэлцсэнээр төрөх бидний хуурамч эго аажим аажмаар үгүй болох ба тэгснээрээ бид бүхий л материаллаг адилтгалаасаа салан ангижирч Үнэмлэхүй Үнэнтэй холбогдсон өөрийн харьцаа холбоог дурсан санаж эхлэх боломжтой болно. Ингэснээрээ бид энэ амьдралдаа ч ангижралд хүрч болно.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришна бол Үнэмлэхүй Үнэн бөлгөө. Бүхий л ариун гэгээн шастируудад ингэж баталсан байдаг. Бид Шри Кришнаатай өөрсдийн холбоо харьцааг сэргээмэгц л бидний бурханлаг амьдрал эхэлдэг. Шри Кришна нар лугаа харин мунхаг байдал нь харанхуйтай адил. Бид Кришнаатай холбогдмогц л биднийг бүрхэн байсан мунхагийн харанхуй сарнин алга болно. Кришна бидний зүрхэнд тодормогц л, өглөө дорно зүгээс мандан гийх нарны цацрагт бүх зүйлс онцгой цэвэр, шинэ байдалтай болж туяаран гялалздагийн адил бид материаллаг бузраас ариусдаг. Энэ бол ямар нэгэн гэнэн, санаанаасаа зохиосон зүйл биш, харин бурханлаг танин мэдэхүйн бодит туршлага билээ. Шри Кришнагийн болон Түүний албатын зам мөрөөр чин зүрхнээсээ замнаж байгаа хэн бүхэн энэхүү эгэл хялбар үнэнд хүрдэг.

Харин Кришнад атаархагч болон Түүнтэй өрсөлдөн тэмцэлдэхийг оролдож байдаг мунхаг хүмүүс нь энэ учир, баримтыг үл зөвшөөрдөг. *Карма-йогын* чухлыг ийн үл ойлгон байгаа ухвар мөчид материалистууд нь өөрсдийг нь зөвхөн боолчлох эмх замбараагүй материаллаг үйл ажиллагааныхаа эрхэнд ордог. Ийм хүмүүсийн үйлдэх үйл нь л тэднийг дахин дахин төрж үхэхийг албадаж тулган материаллаг ертөнцөд барьж байдаг. Тэнэг

мунхаг бэртэгчингүүд нь Кришнаг өөрсдийн нь адил эгэл хүн мэтээр үзэж Түүнийг басамжлан шоолж, Түүнд атаархаж байдаг. Тэд имперсонализмын философийн халдвар авсан байдаг учраас тэдний гажуудсан ухаанд Шри Кришнагийн тухай мэдлэгийг нэвтрүүлэн дэлгэрүүлэх нь хүнд бэрх. Харин, Бурханыг бишрэн Түүнд өөрийгөө даатган, Түүний айлдварт дүүрэн итгэлтэй байгаа хэн бүхэн Бхагавад Гитагийн бүхий л айлдваруудыг, “бурханлаг тайлбар” гэж олонтоо нэрлэгддэг өөрсдийн ухаан санаандаа дүрслэн бодсоны дагуу буюу эмпирик-философийн тусламжтайгаар биш, харин байгаа тэр байдлаар нь ойлгож ухаардаг. Зөвхөн ийм чин бишрэлтэн л Кришнад өөрийгөө бүрнээ даатгахуйн зарчмыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд материаллаг үйлийн гав гинжнээс ангижрах боломжийг өгдөг *карма-йогын* аргыг ашигладаг.

Шри Кришна Өөрийн сургаалдаа чин бишрэлтэн нь зөвхөн тодорхой нэгэн каст, итгэл бишрэл, арьс өнгө эсвэл улс орных байх ёстой гэж нэг ч удаа айлдаагүй. Харин ч эсрэгээр, чин бишрэлтэн нь ямар ч улс оронд төрсөн төдийгүй ямар ч анги давхарга, итгэл бишрэлтэй болон арьс өнгөтэй байж болно. Хүн хэн ч байсан ялгаагүй Шри Кришнаг биширч шүтэж болох нь эргэлзээгүй хэрэг. Үүнийг батлан Бурханы Дээд Бодьгал Бхагавад Гитад: “Ай Притхын хүү минь ээ, Надаас аврал ивээл эрэн, Миний чин бишрэлийн албанд зүтгэхэд өөрийгөө зориулан байгаа хэн бүхэн, тэр бүү хэл уналтанд өртсөн эмэгтэйчүүд, мунхаг ажилчид болон худалдаачид зэрэг үл итгэгчид болон доод гарал язгууртай хүмүүс хүртэл төгс төгөлдөрт хүрэн Бурханы оронд буцаж очиж болно.” гэж айлдсан. Өөр үгээр хэлбэл *асурууд*, бурхангүйчүүдийн нийгэм дэх гажуудсан кастын систем нь Бурханы Үнэмлэхүй Бодьгал Шри Кришнад хүрэхэд саад тотгор болохгүй.

Жинхэнэ нийтлэг кастын системийн үндсэн зарчмуудыг Шри Кришна өөрөө тайлбарласан. Аль нэгэн *гунын* нөлөөн доор үйл хэргээ явуулж байгаа хүний агуулах шинж чанарт хамааруулан Бурхан Кришна нийгмийг *брахманууд* (тайлгачид болон оюунлаг хүмүүс), *киатрия-гууд* (төр засгийн удирдагчид болон дайчин баатар эрс), *вайшья-гууд* (худалдаачид болон тариачид) болон *шудра-гууд* (ажилчид) гэсэн дөрвөн бүлэг, ангид буюу кастад хуваасан. Кришна Өөрөө энэхүү системийг бүтээж бий болгон бүхий л дэлхий ертөнц даяар дэлгэрүүлсэн хэдий ч Тэрээр, бурхангүй үзэлтэнгүүд нь хүний нийгэмд эзлэх байр суурийг түүний гарал үүслээр нь тодорхойлж байдаг жам ёсны бус харгис бурангүй кастын систем үүсэн бий болсонтой холбоогүй. Кришнагийн бүтээсэн кастын систем нь жам ёсны бөгөөд хаа сайгүй зохицон хэрэглэгддэг. Түүний гол тодорхойлох хүчин зүйл нь хүний чадвар болоод шинж чанар байдаг учраас тэрээр албадан шахалт, тулгалт дээр үндэслэгдээгүй.

Нийгмийн бүрэлдэхүүн болдог эдгээр дөрвөн анги бүлэг нь хүний байр суурийг түүний гарал язгуураар нь тодорхойлдог кастын системийг бий болгоход огтхон ч зориулагдаагүй. Анги бүлэгт жинхэнэ систем нь зөвхөн хүний бодит чадвар болон шинж чанарыг л харгалзан үздэг учраас түүнийг хаа сайгүй хэрэглэхэд зохицсон байдаг. Язгуур угсаа зэрэг хоёрдагч хүчин зүйл дээр үндэслэн өөрийгөө *брахмана*, *киатрия*, *вайшья* болон *шудрагуудын* анги бүлэгт харьяалагддаг гэж хэн ч баталж чадахгүй. Жишээлбэл, нэр алдартай сайн эмчийн хүү гэдэгтээ дулдуйдан эмчийн ажлыг хийж болохгүй. Жинхэнэ эмч болохын тулд анагаах ухааныг удаан хугацааны туршид хичээнгүйлэн судлах ёстой бөгөөд зөвхөн сургууль соёлоо төгссөний дараагаар л эмчийн ажил албанд орж болно. Өвчтөн эмчид үзүүлэхдээ, чухамдаа бол эмчийн төрсний гэрчилгээг биш харин түүний чадварыг л хардаг шүү дээ.

Улс гүрэн бүрт л эмч нар байсан, одоо ч байгаа бөгөөд үүний нэгэн адил *брахмануудын*, *киатриягуудын* эсвэл бусад анги бүлгийнхний чадвар болоод шинж чанарыг агуулсан хүмүүс дэлхийн аль ч хэсэгт ямагт байж л байдаг билээ. Газар нутгийн давчуу хүрээлэл хийгээд шашины бүлэглэлийн явцуу үзлээр хязгаарлагдсан одоогийн кастын систем нь алдаатай буруу гэдэг нь эргэлзээгүй учраас жинхэнэ нийтлэг кастын системийн гажуудмал хэлбэр төрх юм. Анагаах ухааны боловсрол мэдлэггүй мөртөө,

эмчийн хүү учраас өөрийгөө эмч гэж нэрлэх хүнийг бусад нь, тийм ээ эмч гэж хүлээж авах болбоос энэ нийгэм нь бүгд бие биенээ хууран мэхэлж байдаг нийгэм болон хувирна. Мэхлэгчидийн болон мэхлэгдэгчидийн нийгэм. Ийм учраас Бхагавад Гитад дурьдагдсан байдаг, Бурханы Дээд Бодьгал Шри Кришнагийн бүтээсэн кастын системд мэхлэгчид хийгээд мэхлэгдэгчидийн нийгмийн кастын системтэй адил ижил зүйл огтхон ч байхгүй. Шри Кришнагийн кастын систем нь үргэлжид болон хаа сайгүй- гаригуудын, тэр ч бүү хэл орчлонгийн аль ч хэсэгт тогтож байдаг нь үнэн билээ.

Янз бүрийн анги бүлгийн төлөөлөгчдийн шинж чанарыг Бхагавад Гитад тоочсон байдаг. Бид мөн тэдгээрийг товч дурдъя. Нийгмийн эхний, хамгийн дээд ангид *брахманууд* харьяалагддаг. Тэд үргэлж ач ивээлтэй байдаг бөгөөд бурханлаг адил тэгш байдал, огоорохуй болон бүхнийг уучлан хэлтрүүлж энэрэн нигүүлсэх зарчмуудад үндэслэж тулгуурлан үйл хэргээ явуулдаг. Хоёр дахь ангид *кишатриягууд* харьяалагддаг. Тэдэнд бүтээлийн эхлэл болох хүсэл тачаалын шинж тэмдэг илэрч байдаг бөгөөд нийгмийн болоод улс төрийн янз бүрийн байгууллагуудыг толгойлох удирдагч байдлаар үйл хэргээ явуулдаг. Гурав дахь ангид хүсэл тачаалын болон харанхуй мунхагийн *гунуудын* холимог нөлөөлийн доор орших *вайшьягууд* харьяалагддаг бөгөөд тэд үндсэндээ газар тариалан болон худалдаа арилжаа эрхэлдэг. Төгсгөлд нь, дөрөв дэх буюу хамгийн доод ангид мунхагийн харанхуйд орших *шудрагууд* харьяалагддаг. Иймд тэд бусад гурван ангийн төлөөлөгчиддөө үйлчилж байдаг. *Шудрагуудын* үүрэг нь бүхий л нийгэмдээ үйлчлэхэд оршдог. Манай өнөөгийн харанхуй цаг үе- хэрүүл тэмцэл, бялангач үзэл болон мунхаглалын цаг үе *Калид* бараг хүн бүхэн *шудра* болон төрдөг.

Бурханы Дээд Бодьгалын бүтээсэн кастын системийн байр сууринаас хүний нийгмийг ажиглан харвал эдгээр дөрвөн анги нь дэлхийн аль ч хэсэгт байгааг олж харах нь лавтай Дэлхийд хаа сайгүй, хүн амьдарч байгаа газар бүрт л *брахмана*, *кишатрия*, *вайшья* болон *шудра-ын* шинж байдлыг агуулсан хүмүүсийг олж харж болно. Мөн чанарын цэвэр ариуны, хүсэл тачаалын болон мунхагийн харанхуйн гэсэн гурван *гунууд* нь бүхий л орчлон даяар нэвчин байдаг бөгөөд *брахманууд*, *кишатриягууд* болон бусад ангийнхан нь эдгээр *гунуудаас* л төрсөн болохоос өөр юунаас ч биш. Энэ дэлхийн аль ч хэсэгт эдгээр дөрвөн каст оршдоггүй гэж батлахыг оролдох нь утгагүй хэрэг. Мөн чанарын харгалзах *гунуудын* нөлөөн доор үйл ажиллагаагаа явуулах эдгээр дөрвөн кастын төлөөлөл аль ч улс гүрэнд үргэлж байсаар байсан, одоо ч байж байна мөн ирээдүйд ч байсаар байх болно. Иймээс нийгмийг дөрвөн ангид хуваадаг байдал буюу кастын систем нь зөвхөн Энэтхэгт л байдаг гэж ярих хүн төөрөгдөл самууралд гүн орсон хэрэг. Эдгээр ангиуд нь улс орон бүрт ямар нэгэн нэр хаягийн доор байж л байдаг.

Гэхдээ кастын систем нь биднийг Бурханы чин бишрэлтэн болох боломжийг үгүй хийдэггүй. Хүн хаана ч амьдарч байсан, тэр бүү хэл өөрийн шинж чанарын хувьд тэр тэрээр дөрөв дэх ангийн төлөөлөл болох ердийн *шудрагаас* бүр дор байсан ч Шри Кришнагийн трансценденталь алба үйлэнд зүтгэж болно. Бурханы Бодьгал Шри Кришнагийн (Үнэмлэхүй Үнэн болоод Бүхнийг Татагч) трансценденталь албанд зүтгэж байгаа туршлагатай *брахмана* нь дээдийн дээд төгс төгөлдөрт хүрдэг бөгөөд ийм төгс төгөлдөрт ямар ч хүн, тэр ч бүү хэл *шудрагаас* бүр доод түвшинд орших хүн ч Шри Кришнагийн трансценденталь чин бишрэлийн албанд зүтгэх зам мөрөөр орон замнаснаар хүрч болно. Пурануудад өгүүлсэнчлэн, *чандала* (*шудрагаас* доор байр суурьтай байх тав дугаар ангийн төлөөлөл) хүртэл Бурханы чин бишрэлийн алба үйлэнд зүтгэснээр дээд ангийн төлөөлөл болох *брахманаас* ч илүү гарч болно. Иймд, орчлонгийн дээдийн дээд шастир Бхагавад Гитагийн эрхэм нандин номлол сургаалын зорилго нь Шри Кришнагийн трансценденталь албанд өөрийгөө зориулан төгс төгөлдөрт бүрнээ хүрэхэд нь хүнд туслахад оршдог. Иймээс хүн бүр өөрийн каст, итгэл бишрэл эсвэл арьс өнгөнөөс үл хамааран бурханлаг үр дагаврыг авчрах үйл ажиллагаа болох *карма-йогын* түвшингээс эхэлдэг чин бишрэлийн албаны зам мөрд орох хэрэгтэй. Энэ албанд зүтгэснээрээ хүмүүс

дэлхий дээр болж байгаа бүхнийг төгс төгөлдөржүүлж чадна. Энэ явдал нь бурханлаг байдлыг дүүрэн бялхуулж хүмүүсийг, мөн тэдний үйлүүдийг мөн чанарын *гунуудын* түвшингийн чанадад дээшлүүлэн гаргадаг. Хүний хийж үйлдэж байгаа үйлүүд нь төгөлдөржсөн цагт л түүнд дээд ангийн төлөөлөл болох *брахманы* шинж чанар жам ёсоороо хөгжин бий болдог. Чухам үнэнийг хэлэхэд, өөрийн амьдралыг бүрнээ төгөлдөржүүлэн мөн чанарын *гунуудын* нөлөөнөөс дээш гарсан хүн *брахманаас* ч илүү дээд байр суурийг эзэлдэг. *Брахмана* нь анги бүлгийн материаллаг шатлан захирах ёсыг толгойлж байдаг хэдий ч эцсийн дүндээ түүний байр суурь трансценденталь бус.

Бурханы Дээд Бодьгалын трансценденталь албанд зүгээр л зүтгэснээр бурханлаг мэдлэгийг хэрхэн хүртдэгийг Бхагавал Гитагийн (4.24)-д тайлбарласан байдаг. Тэнд өгүүлсэнчлэн, биднийг бурханлаг үр дагавар авчрах үйлэнд зүтгэхэд бидний эргэн тойрон бурханлагаар бялхан гийдэг. Хаа сайгүй залрах Дээд Сүнсний тухай Веданта-ын мэргэн цэцэн үгний буруу ойлголтыг дэлгэрүүлж байсан Шанкарачарьягийн пантейст-философи мөн энэ л шүлэг дээр үндэслэгдэж байсан

Тахилга өргөлийн олон хэлбэрүүд байдаг ч тэд бүгд эцэстээ Бүхний Дээд Бурхан Вишнуг цэнгүүлэх ганц л зорилготой байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Материаллаг ертөнцөд оршин байгаа цагт бид сүнсээ бие махбодидоо тогтоон барихын тулд ч гэсэн түүнтэй ямар нэгэн байдлаар шүргэлцэн зууралдах л болно. Харин бид Дээд Сүнс хаа сайгүй залран байдаг тухай Веданта-ын баталгааг зөв ойлгох аваас материаллаг үйлээ төгөлдөржүүлж чадна. Пантейзмыг баримтлагчид нь энэ үнэнийг, Дээд Сүнс нь хаа сайгүй залран байдаг учраас бүх оршнол бол Дээд Сүнс гэж буруугаар, хийсвэрлэн бодож байдаг. Энэ төөрөгдлөөс салах шаардлагатай. Хүмүүс Дээд Сүнс бол үнэхээрийн хаа сайгүй залран байдаг гэдгийг ойлгож, өөрийн бурханлаг мөн чанарыг ойлгож ухаарсан хүний сургаал зааврыг даган өөрсдийн үйл ажиллагааг энэхүү Дээд Сүнстэй холбож сурсан цагт л тэдний амьдрал төгөлдөржих болно. Тэгсэн цагт үнэндээ эргэн тойрны бүх зүйлс бурханлаг болно.

Үүнийг дараахь жишээн дээр тайлбарлаж болно. Төмөр утсыг галд хийн улайсгавал тэр төмрийн чанараа алдан галын шинж чанартай болдог. Үүнтэй төстэйгөөр, хэрвээ бид үйл бүрээ Кришнаатай холбогдсон харьцаан дээрээ үндэслэж тулгуурлан үйлдэх аваас бидний бүхий л амьдрал дээдийн дээд бурханлаг байдлаар дүүрэн бялхана. Бид юуны өмнө Кришнаг л цэнгүүлэх гэж тэмүүлэх болсоны ачаар үйл бүр маань бурханлаг мөн чанартай болно.

Тахилга өргөл нь таван үндсэн элементээс бүрддэг. Үүнд: 1) өргөл өргөх үйл явц, 2) өргөл, 3) гал, 4) тахилга өргөл болон 5) тахилга өргөлийн үр дүн ордог. Энэ бүх элементүүд нь Дээд Сүнстэй холбогдсоноор төгөлдөржилтийг олох бөгөөд тэгсэн цагт жинхэнэ тахилга өргөл болдог. Өөр үгээр хэлбэл, эдгээр таван элементийг Шри Кришнагийн трансценденталь албанд ашиглах аваас, тэд Түүнтэй шүргэлцсэнээр үнэмлэхүй бурханлаг болно.

Ийм учраас цэцэн мэргэн хүмүүс өөрсдийн бүхий л үйлээ Бурханы Бодьгалд зориулдаг. Эдгээр өө сэвгүй, цэвэр ариун сүнснүүд нь мэдрэхүйгээ бүрэн эзэмдэн захирч, өөрсдийн бурханлаг “Би”-ийн жинхэнэ ойлголтонд хүрсэн байдаг. Зөвхөн ийм гэгээн сүнснүүд л уналтанд өртсөн сүнснүүдэд цаг хугацаа, орон зай болон тухайн хүний онцлог байдалд харгалзуулан зохицуулж жинхэнэ энэрэл нигүүлслийг үзүүлж чадна. Эдгээр гэгээнтэнгүүдийн үйлдлүүд нь материаллаг шинжтэй харагдаж болох боловч тэд өөрсдөө бол материаллаг үйл ажиллагааны чөдөр тушаанаас ангид чөлөөтэй байдаг. Үүнийг Бхагавад Гитагийн (5.7)-д тайлбарласан байдаг. Бусдыг энэрэн нигүүлсэх үүднээс бурханлаг үр дагавар дагуулах үйлэнд зүтгэж байгаа хүн л нийгмийг удирдан толгойлоход үнэхээрийн зохистой. Засгийн эрх мэдлийг авахаар тэмүүлэгч нь алдаа хийх тавилантай байдаг.

Карма-йогчдын эсрэг этгээдүүд болох өөрсдийнхөө болон өөрсдийнхөө таашаал ханамжийн төлөө ажиллах, Дээд Сүнстэй алба зүтгэлийн трансценденталь харьцаагаар үл холбогдсон хүмүүс заримдаа тэдний үйл ажиллагаа нь дээд Таалалд таарч нийцэн Түүний дагуу явагдаж байдаг гэж батлахыг оролддог. Пантейст- сөргөлөдөгчид нь өөрсдийн хувиа хичээж амиа бодсон үйлээ Бурханы трансценденталь албанд зориулж байгаа мэт дүр үзүүлэхийг оролддог. Харин бүхнээ Бурханы төлөө өргөл болгон, Түүний бадамлянхуа өлмийд аврал ивээлийг олсон цэвэр ариун сүнснүүд нь иймэрхүү хуурамч трансценденталистуудаас тэдний шаардаж байсан хүндэтгэлийг үзүүлэхээ марталгүйгээр холдон зайлсхийдэг.

Трансценденталистууд нь амьд оршнол нь өчүүхэн жижиг хэдий ч тэрээр Үнэмлэхүй Үнэний салшгүй хэсэг болж байдаг, иймээс өөр шигээ өчүүхэн бага ч гэсэн үл хамаарсан байдлыг мөн агуулж байдаг гэдгийг цэвэр ариун зүрхээрээ мэддэг. Бурханы Дээд Бодьгал бүхнээс хүчирхэг, гэвч Тэр амьд оршнолын энэхүү үл хамаарсан буюу бие даасан байдалд хэзээ ч халддаггүй. Иймээс амьд оршнол өөрийн өчүүхэн бага үл хамаарсан байдлаа буруугаар ашиглах аваас материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөн доор орж унадаг. Цэвэр ариуны, хүсэл тачаалын болон мунхагийн *гунуудын* чөдөр тушаанд орсон амьд оршнолд тэдгээрт харгалзах шинж чанарууд хөгжин бий болдог. Материаллаг мөн чанараар болзолдож нөхцөлдөж байгаа цагт бид нөлөөн доор нь оршин байгаа тэр л *гунад* харгалзан нийцсэн байдалд үйл ажиллагаагаа явуулахаар тулгагдсан аргагүй байдалд байдаг. Хэрвээ мөн чанаруудын *гунуудын* нөлөө байдаггүй байсансан бол материаллаг ертөнцөд олон янз хэлбэрийн үйл ажиллагаа гэж байхгүй байх байсан. Үйлийн олон янз хэлбэрүүд нь бүгд л энэ гурван гунаар болзолдож нөхцөлдсөн байдаг.

Байгаль мөн чанарын нарийн хуулиудыг үл ойлгон, өөрсдийн үйлүүдээ дээд Таалалд нийцэж зохицсон хэмээн зөвтгөхийг оролдох аваас бид хэн нэгнийг алагчлан үзэж тал тохой татах, ухаан бодолгүй болон харгис хэрцгий зан гаргах зэрэг төгөлдөр бус байдлуудаа Бурханы Бодьгалын ач ивээлийнх гэж хэлэхээс буцахгүй. Материаллаг ертөнцөд болж байгаа аливаа нэгэн гай зовлон нь Бурханы тааллаар л тохиолдож нэг хэсэг нь жаргаж, нөгөө хэсэг нь зовж байдаг гэж хэн ч бодох ёсгүй. Ийм байдал нь зөвхөн, амьд оршнол бүр өөрийн үл хамаарсан буюу бие даасан байдлаа янз бүрийн байдлаар л ашиглаж байгаагаас болдог. Бурханы Дээд Бодьгал Шри Кришна материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөллөөр болзолдож нөхцөлдсөн үйлээсээ татгалзан огоорохыг бүгдэд уриалдаг. Энэ үйл нь мунхаглалаас төрдөг бөгөөд мөн чанарын *гунууд* биднийг байнга түүнд барьж байдаг.

Бхагавад Гитагийн (5.14-15)-д Бурханы айлдсанчлан, Тэрээр хэнийг ч энэ эсвэл тэр үйлийг үйлд гэж даалгаж, албадаж тулгадаггүй хийгээд тэдний үр дагаврыг бий болгодоггүй. Энэ бүхнийг материаллаг мөн чанарын *гунууд* л хийж байдаг. Иймд, амьд оршнолын үйлдэж байгаа бурханлаг үр дагавар авчрахаас бусад бүх үйлүүдийн учир шалтгаан нь түүний буруугаар ашиглаж байгаа хүсэл эрмэлзлийн эрх чөлөө юм. Хэн ямар үйл үйлдэх ёстой, түүнийхээ төлөө тэр юуг хүртэх ёстой гэдгийг бүхнийг чадагч Бурхан Өөрөө тодорхойлдог гэж бодож болохгүй. Болзолдож нөхцөлдсөн амьд оршнолуудын үйл ажиллагаа нь материаллаг бөгөөд материаллаг *гунуудын* эрхшээлд захирагдсан байдаг ба Бурханы Дээд Бодьгал түүнтэй шууд харьцаж оролцдоггүй.

Карма-йогчийн хувьд гэвэл тэрээр үргэлж трансценденталь байр сууринд оршиж байдаг бөгөөд түүний бүхий л үйл ажиллагаа нь үнэмлэхүй түвшинд өрнөж явагдаж байдаг учраас материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөллөөс ангид байдаг. Хүн цэвэр ариун, хүсэл тачаал болон харанхуй мунхагийн *гунуудын* нөлөөллөөс ангижирсан цагт түүнд илэрч тодорсон ертөнцийн бурханлаг мөн чанар нээгддэг. Энэ үеэс эхлэн мөн чанарын *гунууд* түүний бурханлаг төгс төгөлдөржилтөнд саад тотгор хийж чадахгүй болдог. Ийм саад тотгорыг даван туулсан хүн үнэмлэхүй харааг хүртдэг.

Цааш нь Бхагавад Гитагийн (5.18)-д тайлбарласанчлан, цэцэн мэргэн хүн үнэмлэхүй харааныхаа ач тусаар амьд оршнолуудын хоорондын ялгааг анхаарахаа больдог. Түүний хувьд эрдэм номтой, зөв хүмүүжилтэй *брахмана* ч, үнээ ч, заан ч, нохой ч эсвэл нохойгоор хооллогч ч адил. Зөв шудрага, эрдэм мэдлэгтэй *брахмана* нь цэвэр ариуны *гунын* биелэл байдаг бол үнээ нь амьтадын дундахь энэ *гунын* төлөөлөл байдаг. Заан болон арслан нь хүсэл тачаалын *гунын*, харин нохой болон *чандала* (нохойгоор хооллогч) нь харанхуй мунхагийн *гунын* биелэл болж байдаг. *Карма-йогч* нь эдгээр амьд оршнолуудын гадаад бүрхүүлүүдийн хоорондхи материаллаг мөн чанарын *гунуудын* нөлөөллөөр болзолдож нөхцөлдсөн ялгаатай байдалд анхаарал хандуулдаггүй, харин үнэмлэхүй харааныхаа ач тусаар энэ бүрхүүлээр бүрхэгдэн хучигдсан сүнсийг өөрийг нь ойлгож ухаардаг. Өчүүхэн жижиг сүнс нь хэмжээ хязгааргүй Дээд Сүнсний хэсэг байдаг учраас *карма-йогын* төгс төгөлдөр түвшинд хүрсэн хүн бүх амьд оршнолуудын болон хүрээлэн байгаа бүгдийн нэгдмэл мөн чанарыг тодорхой харж байдаг. Оршин байгаа бүгдийн Үнэмлэхүйтэй холбогдсон холбоог ухаарсанаар ийм *карма-йогч* нь бүхнийг Түүний трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах албанд ашигладаг. Тэр амьд оршнол бүрийг Үнэмлэхүй Бурхан Шри Кришнагийн трансценденталь албат гэдгийг харж байдаг. Түүний төгс төгөлдөр бурханлаг хараа нь материаллаг бие махбодин бүрхүүлийг, улайссан төмөр хүрч хавьтсан бүхнээ шатааж байдгийн адил цоо нэвтэлж байдаг. *Карма-йогч* нь Бурханы Дээд Бодьгалын чин бишрэл дүүрэн бялхах албанд хэн бүхнийг болон юм бүхнийг хамруулж татаж оруулан жинхэнэ бурханлаг ойлголтын үлгэр жишээг ингэж л үзүүлдэг.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришна бол бүхий л амьд оршнолуудын Эзэн, дэлхий ертөнцийн бүхий л зүйлс Түүний цэнгэлд л зориулагдсан байдаг гэдгийг *карма-йогч* сайн мэддэг. Мөн тэр, алдар хүндэтгэлд хүрэхээр таашаал ханамжийн зам мөрд орох эсвэл ертөнцөөс огоорохоор эрмэлзэн байгааг ямар ч утгагүй зүйл гэдгийг мэддэг. Алдар цууд хүрэх гэсэн материаллаг хүсэл эрмэлзэл бол материаллаг оршнолын өвчний үндсэн учир шалтгаан гэдгийг мэддэг учраас жинхэнэ мэргэд нь түүнийг жигшин үздэг. Ач тустай үйл, мэдлэг хүртэхүй, бясалгал, огоорон зүтгэхүй болон тахилга өргөл зэрэг нь зөвхөн энэхүү материаллаг өвчнийг эдгээн илааршуулахад л зориулагдсан байдаг. Иймээс Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Бхагавад Гитагийн (5.29)-д: “Бүхий л тахилга өргөл болоод тэвчил хатуужлын үр шимийг Намайг таашаан болгоож байдаг гэдгийг ойлгосноор л дээдийн дээд амар амгаланд хүрч болно.” гэж айлдсан. Тэр бол бүхий л орчлонг залан Захирагч бөгөөд бүх амьд оршнолуудын шилдэг сайн найз нөхөр нь.

Урьд өмнө өгүүлсэнчлэн, ямар ч үйлийг тахилга өргөл байдлаар хийж үйлдэх ёстой. Өөрөөр хэлбэл Вишнугийн трансценденталь мэдрэхүйн таалалд нийцүүлэх ёстой. Бхагавад Гитад батлан өгүүлснээс үзэхэд, тахилга өргөлийн үр шимийг зөвхөн Шри Кришна л таашаан болгоодог гэдэг нь тодорхой. Өөрийн ажил хөдөлмөрийн үр шимд татагдан байгаа эгэл хүмүүсийн үйлдэж байгаа тахилга өргөлүүд, мөн имперсоналист философичдын өөрсдийгөө зориулан байдаг бясалгал болон тэвчлүүдийг Бурханы Дээд Бодьгал Шри Кришна үүрэг болгон оноосон бөгөөд мөн дэмжин тусалж байдаг. Амьд оршнол бүрийн зүрхнээ залран байдаг болон ид шидийн йогчдын бясалган байдаг Дээд Сүнс-төлөв бол Бурханы Дээд Бодьгал Шри Кришнагийн бүрэн хувилгаан дүр.

Ийнхүү Шри Кришна бол өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнд татагдан байгаа эгэл хүн, имперсоналист философич, тэр ч бүү хэл ид шидийн йогч зэрэг хэн бүхний найз нөхөр нь байдаг. Тэгвэл Бүхний Дээд Бурханд өөрийгөө бүрнээ зориулан байгаа чин бишрэлтэнгүүдийн найз нөхөр нь байдаг эсэх талаар бол ярихын ч хэрэггүй билээ. Бурхан хүмүүсийн сайн сайхны төлөө санаа тавьж байдаг бөгөөд Өөрт нь чин бишрэлээр зүтгэхийг цаг хугацаа, орон зай болон хүмүүсийн зан чанарт харгалзуулж нийцүүлэн хаа сайгүй номлож түгээн дэлгэрүүлэх эрхийг Өөрийн чин бишрэлтэнгүүдээ олгодог. Иймээс л Бурханыг бүх учир шалтгааны эх учир шалтгаан, бүх адислалын эх булаг буюу

Говинда гэж нэрлэдэг. Бурханлаг үр дагавар авчрах үйл ажиллагааны зам мөрөөр орж замнан Бурханыг танин мэдсэнээр хүмүүс жинхэнэ тайван амгалан хийгээд аз жаргалд хүрч чадна.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришнагийн трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах албанд өөрийгөө бүрнээ зориулсан хүн Бурханд үйлчлэн зүтгэхтэй нь холбоогүй л бол тахилга өргөл өргөх, тэвчил хатуужил эсвэл бясалгал үйлдэхийн хэрэггүй. Урьд өмнө өгүүлсэнчлэн, Бурханы ийм чин бишрэлтэнгүүдэд цэвэр ариуны *гуныг* тодорхойлдог буюу өөрөөр хэлбэл *брахмануудад* илэрч тодордог шинж чанарууд жам ёсоороо хөгжиж бий болдог. Үүнтэй адилаар, чин бишрэлтэнгийн шинж чанаруудын дунд жинхэнэ *карма-йогчид* угийн байдаг өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнг өргөл болгоход бэлэн байдал болон туршлага, *санньясид* байдаг мэдлэг болон огоорохуй, мөн ид шидийн иогчид байдаг тайван амгалан байдал болон Бурханд гүнээ төвлөрөхүй зэрэг нь мөн л байдаг. Үүнтэй уялдуулан Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Бхагавад Гитагийн (6.1)-д: “Өөрийн үйлийг үр дүнд нь татагдалгүйгээр өөрт оноогдсон үүрэг байдлаар биелүүлж байгаа хүн нь огоорохуйн түвшинд амьдарч байдаг. Тэр бол жинхэнэ мистик буюу ид шидтэн болохоос өөрт оноогдсон үл биелүүлэгч нэгэн биш.” гэж айлдсан.

Чин бишрэлтэнгийн хөдөлмөрийн үр шимийг Шри Кришна Өөрөө таашааж болгоон цэнгэж байдаг. Ийм учраас чин бишрэлтэнгүүд нь өөрийн үйлийн үрийг, материаллаг үүднээс үзэхэд сайн ч байна уу эсвэл муу ч байна уу ялгаагүй, амсаж эдэлдэггүй. Чин бишрэлтэн нь Шри Кришнагийн таалалд нийцэх тэр л зүйлийг хийх эрмэлзлийг удирдлага болгож байдаг. Тэр үйл ажиллагаандаа өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэх боломжтой эсвэл зайлшгүй огоорох ёстой зүйл байна гэсэн үүднээс ханддаггүй. *Санньясигийн* чин бишрэлтэнгээс ялгаатай тал нь гэвэл тэрээр хаа сайгүй залрах Сүнсний тухай мэдлэг хүртэхийн тулд материаллаг үүргүүдээсээ татгалзсан байдаг. Ид шидэт иогч нь үүнийг бясалгалынхаа төгс төгөлдөрт хүрэх болон Дээд Сүнсийг өөрийн зүрхэндээ бүр илүү харах гэж хийж байдаг. Гэхдээ чин бишрэлтэнгийн үйлдэл нь Дээд Бодьгалыг цэнгүүлэх гэсэн зөвхөн ганц л зорилгыг агуулж байдаг. Иймээс түүнд хувийн ямар ч ашиг сонирхлын санаа байдаггүй. Чин бишрэлтэн нь материаллаг үүргүүдээс үнэхээрийн ангид чөлөөтэй байдаг бөгөөд *санньяси* болон ид шидтэнгүүдээс ялгаатай нь гэвэл түүний хувьд ийнхүү ангид чөлөөтэй байхын тулд төдийлөн онцгой хүчин чармайлт гаргах хэрэггүй байдаг. *Санньясуудын* агуулдаг бурханлаг мэдлэгт болон иогчдын хүрдэг найман ид шидийн төгс төгөлдөрт хүрэх нь чин бишрэлтэнгүүдийн хувьд хялбархан байдаг. Гэхдээ, энэ явцдаа чин бишрэлтэн нь олз ашиг, хүндэтгэл өргөмжлөл эсвэл алдар нэрд тэмүүлдэггүй. Түүний хүсэж байдаг цорын ганц зүйл бол Бурханы трансценденталь албанд зүтгэх явдал байдаг бөгөөд энэхүү алба зүтгэлийн үрээр тэр бүхий л боломжит ач тусыг хүртдэг. Хүн дээдийн дээд ач тусыг хүртсэн бол өөр юуны тухай санаа зовох билээ дээ?

Патанжалын системийг даган баримталж байгаа ид шидэт-иогч бие махбодийн амьдралын үйл ажиллагаагаа зогсоон бясалгалын транст автан умбадаг. Өөрийн зүрхэндээ залран байгаа Дээд Сүнсийг харахын тулд тэрээр олон янзын зовлон бэрхшээлийг амсаж туулах болдог. Өөр үгээр хэлбэл, тэр өөрийн бясалгалын объект болох орчлонгийн юутай ч эгнэж зүйрлэшгүй, хосгүй Түүнд ямар ч үнээр хамаагүй хүрэхэд, тэр ч бүү хэл өөрийн амьдралыг хүртэл өргөл болгоход бэлэн байдаг. Бурханы Дээд Бодьгал Бхагавад Гитагийн (6.22)-г: ”Өөрийн зүрхэндээ залрах Дээд Сүнсэнд хүрсэнээр ид шидийн иогч энэхүү трансценденталь байдлаас илүү үнэ цэнэтэй юм байдаггүй гэдэгт итгэдэг. Ийм түвшинд хүрсэнээр хүн маш их аюул, гай тохиолдсон ч бачимдан сандардаггүй.” гэж айлдсан.

Патанжалын системээр бол ид шидийн *йога* гэж хувирамтгай болоод дур зоргоороо ухааныг эзэмдэн захирахыг хэлдэг. Трансценденталь түвшинд хүрнэ гэдэг нь материаллаг мэдрэхүйн үйл ажиллагаагаа зогсоон больж, төгс төгөлдөр бурханлаг ойлгоцын түвшинд дээшлэн очих гэсэн утгатай юм. Энэ түвшинд дээшлэн хүрсэнээр ид

шидэт иогч нь өөр юунд ч самуурч сатаарахаа больдог. *Анима* (жижгээс ч жижиг болох чадвар), *лагхима* (хөнгөнөөс ч хөнгөн болох чадвар), *пранти* (хүссэн зүйлдээ хүрэх чадвар), *ишита* (гаригуудыг бүтээж бий болгох чадвар), *вашита* (хэн бүхнийг өөрийн хүсэл санаандаа оруулан захирах чадвар) болон өөр бусад бүгд найман ид шидийн төгс төгөлдөр нь иогчийн ид шидийн дээдийн дээд түвшинд хүрэх зам мөр дээрээ хүртэн эзэмших зөвхөн дагалдах үр дүнгүүд юм. Ид шидийн олон иогчид нь эдгээр чадваруудын нэг эсвэл хоёрыг нь л хөгжүүлснээр ухааны тэнцвэртэй байдлаа алддаг. Ухаанаа тэнцвэртэй байлгалгүйгээр дээдийн дээд төгс төгөлдөрт хүрч Бурханы Дээд Бодьгалд цэвэр чин бишрэлтэй болох боломжгүй юм.

Чин бишрэлтэн нь Бурханы Дээд Бодьгалын трансценденталь албанд анхаарлаа хэдийнээ төвлөрүүлсэн байдаг учраас уналтанд өртөх иймэрхүү аюул занал түүнд учирдаггүй. Иймээс түүнд транс-д тусгайлан автаж умбах хэрэггүй байдаг. Мөнхөд шинэ сайхнаараа байх Бурханд дурлан татагдах чин бишрэлтэн ид шидийн төгс төгөлдөржилтөнд онцгой ач холбогдол өгдөггүй. Бурханы Дээд Бодьгалд үйлчлэн зүтгэж байгаа хүн ямар их жаргал цэнгэлтэй байдгийг материалист ухаан бодол бүхий хүн хэзээ ч ойлгож ухаардаггүй.

Ид шидийн иогч эсвэл *карма-йогч* нь бурханлаг үйл ажиллагааныхаа төгс төгөлдөрт хүрээгүй байсан ч энэ зам мөр дээр гаргасан тэдний хүчин чармайлт хий дэмий хоосон өнгөрч алдагддаггүй. Одоогоор зам мөр нь төгсгөлдөө хүрээгүй байгаа ч тэд дээд зорилгодоо заавал хүрнэ. Бүхий л материаллаг зүйлс, эд баялаг ч бай эсвэл мэдлэг чадвар ч бай ялгаагүй бие махбодийн үхэлтэй л цуг төгсгөл болдог. Харин *карма-йогчийн* бурханлаг үйл ажиллагаа нь материаллаг бие махбодь болон ухааны хүрээ хязгаарын чанадад оршдог бөгөөд трансценденталь сүнстэй холбогдсон байдаг. Энэ үйл ажиллагаа нь бурханлаг учраас материйн мөхөл сүйрэл түүнд хавьтаж шүргэдэггүй. Сүнс мөнхөд оршин байдагтай адилаар материаллаг бие махбодийн үхэлтэй ч хамт үл замхрах бурханлаг үйл ажиллагаа хэзээ ч хий хоосон, үр дүнгүй өнгөрдөггүй.

Бурханы Дээд Бодьгал энэхүү үнэнийг Бхагавад Гитагийн (6.40)-д батлан айлдсан. Энэ талаар Тхакур Бхактивинода дараахь байдлаар тайлбарласан байдаг: “Бүх хүмүүс хоёр ангилалд хуваагддаг. Эхний хэсэгт нь хууль дүрмийг дагаж мөрдөгчид, харин хоёр дахь хэсэгт нь тэрсүүд үзэлтэнгүүд харьяалагддаг. Тэрс үзэл бүхий хүн нь амьдралын ямар ч зарчмыг үл хүлээн зөвшөөрч, зөвхөн мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөө л ажиллаж байдаг. Ийм хүмүүс нь соёлын хувьд хөгжсөн ч байдаг, хоцрогдсон ч байдаг, боловсролтой ч байдаг, бичиг үсэгт тайлагдаагүй ч байдаг, мөн хүчтэй ч байдаг, сул дорой ч байдаг. Гэхдээ аль ч тохиолдолд байсан ялгаагүй тэдний үйл ажиллагаа нь адгуусан амьтадын үйл ажиллагаанаас илүү дээрдээд байх юмгүй. Эхлээд харахад тэд эрхэм сайн талтай мэт байж болох ч үнэн хэрэгтээ тэдэнд ямар ч тийм эрхэм сайн зүйл байдаггүй. Хууль журмыг сахигч хүмүүсийг дотор нь шудрага хөдөлмөрчин, имперсоналист философич болон Бурханы чин бишрэлтэнгүүд гэж гурав ангилдаг. Шудрагаар хөдөлмөрлөгчдийг цааш нь өөрсдийн ажил хөдөлмөрийн үр шимээр таашаал ханамж эдлэгчид болон ийм хүслээс ангид байгчид гэж мөн хоёр бүлэгт хуваадаг. Эхний бүлэгт хамаарагдагч хүмүүс нь цаг зуурын материаллаг аз жаргалд тэмүүлж байдаг бөгөөд өөрсдийн хөдөлмөрийн төлөө урамшуулал болгон материаллаг орчлонгийн хүрээн дотор газар дэлхийн эсвэл диваажингийн гаригуудын хаа нэгтэй энэхүү аз жаргалыг амсаж эдлэх боломжоор шагнагддаг. Гэхдээ иймэрхүү аз жаргал нь зуурдын байдаг гэдгийг үргэлж санаж байх хэрэгтэй. Ийм хүмүүс мөнхийн болоод бурханлаг жинхэнэ аз жаргалыг таньж мэдэж чаддаггүй. Материаллаг амьдралын боолчлолоос ангижирсан хүн л жинхэнэ бурханлаг аз жаргалд хүрдэг. Бурханлаг аз жаргалд хүрэхэд чиглэгдээгүй л бол ямар ч үйлийн үр дүн нь цаг зуурын болоод ямар ч ач тусгүй хий дэмий зүйл л байдаг.”

Хүний үйл ажиллагаа бурханлаг зорилгод хандаж чиглэсэн цагт л *карма-йога* гэж нэрлэгддэг. *Карма-йогын* зам мөрд орж замнаснаар хүн өөрийн амьдралаа аажим аажмаар

ариусган, бурханлаг мэдлэгийг хүртэн бясалгалын төгс төгөлдөрт хүрэх, төгсгөлд нь Бурханд трансценденталь хайр чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэх боломжийг хүртдэг. Материаллаг зорилгодоо хүрэхийн төлөө олон янзын хүнд хэцүү сорилт шалгалтуудыг туулан байгаа материалист-хөдөлмөрчинг хүмүүс заримдаа энэ бол *тапасви* (тэвчил үйлдэгч) эсвэл *махатма* (аугаа сүнс) гэж буруу ташаагаар ойлгож хүлээж авч байдаг. Гэхдээ материалистуудын амсаж туулж байгаа хүнд хэцүү тэвчлүүд нь эцсийн эцэст материаллаг мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө л чиглэгдэж байдаг учраас бурханлаг харьцаанд иймэрхүү тэвчил нь ямар ч тус нэмэргүй. Зарим демонууд, жишээлбэл Равана эсвэл Хираньякашипу нар мөн л хүнд хэцүү тэвчил үйлдсэн, гэсэн ч тэд мэдрэхүйдээ таашаал ханамж эдлүүлэх цаг зуурын зүйлсээс өөр юунд ч хүрээгүй. Иймд, бурханлаг зорилгод хүрэх зам мөрөөр замнан байгаа хүн буюу *карма-йогч* гэж зөвхөн, хязгаарлагдмал мэдрэхүйн таашаал ханамж эдлэх түвшингийн чанадад дээшлэн гарсан хүнийг л хэлдэг.

Карма-йогын зам мөрөөр замнаж байгаа хүн энэ замдаа ороод удаагүй байсан ч жинхэнэ ач тусыг хүртдэг. Тэрээр амьдралаас амьдралд бурханлаг төгс төгөлдөржилтөө үргэлжлүүлдэг бөгөөд энэ тухай Бхагавад Гитагийн (6.43)-д өгүүлсэнчлэн: “Таашаал ханамжийг ихээр эдлэн байсан ч дараагийн амьдралуудынхаа аль нэгэнд нь *карма-йогч* алба зүтгэлийн бурханлаг оюун санааг өөртөө дахин мэдэрдэг бөгөөд ийм алба зүтгэлд жам ёсоороо дурлан татагдахын хүчээр бурханлаг үйл ажиллагааныхаа төгс төгөлдөрт хүрэх зам мөрөө үргэлжлүүлэхийг чармайн зүтгэдэг.”

Трансценденталист нь ямар нэгэн учир шалтгаанаар өөрийгөө төгөлдөржүүлэхүйн зам мөрөөс хазайн гажсан байсан ч өөрийн бурханлаг хөгжлөө цааш үргэлжлүүлэх боломж түүнд дахин олгогддог. Бхагавад Гитагийн (6.41)-д батлан өгүүлсэнчлэн, ийм хүн дараагийн амьдралдаа жинхэнэ *брахманы* эсвэл Бурханд үйлчлэн зүтгэхэд өөрийгөө зориулан байгаа баян худалдаачны гэр бүлд төрдөг.

Гэхдээ, Бхагавад Гитагийн (6.47)-д батлан өгүүлсэнчлэн, *бхакти-йогчид* нь Бурханы тухай санаа бодолд үргэлж автаж байдаг болон Түүний чин бишрэл дүүрэн бялхах албанд цуцалтгүйгээр зүтгэж байдаг учраас *карма-йогч*, *гьяна-йогч*, *хатха-йогч* болон *бхакти-йогч* зэрэг бүхий л трансценденталистуудаас чухамдаа *бхакти-йогч* л хамгийн эрхэм дээд нь байдаг билээ.

Бүхий л хэлбэрийн ид шидийн иогчдын эцсийн зорилго нь Бурханы Дээд Бодьгалын трансценденталь хайрын алба байдаг гэдэг нь бүрэн тодорхой, илт зүйл. Бхагавад Гитагийн энэ шүлэг ийм л утгатай. Мөн үүнтэй адилаар Тхакур Бхактивинода: “Бурханы албанд хайр дүүрэн зүтгэж байгаа хүн бол дээдийн дээд иогч.” гэж өгүүлсэн байдаг. Бурханы Дээд Бодьгалыг бялхан дүүрэн хайраар хайрлан Түүнд чин бишрэлтэйгээр, бие хайрлалгүйгээр зүтгэж байгаа хүнийг бүх ид шидтэнгүүдээс хамгийн аугаа нь гэж үзэх хэрэгтэй, харин материаллаг үр шимийг хүртэхийн тулд л тэвчил үйлдэж буй хүнийг иогч буюу ид шидтэн гэж нэрлэх аргагүй. Мөн өөрсдийн чармайлт зүтгэлийнхээ үр шимээр таашаал ханамж эдлэх хүслээс ангид байгаа хүнийг ухаан бодлын-философичид, найман ид шидийн төгс төгөлдөрт хүрч байгаа ид шидтэнгүүд мөн төгсгөлд нь Бурханы Дээд Бодьгалын трансценденталь хайр дүүрэн бялхах албанд зүтгэж байгаа чин бишрэлтэнгийн адилаар хүндэтгэвэл зохистой.

Үнэн хэрэгтээ, ид шидийн *йогын* зам мөр нь хэн бүхний хувьд нэг л байдаг. Энэ нь дээд зорилгод хүргэдэг шаттай адил төстэй юм. Түүгээр өгссөнөөр хүн бурханлаг төгс төгөлдөрт хүрдэг. *Карма-йога* буюу бурханлаг үр дагавар аврагч үйл ажиллагааг энэ шатны эхний үетэй адилтгахуйц. Философийн эрэл хайгуул хийхийг сонирхсоноор болон ертөнцөөс огоорохуй хүслийг өөртөө хөгжүүлснээр хүн хоёр дугаар үе буюу *гьяна-йогын* түвшинд хүрч болдог. Дээд засаглал болох Бүхний Дээд Бурханы талаар тодорхой ойлголт төсөөлөлтэй болсон цагтаа хүн Бурханыг өөрийн зүрхэндээ мэдрэхийг оролдож чармайдаг ба ингэснээрээ гурав дугаар үед буюу *дхьяна-йогын* түвшинд хүрдэг. Төгсгөлд

нь Бурханы Дээд Бодьгалын трансценденталь албанд өөрийгөө хайр дүүрэн зориулснаар хүн дээдийн дээд түвшин *бхакти-йогын* зам мөрд орж бүрэн төгс төгөлдөрт хүрдэг. Иймд, жинхэнэ ид шидийн зам мөр нь энэ бүх үе шатуудыг өөртөө багтаах бурханлаг хөгжлийн шаталсан үйл явц юм. *Йогын* шатны хамгийн дээд үе, түвшинг ойлгох болон үнэлэхийн тулд түүний бусад үеүдийн талаар мэдэж байх нь чухал. Хүн дээдийн дээд зорилгодоо хүрэхийг хүсэж байвал бурханлаг хөгжил дэвшлийн шаталсан зам мөрөөр орон замнаж болно.

Гэхдээ энэ үедээ нэг дэх, хоёр дахь эсвэл гурав дахь үе шатандаа зогсон үлдэж болохгүй, цаашаа *йогын* эцсийн, хамгийн дээд түвшинд хүртэл яван Бурханы Дээд Бодьгалын трансценденталь албанд өөрийгөө хайр дүүрэн зориулах хэрэгтэй. Завсрын үе шатуудын аль нэгэнд зогсон үлдэж, хүрсэн түвшиндээ хангалуун болж цааш үл явах хүн өөрийн хүрсэн байр сууринаасаа хамааран *карма-йогч*, *гьяна-йогч* эсвэл *дхьяна-йогч* гэж нэрлэгддэг. Энэ бол янз бүрийн иогчдыг өөр өөрөөр нэрлэдгийн цорын ганц учир шалтгаан юм. Иймд, ид шидийн зам мөр нь нэг боловч зөвхөн Бурханы эрхэм дээд чин бишрэлтэн л энэ зам мөрийн эцсийн зорилгодоо хүрдэг учраас түүнийг бүхий л ид шидтэнгүүдээс буюу иогчдоос хамгийн аугаа нь гэж үздэг.

Мөн тэрчлэн, ид шидийн трансценденталь зам мөр дээрх хөгжил дэвшил нь материаллаг хүрээний ямар нэгэн салбарт хүрсэн боловсронгуй дээд түвшингээс ялгаатай гэдгийг тэмдэглэж хэлэх нь зүйтэй. Материаллаг ертөнцөд, илүү дээд түвшинд дээшлэн хүрэх эрхтэй болохын тулд хөгжлийн зохих урьдчилсан үе шатуудыг туулах хэрэгтэй байдаг. Үүнээс өөр арга зам, сонголт гэж байдаггүй. Жишээ нь, эрдмийн зэрэг цол хүртэхийн тулд хүн эхлээд сургалтын тодорхой үе шатуудыг дамжин олон тооны шалгалтуудыг өгөх хэрэгтэй байдаг. Өөр арга зам байдаггүй. Сургалтанд хамрагдалгүйгээр болон шаардлагатай шалгалт шүүлгүүдийг өгөлгүйгээр эрдмийн зэрэг цолыг хэн ч авдаггүй. Харин бурханлаг амьдралд, хэдийгээр хүмүүсийг ид шидийн зам мөрөөр замнан хамгийн доод үеэс эхлэн аажим аажмаар өгсөн хамгийн дээд түвшинд хүрэхэд нь туслах эх сурвалж дүрэм журмууд байдаг ч, Бурханы өршөөл нигүүлслээр сургалтын урьдчилсан үе шатуудыг дамжилгүйгээр трансценденталь “эрдмийн зэрэг”-ийг авч болдог. Гэхдээ ийм онцгой өршөөл нигүүлслийг Бурхантай маш ойр дотно харьцах хүн л хүртдэг. Зөвхөн, Бурханы чин бишрэлтэнгүүдтэй бурханлаг харьцаа холбоо тогтоосны ачаар л Түүнтэй ийм ойр дотно харьцаж болдог.

Сүнс бүр Бурханы Дээд Бодьгалтай эвдэршгүй, мөнхийн болоод эрхэм нандин харьцаатай байдаг. Гэхдээ материаллаг эрчимтэй шүргэлцэн зууралдсанаас болж хий хуурмагт удаан хугацаагаар байсны улмаас бид энэхүү харьцаагаа аль эртнээс мартсан байдаг. Бид үнэн хэрэгтээ хамгийн баян эцэг-Бүхний Дээд Бурханы хүүхдүүд мөн боловч одоо бол орон гэргүй тэнүүлчинтэй адил төстэй болжээ. Эрүүл ухаанаар сайн бодож үзвэл бид энэхүү үнэнийг тодорхой ойлгож чадахсан. Бид бүгдээрээ өөрсдийн онцгой баян Эцэг болон Түүнтэй холбогдсон харьцаагаа дурсан санахгүй байхыг л эрхэмлэцгээдэг. Үүнийхээ оронд бид, хэн нэгэн хэрмэл тэнүүлчин адилаар өөрсдийгөө нөмрөн байгаа өлсгөлөн гуйланчлалын асуудлуудаа л шийдвэрлэхийг янз бүрээр хичээн оролдож байдаг, гэсэн ч мэдрэгдэхүйц үр дүнд үл хүрнэ. Гудамжинд ч өөрсөдтэйгөө адил гуйлгачин шиг найз нөхөдтэйгөө л уулзалдана. Заримдаа биднээс ямар нэгэн зүйлээр илүү хэн нэг нь илүү төгс төгөлдөр амьдралд хүргэх замыг заана. Тэдний заасан замыг дагасан ч бид аз жаргалыг тэртэй тэргүй олдоггүй. Ийм хүмүүс биднийг материаллаг үйл ажиллагааны, мэдлэгийн, бясалгалын, ид шидэт *йогын* болон өөр бусад олон замаар замнахыг уриалж байдаг ч харамсалтай нь тэдний хэн нь ч бидний тэмүүлэн байгаа аз жаргалыг өгч чаддаггүй. Ийм учраас Бурхан Чайтанья Рупа Госвамитай Дашашвамедха-гхата-гийн ойролцоо Ганга мөрний эрэг дээрх Праягад уулзахдаа, чин бишрэлийн алба зүтгэлийн үрийг Бүхний Дээд Бурханы болон Түүний жинхэнэ элч төлөөлөгчийн өршөөл нигүүлслийг хүртэх аугаа зол завшаан тохиосон зөвхөн тэр сүнс л хүртдэг гэж айлдсан.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришнагийн бурханлаг илгээлт Бхагавад Гитаг үзэж судалснаар бид бүхэн трансценденталь чин бишрэл дүүрэн бялхах алба зүтгэлийн үр хөврөлийг хүртэж чадна. Зөвхөн тэр цагт л Бхагавад Гитад агуулагдах (Түүний чин бишрэлийн албанд өөрийгөө зориулах ёстой гэсэн) Шри Кришнагийн сургаалын учир утгыг ойлгож ухаарах болно. Зөвхөн тэгсэн цагт л Түүний аугаа илгээлтийн жинхэнэ үнэ цэнэ бидэнд нээгдэх болно. Хэрэвзээ тэгээгүй л бол, Бхагавад Гитаг амьдралаас амьдралд уншин, түүнд бүтэн боть ботиор нь тайлбар бичсэн байсан ч энэ бүгд нь ямар ч хэрэггүй хий дэмий хоосон зүйл болно.

Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Бхагавад Гитад Өөрөө Өөрийнхөө талаар айлддаг. Өөрийнхөө намтар түүхийг бичдэг маш олон тооны эгэл хүмүүс байдаг ба бусад нь тэдгээрийг таатайгаар уншин тэнд бичигдсэн бүхэнтэй санал нэгдэж байдаг боловч Бурханы Дээд Бодьгал Шри Кришна Өөрийнхөө талаар Өөрөө айлдахад нь хүмүүс Түүний илгээлтийг, тэр айлдсан төрх байдлаар нь хүлээж авахыг шамддаггүй. Үүнд л тэдний гай гамшиг оршдог. Тэд Бхагавад Гитагийн энгийн үгүүдээс хаа ч байхгүй ямар нэгэн утга санааг мушгин гаргаж ирэхийг хичээн чармайж байдаг бөгөөд ийм замаар л тэд үнэн хэрэгтээ Бхагавад Гитагийн хаана ч байхгүй өөрсдийн бодож олсон санаагаа батлахыг оролддог. Эцсийн эцэст, хүмүүс өөрсдийн дэмий балай онолуудаа баталж чаддаггүй бөгөөд тэгсэн цагтаа тэд Бурханы байр сууринд хэн нэгэн тэнэг мунхагийг сонгосноор энэхүү байдлаа өмгөөлөн хамгаалахыг оролдож байдаг.

Шри Кришна бол Бүхний Дээд Бурхан Өөрөө юм гэдгийг Бхагавад Гитад итгэлтэйгээр батлан харуулдаг. Түүнээс гадна, бидний цорын ганц үүрэг бол Кришнад трансценденталь хайраар үйлчлэн зүтгэх явдал гэж өгүүлсэн байдаг. Бхагавад Гитаг уншаад энэхүү хоёр үнэнийг ойлгож ухаарсан цагт бид бурханлаг амьдралдаа эхний алхамуудаа хийж чадах болно.